

# Лиахоно

## Авралын ажлын нэгдмэл байдал, 14-р хуудас

Сэтгэл санааны хямралаас  
би юу сурсан бэ , 26-р хуудас  
Даруу байдлын 3 адислал,  
36-р хуудас

Өсвөр үеийнхний гэр бүлийн  
түүхийн ажлыг хийж буй  
5 арга зам, 58-р хуудас



*“Хэн арван хуруу  
тэгш эхнэр олж  
чадах вэ? Тийм  
эхнэр эрдэнэсээс  
ч үнэтэй.”*

Сургаалт үгс 31:10



## ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Итгэлийн залбирал  
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Амийн талх

## ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 14** Номлогчийн ажил, гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажил  
Ахлагч Дэвид А.Бэднар  
*Сайн мэдээг номлох болон нас барагсдаа аврах ажлууд нь хоорондоо нягт холбоотой.*

- 20** Гэр орон: бол суралцах амин чухал газар юм  
*Гэртээ суралцсан зүйлс нь амьдралын минь туршид болон мөнхөд бидэнтэй хамт үлдэнэ.*

- 26** Усны мандал дээр  
Жон Варнэр  
*Гутрал, хямралын давалгаа намайг нөмөрсөн мэт санагдаж байсан ч Бурхан намайг жिवүүлэлгүй, амлалтын нутаг руу удирдаж байлаа.*

- 28** Газар бүрийн анхдагчид: Чили дэх хөрвөлт ба өөрчлөлт  
Нэстор Курбэло  
*Өнөөдөр бараг 30 чили хүн тутмын нэг нь сүмийн гишүүн байна.*

- 36** Даруу байдлыг сонгох зориг  
Кэрл Ф. Макконки  
*Даруу байдлын сургаал ба адислалууд юу вэ?*

## АЛБАД

- 8** Сүмд үйлчлэх нь: Баярлалаа, Жэй ах аа  
Кристин Пурсэлл
- 9** Хуучин Гэрээний бошиглогчид: Иеремиа
- 10** Бид Христийн тухай ярьж байна: Хаш чулуун байцаа  
Эллэн С.Жэнсэн
- 12** Бидний гэр орон, бидний гэр бүл: Лизочкагийн зүрх  
Марина Петрова
- 40** Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80** Биднийг дахин уулзтал: Мэхлэлт  
Ахлагч М. Рассэлл Баллард  
*Сатан уургаар загасчилдаг загасчинтай адил биднийг барихын тулд хиймэл өгөөш ашигладаг.*

### ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Гэрэл зургийг Лэсли Нилссон.  
Хавтасны дотор талд: Гэрэл зургийг Мэттью Рэйэр.



**44 Итгэдэг зүйлийнхээ төлөө зогсох нь**

*Залуучууд итгэл үнэмшилээ хэрхэн зоригтой хамгаалдаг талаараа хуваалцаж байна.*

**48 Сайн мэдээ миний амьдралд: Хоорондоо нягт холбоотой миний гэрчлэл**

Айви Ноче

*Мормоны Номын талаар гэрчлэлгүй байх нь намайг сүм дэх итгэл үнэмшилдээ эргэлзэхэд хүргэсэн юм.*



*Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Зөвлөгөө: Үйлчлэл хийхэд хамгийн тохиромжтой цаг хэзээ вэ?*



**50 Чөлөөт сонголт уу эсвэл ёс суртахууны сонгох эрх үү?**

Майкл Р.Моррис

*Найз маань өөрийгөө номлогчийн үйлчлэлд тэнцэхээргүй болгосон. Би номлолыг сонгох эрх чөлөөтэй байх болов уу?*

**52 Асуулт, хариултууд**

*“Би бодол санаагаа хянахыг хичээсээр байгаа ч маш олон уруу таталттай тулгардаг. Би хэрхэн илүү цэвэр ариун бодолтой байж чадах вэ?”*

**54 Хэрхэн утга учиртай асуултууд асуух вэ**

Дэвид А.Эдвардс

**57 Хүч чадал ба амжилтыг хэрхэн олох вэ**

Ахлагч Жэффри Р.Холланд

*Бид Есүс Христийг дагаснаар аюулгүй байдал, амжилт, аз жаргалыг олж авч чадна.*

**58 Гэр бүлийн түүх—Би үүнийг хийж байгаа**

*Эдгээр өсвөр үеийнхэн гэр бүлийн түүхийн ажлыг хийснээр төсөөлж байгаагүй адислалуудыг олжээ.*

**61 Зурагт хуудас: Тэднийг таньж мэд бас өөрийгөө ч таньж мэд**

**62 Миний номлолд тулгарсан эсэргүүцэл**

Алсэнир де Суза

**64 Биднийг юу хүлээж байгааг илүү сайн ойлгох нь**

Катрин Апэлсэт-Аанэнсен

*Бүрэн цагийн номлогчийн амьдрал өөр байдаг. Норвегийн Осло дахь өсвөр үеийнхэн уг өөрчлөлтөд бэлтгэж, нэг өдрийг өнгөрөөв.*



**66 Дараа үйлчлэхийн тулд одоо үйлчлэх нь**

Мичи Барбоса

*Мормон яагаад найзуудтайгаа хөл бөмбөг тоглохын оронд сүм цэвэрлэхийг сонгосон юм бол?*

**68 Матилдэ залуу эмэгтэйчүүдийн бүлэгт орохоор бэлтгэсэн нь**

Жэн Вилкс

**70 Дуу хөгжим: Бидний гэрэлтэх цаг**

Жан Пинбороу, Жэнис Кэпп Пэрри

**71 Онцгой гэрч: Би гэр бүлийн түүхийн ажилд хэрхэн тусалж чадах вэ?**

Ахлагч Квинтин Л. Күк

**72 Хүүхдийн хэсгийг гэртээ авчрах нь: “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” нь миний гэр бүлд туслахаар Бурханаас ирсэн юм.**

Эрин Сандэрсон, Жин Бингам нар

**74 Дэлхий даяар найзуудтай болох нь: Би Чилийн Барбара байна**

Эми Жэйн Лэвитт

**76 Бидний хуудас**

**77 Дээшээ хар**

Ахлагч Адриан Очоа

*Бид бороонд төөрч, морьд маань алдуураад явчихсан байв.*

**78 Бага насны хүүхдүүдэд зориулав: Гэр бүлийн баг**

Шэрали Харди

**2014 ОНЫ 10-Р САРЫН ДУГААР 15 НО. 5  
ЛИАХОНА 10990 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн  
Сүмийн олон улсын сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,  
Дийтр Ф.Угдорф

**Арванхоёр Төлөөлөгчийн чуулга:** Боид К.Пакэр,  
Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,  
М.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хэйлс,  
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук,  
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

**Эрхлэгч:** Крэйг А.Кардон

**Зөвлөхүүд:** Мэрвин Б.Арнолд, Кристоффэл Гуолдэн,  
Ларри Р.Лоурэнс, Жэймс Б.Мартино, Иосеф В.Ситати

**Удирдах захирал:** Дэвид Т.Варнэр

**Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:**  
Винсэнт А.Ваун

**Сүмийн сэтгүүлийн захирал:** Алан Р.Лоиборг

**Бизнесийн менежер:** Гарфф Каннон

**Гүйцэтгэх редактор:** Р.Вал Жонсон

**Гүйцэтгэх захирлын туслах:** Раян Карр

**Хэвлэлийн туслах:** Лиза С.Лопэз

**Редакцийн баг:** Бриттани Бийти, Дэвид Диксон, Дэвид  
А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гаррэт  
Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Минди Аннэ Лийвигт, Майкл  
Р.Моррис, Салли Жонсон Одажэрк, Жошуа Ж.Пэркий, Жан  
Пинбороу, Ричард М.Ромни, Пол Вандэнбэрг, Марисса  
Виддисон

**Зураглал чимэглэлийн удирдагч менежер:**

Ж.Скотт Кнудсэн

**Зураглал чимэглэлийн удирдагч:** Тэдд Р.Петрсон

**Уран бүтээлийн ажилтнууд:** Жанэтт Эндрьюс, Фэй  
П.Андрус, Мэндэл М.Бэнгли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,  
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан  
Лофгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брэд Тизери,  
П.Никол Вокэнорст

**Оюуны өмчийн зохицуулагч:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэлийн захирал:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэх баг:** Кэвин К.Банкс, Конни Бюгторп Бриж, Жүүли  
Бурдэтт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,  
Гэйл Тэйт Раффэрти

**Хэвлэлийн захирал:** Крэйг К.Сэдвик

**Хуваарилалт хариуцсан захирал:** Эван Ларсэн, Нэгдсэн  
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн  
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,  
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт**  
liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,  
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA  
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар  
ирүүлнэ үү.

*Лиэхона* нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"  
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,  
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,  
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,  
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,  
свахили, самоа, себуано, солонгос, тагалоог, тай, тахити,  
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,  
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр  
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр  
байна.)

© 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

*Лиэхона* дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой  
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт  
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг  
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран олшруулж  
болдохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual  
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:  
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

**For Readers in the United States and Canada:**

October 2014 Vol. 15 No. 5. LIAHONA (USPS 311-480)  
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year  
(January, April, June, July, October, and December) by  
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North  
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is  
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals  
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required  
for change of address. Include address label from a recent issue;  
old and new address must be included. Send USA and Canadian  
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.  
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders  
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.  
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)  
POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).  
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes  
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,  
Salt Lake City, UT 84126-0368, USA.

# Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглах өгүүлэл, үйл ажиллагаанууд орсон байгаа.  
Дор хоёр жишээ өгөв.



**"Гэр бүлийн түүх—Би үүнийг хийж байгаа,"** 58-р хуудас: Өдрийн тэмдэглэл хөтлөх үйл ажиллагаа зохио! Амьдралынхаа талаар ямар нэг зүйлийг тэмдэглэхэд нь гэр бүлийн гишүүдээ урамшуулан дэмж. Энэ нь олон жилийн өмнөх дурсамж эсвэл тухайн өдөр тэдэнд тохиолдсон зүйл байж болно. Тэмдэглэл хөтлөх олон арга зам байдгийг ойлгоход нь гэр бүлийнхэндээ туслаарай. Тэд тэмдэглэл бичиж, компьютер дээр шивж эсвэл зурж болно эсвэл тэд өөрсдөө түүхээ яриад дуу хураагчид бичиж болно. Тэмдэглэлээ үргэлжлүүлэн, ойр ойрхон хөтөлж байхад нь гэр бүлийнхнээ урамшуулан дэмжээрэй.

**"Биднийг юу хүлээж байгааг илүү сайн ойлгох нь,"** 64-р хуудас: Норвегийн нэгэн тойргийнхны хийсэнтэй адил номлолд бэлтгэх үйл ажиллагаа зохион байгуулах талаар бодож үзнэ үү. Та тэдний заасантай адил зүйлүүдийг—сайн мэдээтэй холбоотой яриаг хэрхэн эхлэхийг юм уу цагаан цамц хэрхэн индүүдэхийг зааж болно эсвэл гэр бүлийнхэнд чинь номлолын талбарт хэрэг болно гэж бодсон чадварууд дээр анхаарал төвлөрүүлж болно.

## ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

*Лиэхона* болон сүмийн бусад материалыг [languages.lds.org](http://languages.lds.org) вэбсайтаас олон хэлээр үзэх боломжтой.

## ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

*Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.*

**Авралын ажил,** 14, 20,  
54, 58, 62, 64  
**Ариун сүмийн ажил,**  
14, 58  
**Ач ивээл,** 10  
**Гэр бүл,** 12, 20, 61, 72, 78  
**Гэр бүлийн түүх,** 14,  
58, 71  
**Гэрчлэл,** 48  
**Даруу байдал,** 36  
**Дуудлагууд,** 8

**Есүс Христ,** 7, 57  
**Заасан зүйл,** 20, 36, 54  
**Залбирал,** 4, 40  
**Залуу эмэгтэйчүүд,** 68  
**Иеремиа,** 9  
**Итгэл,** 4, 26  
**Мацаг барих нь,** 4  
**Мормоны Ном,** 48  
**Номлогчийн ажил,** 14,  
28, 62, 64  
**Сонгох эрх,** 50

**Сорилтууд,** 12, 26, 62  
**Сул дорой байдал,** 10  
**Сэтгэлийн хямрал,** 26, 42  
**Сүмийн түүх,** 28  
**Уруу таталтыг даван  
туулах нь,** 43, 44, 52, 80  
**Үйлчлэл,** 8, 66  
**Хайр,** 8, 41  
**Цагаатгал,** 10, 80  
**Чили,** 28, 74



**Ерөнхийлөгч  
Хэнри Б.Айринг**

Тэргүүн Зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх

# ИТГЭЛИЙН ЗАЛБИРАЛ

**З**албирал нь бидний Бурханд хандан хэлдэг үгсээс ч илүү чухал зүйл юм. Энэ нь Бурхан болон Түүний хүүхдүүдийн хоорондын хоёр талт харилцаа мөн.

Бид зохих ёсоор залбирсан үедээ зүрх сэтгэлийнхээ мэдрэмжийг энгийн үгсээр илэрхийлдэг. Тэнгэрлэг Эцэг ерөнхийдөө бидний оюун санаанд мэдрэмж төдийгүй бодол төрүүлэх замаар хариулдаг. Бид Түүнээс ямар ч хариулт авсан, энэ нь хэзээ ч ирсэн бай, Түүнд дуулгавартай байхыг амласан чин сэтгэлийн залбирлыг маань Тэр үргэлж сонсдог.

Мормоны Номыг уншиж, үүний талаар залбирдаг бүх хүнд Их Эзэн:

“Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулъя би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно.

“Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” (Моронай 10:4–5) гэсэн амлалтыг өгдөг.

Энэхүү амлалт баттай юм. Сая сая хүн амьдралыг нь баяр баясал, мөнхийн аз жаргалаар дүүргэсэн адислал хүлээн авснаар залбирлын тухай энэхүү гайхалтай амлалтыг биеэр эдэлж, нотолсон юм. Тэрхүү амлалт нь бидний төлөөх Бурханы оюун ухаан, тааллыг мэдэх

гэсэн бидний бүх залбиралд хамаатай байдаг. Бидэнд удирдамж өгөх эрх мэдэл бүхий Бурханы үйлчлэгчээс зөвлөгөө авах бүрдээ бид үүнийг хэрэгжүүлж чадна. Жишээ нь, бид Ерөнхий чуулганы үгсийг сонсоод тэдгээрт найдаж болно. Бид амьд бошиглогчдоор дамжуулан Бурханаар дуудагдсан даруухан номлогчдоор заалгах үедээ үүнийг хэрэгжүүлж болно. Мөн энэ нь бидний бишопоосоо эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө авдаг зөвлөгөө ч байж болно.

Залбирлыг амьдралдаа хэрэгжүүлэх дүрмүүд нь энгийн юм. Бид Есүс Христийн нэрээр Эцэгт хандан залбирч, чухам юу үнэн болохыг мэдэхийн тулд асуух ёстой. Бид чин сэтгэлээсээ асуух нь зүйтэй бөгөөд Бурхан үнд хариулахдаа биднээс шаардах юуг ч боловхийх болно гэсэн шударга хүсэлтэй байх ёстой. Мөн бидний чин хүсэл нь Есүс Христэд итгэх итгэлээс маань гарах ёстой.

Мормоны Номыг уншдаг сонирхогч баптисм хүртэж, гишүүнээр батлагдахаасаа өмнө уг ном нь үнэн бөгөөд Иосеф Смит үүнийг Бурханы хүчээр орчуулсан гэсэн гэрчлэлийг хүлээн авч болно. Бид сүмийн гишүүнээр батлагдсаныхаа дараа Ариун Сүнсний нөхөрлөлтэй хамт байж, энэ нь бидэнд бусад үнэнийг баталдаг. Тэгээд бид итгэлтэй залбирах бүрдээ Ариун Сүнс бидэнд Есүс бол Христ, Бурхан Эцэг амьд бөгөөд Тэд бидэнд болон Тэнгэрлэг



хамгийн багаар хоёр хоолны үнэтэй тэнцэх мацгийн өргөлийг бишоптоо юм уу салбарын ерөнхийлөгчдөө өгдөг. Бидний бодол санаа, залбирал Аврагч руу болон сүнслэг ба материаллаг хэрэгцээг нь хангах замаар үйлчлээсэй хэмээн Түүний хүсэж буй тэр хүмүүс рүү чиглэдэг.

Бид илүү хүлцэнгүй, заалгахад хялбар бөгөөд хайраар дүүрэн болохын тулд мацаг барьснаар бидний залбирал ба хүсэл Аврагчийнхтай илүү адилхан болдог. Мөн Түүнтэй адил бид Эцэгийн бидний талаарх хүслийг мэдэж мөн хийхийн төлөө залбирдаг. ■

Эцэгийн бүх хүүхдэд хайртайг гэрчилнэ хэмээн найдаж болно.

Энэ бол Ариун Сүнс бидэнд Есүс бол Христ гэдгийг гэрчлэх үед бид зүрх сэтгэлдээ энэрэлтэй байх болно гэсэн амлалт Мормоны Номонд байдгийн нэг шалтгаан нь юм. “Хэрэв хүмүүн хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон, мөн Ариун Сүнсний хүчээр Есүс бол Христ гэдгийг хүлээн зөвшөөрдөг аваас, түүнд энэрэл байх нь гарцаагүй” (Моронай 7:44).

Мацгийн ням гараг бүр нь сүнс­лэгээр өсөж хөгжих агуу боломж юм. Мацгийн ням гараг нь бидэнд мөнхийн үнэнийг мэдэхийн тулд залбирч, мацаг барихад мөн ингэс­нээрээ лэмэнчүүдэд хүч, эрх мэдэл, хайраар заах боломжтой байсан Мозаягийн хөвгүүдийн болон Ал­магийн туршлагыг ойлгоход тусалж чадна (Алма 17:3, 9-ийг үзнэ үү).

Бид мацгийн ням гарагт залби­ран, мацаг барьдаг. Ядуусыг адис­лахын тулд бид идэхээс татгалзсан

### ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

**З**албирах ба мацаг барих нь бидэнд “мөнхийн үнэнийг мэдэхэд” тусалж чадна хэмээн ерөнхийлөгч Айринг заасан билээ. Та айлчлан очих хүмүү­сийнхээ гэрчлэлийн аль хэсэг нь хүчирхэгжих хэрэгтэйг бо­дож үзээд тэр сэдвээр хичээлээ бэлтгэ. Жишээ нь, хэрэв таны айлчилж очих хүн дотны найзаа эсвэл гэр бүлийн гишүүнээ алдсан бол мөнхийн гэр бүлүүд ба үхлийн дараах амьдралын тухай ярилцах талаар бодож үзээрэй. Тэр зарчмын талаар гэрчлэлтэй болоход нь тус­лахын тулд та айлчлан очдог хүмүүстээ хамт мацаг барих санал тавьж болно.

## Залбирахаасаа өмнө бэлд

**Е**рөнхийлөгч Айринг залбирал нь “Бурхан болон Түүний хүүхдүүдийн хоорондын хоёр талт харилцаа юм” гэдгийг бидэнд сануулсан. Залбирахад бэлтгэхийн тулд цаг гаргах нь тэрхүү хоёр талт харилцааг боломжтой болгодог. Та өдөр бүр залбирахад хэдэн минут бэлтгэхийн тулд тэмдэглэлээ ашиглаж болно. Мөн Тэнгэрлэг Эцэгт ямар адислалуудынхаа төлөө талархахыг хүсч байгаагаа жагсаан бичиж, залбирал хэрэгтэй байгаа хүмүүсийн болон хариулт авах хэрэгтэй асуултуудынхаа жагсаалтыг гаргаж болно.



Тэгээд сүмийн дуулал дуулж эсвэл судрын хэдэн шүлэг уншиж, Сүнсийг урь. Залбирах үедээ Ариун Сүнс таны юу хэлэх ёстойг хэрхэн удирдаж байгаад мөн мэдрэмждээ болон бодол санаандаа анхаарал хандуул (С ба Г 8:2–3-ыг үзнэ үү). Туршлагаа тэмдэглэлдээ бичих болон хүлээн авсан хариултаудаа эргэн харах талаар бодож үзээрэй. Мөн та залбиралдаа дүгнэлт өгч, Ариун Сүнсийг таньж сурахын тулд *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж*-ийн 95–97-р хуудсан дахь үйл ажиллагааг ашиглаж болно.


## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Залбирлын сэндвич

**Т**а нар залбирах үедээ юу хэлэхээ хэрхэн мэддэг вэ? Та нар “Хүндэт Тэнгэрлэг Эцэг минь” гэж залбирлаа эхлээд “Есүс Христийн нэрээр, амен” гэж хэлэн төгсгөж болно. Сэндвич хийхдээ юу юу оруулахаа сонгодогтой яг адилаар залбирлын дунд үед юу хэлэх нь та нарын сонголт юм.

Сэндвич хийхэд орох зүйлсээ сонго. Залбиралдаа оруулахыг хүсэж буй зүйлсээ түүний хажууд бич. Та нар адислалуудынхаа төлөө “баярлалаа” гэж хэлж, санаа зовдог зүйлүүдээ ярин, хүсэх адислалынхаа талаар эсвэл асуух асуултуудынхаа талаар залбирч болно.

Та нар энэ сэндвичийг хувааж болно эсвэл өөр сэндвич хийж болно. Залбирахдаа хэлэх зүйлсээ санаж байхын тулд үүнийгээ гэртээ нэг газарт өлгөөрэй.



Хайрт Тэнгэрлэг Эцэг минь ээ,

---



---



---



---



---



---

Есүс Христийн нэрээр, амен.



Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэж авахаар эрэлхийл. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж, айлчлагч багшилалтаар дамжуулан хариуцлага хүлээдэг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org)-өөс үзнэ үү.

## Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Амийн талх

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Есүс “Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна” (Иохан 6:51) хэмээн хэлсэн билээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон “Бид тухайн өдрийн шаардлагатай тусламж, хоол хүнс буюу өдөр тутмын талхныхаа төлөө Бурханд найдлага тавьдаг байх ёстойг Есүс Өөрийн шавь нар болох бидэнд сургасан юм” хэмээн хэлжээ. “Их Эзэний урилга нь хүүхдүүдийнхээ өдөр тутмын өчүүхэн хэрэгцээ бүрийг сайн мэдэж, тэдэнд нэг бүрчлэн туслах энгүй их хүсэлтэй, хайраар бялхам Бурханд ойртох урилга юм. Тэрбээр ‘Бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч’ Түүнээс бид итгэлээр гуйвал ‘түүнд өгөгдөх болно’ (Иаков 1:5)” хэмээн хэлсэн билээ.<sup>1</sup> Есүс Христ бидний хэрэгцээг хангана гэдгийг ойлгосноор



бид сүнслэг тэжээлийнхээ төлөө Түүнд хандах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд биднийг “амийн талхыг авахыг хүссэн Христийн анхны шавь нарын адал явдалтай, эсвээс буцаж явалгүй харин Түүнд ирж, Түүнтэй хамт үлдэж, өөрсдийн аюулгүй байдал ба авралыг олохын тулд очиж болох өөр хэн ч байхгүй гэдгийг ойлгосон тэдэнтэй нэгдэхэд” урьсан билээ.<sup>2</sup>

### Нэмэлт судрууд

Иохан 6:32–35; Алма 5:34;  
3 Нифай 20:3–8

### ЭШЛЭЛҮҮД

1. Д. Тодд Кристоффэрсон, “Өдөр бүр авдаг адислалууддаа Бурханы мутрыг хүлээн зөвшөөрөхүй,” *Liahona*, 2012 оны 1-р сар, 25.
2. Жэффри Р.Холланд, “He Hath Filled the Hungry with Good Things,” *Liahona*, 1998 оны 1-р сар, 76.

### Үүнийг эргэцүүлэн бод

Бид Христэд ирэхэд Тэрээр биднийг хэрхэн тэжээдэг вэ?



Итгэл, гэр бүл, халамж

### Судруудаас

Есүс Христ цугласан 4000 гаруй хүнд зааж байв. Гурван өдрийн дараа Тэр төлөөлөгчдөдөө хандан: “Би хурсан олныг өрөвдөх юм. Тэдэнд ямар ч идэх юм алга:

“Хэрэв би тэднийг гэрт нь өлөн зэлмүүн буцаавал тэд замдаа ядарч унах болно. . . .

“Шавь нар нь Түүнд -Хэн энэ зэлүүд газар хаанаас эдгээр хүмүүсийг цатгах хангалттай талх олж чадах билээ? гэхэд

“Есүс тэднээс -Та нарт хэдэн талх байна? гэв. Тэд -Долоо гэлээ.”

Тэгээд Христ “долоон талхыг аван талархал өргөөд, хуваан хүмүүст үйлчлүүлэхийн тулд Өөрийн шавь нартаа өгөв. . . .

“Тэдэнд бас хэдэн жижиг загас байлаа. Есүс тэдгээрийг ерөөгөөд, эднийг ч бас тараа гэлээ.

“Хүмүүс идээд цадав. Тэгээд тэд үлдсэн хэлтэрхийнүүдийг нь цуглуулахад долоон том сагс дүүрчээ” (Марк 8:1–9-ийг үзнэ үү).

# БАЯРЛАЛАА, ЖЭЙ АХ АА

Кристин Пурсэлл

*Би сүм даяарх өгөөмөр сэтгэлт түм буман үйлчлэгчийн бодол санаа, шийдвэр төгс байдал, бэлтгэл ба хайрын төлөө хэчнээн их талархдаг гээч.*



“Маргааш ням гараг” гэж би өвөр дээр минь сууж буй таван настай охиндоо хэллээ. Түүний нүүрэнд инээмсэглэл тодров.

“Ямар гоё вэ, тэгвэл би Жэй ахтай уулзана” гэж тэр хэлэв.

Зүрх сэтгэл минь талархлаар дүүрлээ. Шинэ тойрогт шилжиж ирсэн явдлыг маань илүү амар болгосон халамж, хайраар дүүрэн Хүүхдийн хэсгийн багшид би хэчнээн их талархсан гээч. АНУ-ын баруун хэсгийн төвөөс, 2200 км хол нүүсэн нь гэр бүлийн минь хувьд хүнд байсан бөгөөд ялангуяа сургуульд хараахан ороогүй Сийсоны хувьд бүр хэцүү байсан юм. Тэр угийн ичимхий учраас нөхцөл байдлаасаа айж байв. Эхний долоо хоногт охин минь шинэ тойрогт очихдоо баахан гэрэвшиж байлаа.

Жэй ах хэмээх аядуу зөөлөн, сайхан сэтгэлтэй эрэгтэй хошин шогийн мэдрэмж хийгээд хайр энэрлээрээ Сийсоны итгэлийг олж чадсан юм. Тэр эхний ням гарагт гүйж ирэн, Сийсоны гараас бариад, өөдөөс нь эгцлэн харж, “Алив нааш ир, хонгор минь. Чи манай ангид хөгжилтэй байх болно” гэж хэлжээ.

Сийсон хэдэн долоо хоног өнгөрсний дараа ням гаргийг долоо хоногийн аль ч өдрөөс илүү хүсэн хүлээдэг боллоо. Биднийг сүмд ирмэгц тэр цугласан олны дотроос

багшийгаа хайдаг болсон юм. Багш нь инээмсэглэн мэндэлдэг байв.

Жэй ах олон жилийн турш суралцагч болгондоо баяраар бас төрсөн өдрөөр нь бэлэг өгч, тэднийг санадаг байсан юм. Сийсоны төрсөн өдөр ойртоход түүний урихыг хүссэн хамгийн эрхэм зочин нь Жэй ах байлаа.

Тэрээр охины минь амьдралд ямар их нөлөө үзүүлснээ төсөөлж чадах болов уу? Түүний ихэнх үг болон үйлдлүүд нь Хүүхдийн хэсгийн таван настай бүлэг суралцагчийн сэтгэлд хоногшсоныг тэр ойлгодог болов уу? Тэрээр охины минь амьдралын нэг хэсэг байх нь эх хүний хувьд надад ямар их утга учиртай болохыг тэр ойлгож чадах болов уу?

Хожим нь Сийсон Эдвард ахын ангид дэвшин орсон бөгөөд Хүүхдийн хэсгийн гайхалтай туршлага нь үргэлжилсэн юм. Би Сийсоны амьдралд сүнслэг нөлөө үзүүлсэн ухаалаг, сайн бэлтгэгдсэн, даруухан эрэгтэй, эмэгтэйчүүдэд тун их талархдаг.

Манай гэр бүл бидний сүнслэг өсөлтийн зам дээр бидэнд үйлчилж, бүхнээ зориулсан хүмүүсээр адислагдсан юм. Би скаутын гарамгай сайн удирдагч, санваарын чуулгын уйгагүй шаргуу зөвлөх, семинарын тэвчээртэй багш, Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн гайхалтай

ерөнхийлөгч болон миний төлөө санаа тавьдаг бишопыг дурсан санадаг.

Гэр бүл минь ихэд адислагдсан ч бид бусдаас өөр биш гэдгээ би мэднэ. Олон хүн “Жэй ах” шиг байж болох бөгөөд манайхтай адил гэр бүлүүдийн амьдралыг үйлчлэлээрээ адисалсан, бүхнээ зориулсан олон ах, эгч байдаг. Бид тэдний бодол санаа, шийдвэр төгс байдал, бэлтгэл, хайрын төлөө хэчнээн их талархдаг гээч.

Гэр бүлд минь тусалсан, сүм даяарх өгөөмөр сэтгэлт, түм буман үйлчлэгч та нартаа баярлалаа. ■  
*Зохиогч нь АНУ-ын Невадад амьдардаг.*



## БУСДЫН АМЬДРАЛЫГ ӨӨРЧЛӨХИЙГ ЭРМЭЛЗ

“Бид Бурханы хаант улсад үйлчилж болох

энгийн арга замууд дээр төвлөрч, бусдын болон өөрсдийн амьдралыг өөрчлөхөөр үргэлж чармайх болтугай.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М. Рассэлл Баллард, “Ай, мэргэн байгтун,” Лиахона, 2006 оны 11-р сар, 20.

# ИЕРЕМИА

*“Иеремиа хүнд үед, хэцүү газарт амьдарч байсан ч Их Эзэн түүнд бидний үе болох ‘хожмын өдрүүд дэх Израилийн цугларалтын найдварын үеийг’ угтан харах боломж олгосон билээ.”<sup>1</sup>*

—Линда К.Бертон, Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч

**Б**и бол Иерусалимын ойролцоох Анатотын тахилч Хелкиагийн хүү. Өсвөр насанд минь “Эзэний үг над уруу ирж айлдахдаа,

“Эхийн хэвлийд чамайг бүрдүүлэхээсээ өмнө би чамайг мэдсэн бөгөөд төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж, чамайг үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон томилсон” гэв.

Би энэ дуудлагад бэлтгэгдээгүй гэсэн мэдрэмжтэй байсан бөгөөд “Харагтун, би залуу тул хэрхэн ярихыг мэдэхгүй” гэв.

Их Эзэн надад “Би залуу гэж бүү хэл. Учир нь Би чамайг илгээх газар бүрд ч ивах болно. Миний чамд тушаах бүхнийг чи ярих болно гэв.

“Тэднээс бүү ай.

Учир нь Би чамайг чөлөөлөхөөр чамтай хамт байна.” Тэгээд Эзэн “мутраа . . . миний аманд хүргээд” аманд минь үгсийг хийв.<sup>2</sup>

Би МЭӨ 626–586 онд Иосиа, Иехоиаким, Зедекиа нарын засаглалын үед Иерусалимд 40 жилийн турш бошиглосон.<sup>3</sup> Би Мормоны Номын бошиглогч Лихайн үед амьдарч байсан юм. Бид хоёулаа Иерусалим дахь хүмүүсийн ёс бус байдлыг буруутгаж мөн тэр агуу хотын устгалыг угтан хэлсэн.<sup>4</sup>

Бошиглолуудаа “хуйлмал номонд”<sup>5</sup> цэдэглэхийг Их Эзэн надад зарлигласан юм. Иехоиаким хаан бошиглолуудыг сонсоод тэр хуйлмал номуудыг шатаасан. Их Эзэн надад уг бошиглолуудыг дахин бичиж, тэдгээр дээр дахиад олныг нэмэхийг зарлиг болгосон билээ.<sup>6</sup>

Би Их Эзэний үгийг номлох явцдаа байнгын эсэргүүцэлтэй тулгардаг байлаа. Тэргүүн түшмэлийн хүү Пашур намайг жанчуулж мөн дөнгөлөв. Намайг номлосны хариуд дээрэмчид намайг алахыг хүсэж байв. Би нэр алдаргүй

бошиглогч байсан бөгөөд шоронд олонтоо хаягддаг байсан. Би үнэхээр туйлын ёс бус цаг үед амьдарч байлаа.<sup>7</sup>

Израильчууд зовлон бэрхшээлийн дунд амьдарч байсан ч эцсийн өдөр цуглуулагдаж, Их Эзэн Өөрийн хуулийг “тэдний зүрхэн дээр” нь бичиж, “хотоос нэгийг, ургаас хоёрыг” Сионд авчрах болно гэдгийг угтан харах боломжийг надад олгосон юм.<sup>8</sup>

Их Эзэний үгийг үргэлжлүүлэн тунхаглахад маш хэцүү байсан ч сайн мэдээг дагах дотоод амлалт нь амар амгалан руу удирддагийг би ойлгосон. Бид Их Эзэнтэй нөхөрлөх хувийн нөхөрлөлөө хөгжүүлбэл бэрхшээл, зовлон дунд найдвартай байж чадна. ■

## ЭШЛЭЛҮҮД

1. Линда К.Бертон, “Есүс Христийн Цагаатгаад итгэх итгэл бидний зүрхэнд бичигдсэн үү?” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 111.
2. Иеремиа 1:1–9-ийг үзнэ үү.
3. Судруудын удирдамж, “Иеремиа”; scriptures.lds.org-ийг үзнэ үү.
4. Иеремиа 6; 1 Нифай 1:13, 18–20-ийг үзнэ үү.
5. Иеремиа 36:2.
6. Иеремиа 36:23–32-ыг үзнэ үү.
7. Иеремиа 20:2; 26:8; 38:6-г үзнэ үү.
8. Иеремиа 31:33; 3:14.



# ХАШ ЧУЛУУН БАЙЦАА

Эллэн С.Жэнсэн

Би Тайваньд номлолд байхдаа хамтрагчтайгаа нэгэн бэлтгэлийн өдрөөр Тайпэйн Үндэсний Ордон Музейд багахан цагийг өнгөрөөсөн юм. Хамгийн чухал үзмэрүүдийн нэг нь хаш чулуун байцаа гэдэг нэртэй урлагийн бүтээл байлаа. Маш олон хүн үүнийг шагшин гайхаж байсан ч миний нүдэнд бол энэ нь хаш чулуугаар сийлсэн байцаа л байсан юм. Энэ нь нүд хужирламаар сайхан байсан нь эргэлзээгүй ч үүнд миний ажиглаагүй ямар нэг зүйл байсан байж таарах нь.

Музей үзэж дууссаныхаа дараа би хамтрагчаасаа “Хаш чулуун байцаа чамд ямар санагдав?” гэж асуулаа.

“Тэр урлагийн бүтээл надад их таалагдсан шүү!”

Би “Яагаад?” гэж асуугаад, “Тэр чинь зүгээр л нэг байцаа шүү дээ” гэв.

“Чи тоглож байна уу? Хаш чулуун байцаа бол миний амьдралын зүйрлэл!” гэж тэр хэллээ.

“Байцаа юу даа?”

“Тийм ээ! Чи түүхийг нь мэдэхгүй гэж үү?”

“Мэдэхгүй байгааг харж байгаа биз дээ.”

Тэр надад түүхийг нь ярьж өгөв. Түүний зөв байлаа. Уг түүхийг миний амьдрал болон номлол аль алинтай нь зүйрлүүлж болно.

Хаш чулуу бүхэлдээ нэг өнгөтэй байвал сийлбэр нь өндөр үнэтэй байдаг ажээ. Төгс сайн хаш чулуугаар хийсэн сийлбэрүүд өндөр үнээр зарагддаг, учир нь төгс сайн

хаш чулууг олох нь бараг л боломжгүй юм. Хаш чулуун байцааны орой нь ногоон, доод тал нь цагаан өнгөтэй бөгөөд ан цав, овон товонтой байлаа. Ямар ч чадварлаг сийлбэрчин ийм хаш чулуун дээр ажиллаж, цагаа дэмий үрэхгүй. Харин хятад хүмүүсийн дунд агуу сийлбэрчин хэмээн нэрд гарсан нэг хүн үүнийг сийлсэн ажээ.

Хэрэв энэ хаш чулуу ярьж чаддагсан бол энэхүү шинэ сийлбэрчин, хаш чулуу хоёрын хооронд ямар яриа өрнөх байсныг би төсөөлөн боддог. Сийлбэрчин хаш чулууг гартаа барьж байгаагаар би төсөөлж байна.

“Та юу хүсээ вэ?” гэж хаш чулуу асууна.

“Би сийлбэр хийх хаш чулуу хайж байна” гэж сийлбэрчин хэлнэ.

“Тэгвэл өөр чулуу олж ав. Би ямар ч үнэ цэнэгүй. Би хоорондоо

нийлсэн хоёр өөр өнгөтэй, энэ хоёр өнгийг та салгаж чадахгүй. Би бас ан цав, овон товонтой. Би хэзээ ч үнэ цэнэтэй болохгүй. Цагаа биттий дэмий үр.”

“Ай, бяцхан хаш чулуу минь. Надад итгэ. Би бол алтан гартай сийлбэрчин. Би чамаар хосгүй сайхан бүтээл хийнэ.”

Хаш чулуун байцааг гайхалтай болгосон нэг зүйл бол нэр нь үл мэдэгдэх алтан гарт сийлбэрчин хаш чулууны сул тал болох хоёр өнгийг болон ан цав, овон товонг ашиглан түүнийг жинхэнэ байцаа шиг харагдахаар хийсэнд байлаа. Цагаан хэсэг нь байцааны иш болж, ан цав болон овон товон нь жинхэнэ навч шиг харагдаж байв. Хэрэв хаш чулуунд ийм “сул талууд” байгаагүй бол хаш чулуун байцаа жинхэнэ байцаа шиг харагдаж чадахгүй байсан биз ээ.



## ИХ ЭЗЭН ЗҮРХ СЭТГЭЛИЙГ ХАРДАГ.

“Бидний амьдарч буй дэлхийд ёс суртахууны ноён нуруу нь гоо үзэсгэлэн эсвэл сэтгэл татам байдлын дараа, хоёрдугаарт ихэнхдээ тавигдах болжээ. Гэвч олон зууны тэртээгээс Их Эзэний бошиглогч Самуелд хэлсэн: ‘Бурхан хүнтэй адил хардаггүй. Хүн гаднах төрхийг хардаг бол ЭЗЭН зүрхийг нь хардаг’ (1 Самуел 16:7) хэмээх зөвлөгөө цуурайтан байдаг билээ”.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Canaries with Gray on Their Wings,” *Лиахона*, 2010 оны 6-р сар, 4.



Урлагийн энэхүү хосгүй бүтээл ер бусын гоё учраас Хятадын хаадын нэгэнд бэлэг болон өгөгдсөн бөгөөд Тайваний музейд ирэх хүртлээ Азийн үзэсгэлэнт ордуудын танхимыг чимсээр байжээ.

Хаш чулуун байцаа надад Ифер 12:27-г санагдуулдаг: “Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. . . . Мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө даруусаж мөн надад итгэлтэй байх аваас тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө.”

Хаш чулуун байцааг үзсэний дараа энэ судар надад шинэ утга учиртай

болж эхэлсэн юм. Бид бүгд энэ хаш чулуутай адил бөгөөд бид яг сийлбэрлэх үйл явцад байгаа юм. Бид өөрсдийнхөө сул дорой байдлыг хүчирхэгжүүлэгч агуу сийлбэрчин Есүс Христэд итгэх ёстой. Бид төгс бус үзлийнхээ улмаас зарим үед төгс бус зүйлүүд дээр анхаарал төвлөрүүлснээр өөрсдийгөө хэзээ ч сайн байж чадахгүй гэж бодон, шантардаг. Гэвч бидний Аврагч Есүс Христ биднийг ямар хүмүүс болж чадах вэ гэдгээр нь л хардаг. Бид өөрсдийн амьдралд нөлөөлөх боломжийг Түүний Цагаатгалд олгох юм бол Тэр биднийг хэзээ нэгэн өдөр Хаадын хаантай хамт амьдрах хосгүй урлагийн бүтээл болгон сийлэх болно. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

### **ИХ ЭЗЭН НАМАЙГ ХАРДАГ ШИГ БИ ӨӨРИЙГӨӨ ХЭРХЭН ХАРЖ ЧАДАХ ВЭ?**

Их Эзэн биднийг хардаг шиг бид өөрсдийгөө харах нь амархан биш юм. Тэрээр биднийг агуу чадавхтай мөн агуу үнэ цэнэтэй Бурханы хүүхдүүд хэмээн хардаг. Гэвч бид заримдаа өөрсдийнхөө сул талууд дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Тэнгэрлэг Эцэг маань биднийг алдаан дээрээ анхаараасай гэж биш харин үзэсгэлэнт урлагийн бүтээл болоосой гэж бүтээсэн. Есүс Христийн сайн мэдээгээр болон Түүний Цагаатгалаар дамжуулан бид дутагдлуудаа даван туулж чадна.

Их Эзэн өөрийнхөө ажлыг гүйцэлдүүлэхийн тулд төгс бус хүмүүсийг хэрхэн ашигладгийг сурахын тулд дараах судруудыг унших талаар бодож үзээрэй: Египетээс гарсан нь 4:10–12; Иеремиа 1:4–10; 1 Нифай 4:1–6; Алма 26:12; Сургаал ба Гэрээ 35:17–18.

# ЛИЗОЧКАГИЙН ЗҮРХ

Марина Петрова

Нөхөр бид хоёр 1995 онд Орос Оронд сүмд элсэж, дараа жил нь Шведийн Стокгольмын ариун сүмд лацдан холбогдсон. Хоёр бяцхан охин маань ч бас бидэнтэй лацдан холбогдсон юм. Хоёр жилийн дараа бид Лизочка гэдэг өөр нэг охиноор адислагдав. Бидний амьдрал сайхан байлаа. Бид бүгд аз жаргалтай байв. Гэвч түүнийг төрснөөс хоёр өдрийн дараа нялх охин минь юм идэж чадахгүй болж, сарын турш ердөө л 300 гр жин нэмэв.

Хүүхдийн эрүүл мэндийн төвийн ажилтнууд түүнийг илүү ойр ойрхон хоолло гэж бидэнд хэлсэн. Тэр идэхийг хүсэж байсан ч чадахгүй байлаа. Эцэст нь нөхөр маань түүнийг хотын эмнэлэг рүү авч явав. Тэндхийн эмч тэр даруй оношилж, зүрхний төрөлхийн гажиг гэсэн онош тавьсан юм. Зүрхний нэг хавхлаг нь ажиллахгүй байсан бөгөөд цусны эргэлт сулаас болоод түүнд амьсгалах эсвэл идэх нь хүндрэлтэй байсан байв.

Түүнд мэс засал хэрэгтэй байсан ч Оросод ийм мэс засал хийлгэх хамгийн доод нас нь 2 нас байлаа. Охин минь дөнгөж нэг сартай байв. Эмч түүнд зориулан эмчилгээ бичиж өгсөн бөгөөд 2 нас хүрэхээр нь мэс засал хийнэ гэж хэллээ.

Нэг сарын дараа Лизочкагийн эрүүл мэнд улам дордсон бөгөөд бид түүнийг эмнэлэг рүү яаралтай авч явав. Машин дотор би түүнийг тэвэрч байлаа. Тэр тусламж гуйж

буй мэт над руу харж байв. Хэрэв би сүмийн гишүүн байгаагүй бол юу хийх байснаа мэдэхгүй байх байсан. Гэсэн хэдий ч нөхөр бид хоёр Их Эзэнд мөн бүх юм сайхан болно гэдэгт бат итгэж байсан юм. Би “Юунаас ч бүү ай, бяцхан үр минь. Бурхан бидэнд хайртай. Тэр бидэнд тусална мөн бүх юм сайхан болох болно” гэж түүнийг тайвшруулахыг хичээж байв.

Тэгээд бид эмнэлэгт ирлээ. Би охиноо чанга тэврээд хүлээн авах тасаг руу гүйв. Лизочкагийн нүд анилдаж эхэллээ. Тэрээр дөнгөж амьсгаатай байв. Би эмчид хүүхдийнхээ талаар хэлэхдээ бараг л ярих чадваргүй шахам болсон байсан бөгөөд эмч нарын баг түүнийг сэхээн амьдруулах тасаг руу авч явлаа. Түүний уушиг томорч эхэлснийг эмч хэлсэн бөгөөд тэд түүнийг зохиомол амьсгалын аппаратад залгав.

Дараагийн өдөр нь бид мэс заслын тасгийн эрхлэгчтэй ярилцлаа. Тэр “Би ийм мэс заслыг том болсон хүүхдүүд дээр л хийдэг. Охин чинь одоо хэдтэй вэ?” гэж асуулаа.

“Хоёр сартай” гэж бид түүнд хэлэв.

Тэрээр “Түүнд маш их зовиуртай байгаа. Охин чинь нялх бас томорч буй уушиг нь байдлыг бүр дордуулж байна. Бид ийм байдалтай байлгаад байж болохгүй. Би энэ мэс заслыг нялх хүүхдэд хийж үзээгүй боловч чадах бүхнээ хийхийг хичээнэ. Та нар хиймэл хос хавхлаг авах хэрэгтэй ба

энэ нь их үнэтэй, ойролцоогоор 2100 ам.доллар. Мэс засал дөрвөн өдрийн дараа хийгдэнэ” гэлээ.

Бид яах ёстой байсан бэ? Бидэнд ч, бидний таних хэн нэгэнд ч ийм их мөнгө байсангүй. Гэсэн хэдий ч бидний нөхцөл байдлыг бусад хүн мэдсэн бөгөөд тэдний өгөөмөр сэтгэл, Их Эзэний нигүүлслээр дамжуулан бид хэрэгтэй мөнгийг олж, нөхөр маань охиныхоо амийг аврахад шаардлагатай хавхлагийг худалдан авч чадсан юм.

Бяцхан охины минь төлөө манай салбарын ах, эгч нар төдийгүй номлогчид мөн хот даяарх олон хожмын үеийн гэгээнтэн мацаг барин, залбирч байв. Бид тэдний дэмжлэгийг мэдэрч байлаа. Мэс засал болох өдөр коридорт сууж байхдаа бид Ариун Сүнсний оршихуйг болон ах, эгч нарынхаа залбирлыг мэдэрч байв. Тэднийг бидэнтэй ойрхон байгааг нь бид мэдэрсэн! Мөн Бурхан бидэнтэй хамт байж, мэс заслын эмч нарыг удирдаж байсан юм. Тэр биднийг орхихгүй бөгөөд бүх зүйл сайхан болно.

Мэс заслын эмч хагалгаанд ороод гарч ирэхдээ бага зэрэг гайхширсан байдалтай “Бүх зүйл сайн боллоо. Бид хавхлагийг суулгасан. Би яаж гэдгийг нь мэдэхгүй ч мэс засал амжилттай болсон” гэж хэллээ. Харин бид яаж гэдгийг нь мэдэж байв. Тэнгэрлэг Эцэг түүнийг адисалсан юм.

Лизочка эмнэлэгт гурван өдөр хэвтсэн бөгөөд энэ хооронд зүрх



### **ЗАЛБИРЛУУД ХАРИУ- ЛАГДАХГҮЙ БАЙГАА МЭТ САНАГДАХ ҮЕД**

“Маш их хүсэж буй зүйлийнхээ талаар залбирсан залбирлын хариулт тань та нарын хүсэн хүлээж байсан арга замаар ирэхгүй байх нь тун хэцүү. Дуулгавартай амьдралын гүнзгий хийгээд чин сэтгэлийн итгэл нь хүссэн үр дүнг авчрахгүй байгааг ойлгоход хэцүү байдаг. Аврагч ‘Миний нэрээр та нар Эцэгээс юу ч гуйлаа гэсэн, өөрсдөд чинь шаардлагатай тэр нь та нарт өгөгдөх болно’ гэж заасан [С ба Г 88:64; тодруулга нэмэгдсэн]. Зарим үед юу бидэнд хамгийн сайн эсвэл шаардлагатай болохыг таньж мэдэх нь амаргүй байдаг. Бурханы та нарын амьдралд хийж буй зүйлүүд нь та бүхний мөнхийн сайн сайхны төлөө байдаг гэдгийг хүлээн зөвшөөрвөл амьдрал тань илүү амар байх болно.”

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт, “Using the Supernal Gift of Prayer,” Лиахона, 2007 оны 5-р сар, 9.**

болон уушиг нь хэвийн байдалдаа орлоо. Мэс засал хийхдээ түүний цээжийг нээж мөн дараа нь нимгэн давхаргаар хаасан байсан тул хэдэн өдрийн дараа тэд түүний цээж, эрхтнүүдийг хаахын тулд дахин мэс засал хийлээ. Эмч нарын хэн нь ч түүнийг амьд үлдэнэ гэж бодоогүй юм. Гэвч бид Тэнгэрлэг Эцэгт болон Түүний хүчинд итгэж байсан бөгөөд хэрэв энэ нь Түүний хүсэл бол охин маань эдгэрнэ гэдэгт итгэсэн юм.

Зөвхөн Бурхан л Лизочкаг минь

бидэнд буцаан өгч чадах байсан. Өдөр өнгөрөх тусам түүний бие дээрдэв. Тэр эмнэлэгт нэг сар хэвтсэн бөгөөд одоо гэртээ бидэнтэй хамт байна.

Бурхан бол гайхамшгуудын Бурхан. Тэр бидний залбирлуудыг сондог бөгөөд хүнд хэцүү цагт биднийг анхаарч халамжилдаг. Бэрхшээлүүд нь бидний итгэлийг хүчирхэгжүүлж, итгэж, найдахыг мөн хайрлахыг бидэнд заадаг. ■

*Зохиогч нь Бельгид амьдардаг.*



Ахлагч  
Дэвид А.Бэднар  
Арванхоёр Төлөөлөг-  
чийн Чуулгын

# Номлогчийн ажил, гэр бүлийн түүхийн ба ариун сүмийн

# АЖИЛ



1837 оны 4-р сарын 6-нд Кертландын ариун сүмд болсон онцгой цугларалт дээр бошиглогч Иосеф Смит “Эцсийн эцэст, хамгийн аугаа, хамгийн чухал үүрэг бол сайн мэдээг номлох юм”<sup>1</sup> хэмээн хэлжээ.

Үүнээс хойш яг долоон жилийн дараа буюу 1844 оны 4-р сарын 7-нд тэрээр: “Энэ дэлхий дээр Бурхан бидэнд хүлээлгэсэн хамгийн агуу үүрэг бол нас барсан хайртай хүмүүсийнхээ төлөө ажиллах явдал мөн. ‘Тэд бидэнгүйгээр төгс болгогдож чадахгүй’ [Еврей 11:40-ийг үзнэ үү] хэмээн төлөөлөгч хэлсэн. Учир нь цаг хугацааны бүрэн байдлын эрин үе—дэлхийн сууриннаас өмнө хүмүүний авралын төлөө Есүс Христийн хийсэн амлалтуудыг хэрэгжүүлэх эрин үед хүүхдүүдээ болон нас барсан хайртай хүмүүсээ лацдан холбох хүч бидэнд байх нь зайлшгүй чухал юм” гэж тунхаглажээ<sup>2</sup>

Сайн мэдээг номлох болон нас барагсдаа аврах нь хоёулаа Бурханаас хүүхдүүдээ өгсөн хамгийн агуу үүрэг хариуцлага хэрхэн байж болох вэ хэмээн зарим хүн бодож болох юм. Миний зорилго бол эдгээр сургаал нь хожмын үеийн авралын ажлын нэгдмэл



*Сайн мэдээг номлох болон нас барагсдаа аврах нь үнэнийг шударгаар хайгчдын зүрх сэтгэлийг өөрчлөн, эргүүлж, цэвэршүүлэх зорилготой хайрын нэг л агуу ажлын харилцан холбоотой хоёр хэсэг юм.*



байдалд онцгой анхаарал хандуудаг гэдгийг зөвлөх явдал юм. Номлогчийн ажил, гэр бүлийн түүхийн ба ариун сүмийн ажил нь харилцан холбоотой бөгөөд “Энэ нь цагийн дүүрнийг гүйцэлдүүлэхийн тулд тэнгэр дэх юмс болон газар дээрх бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ” (Ефес 1:10) гэсэн нэгэн агуу ажлын хоорондоо холбоотой хэсгүүд юм.

Биднийг хожмын үе дэх авралын гайхамшигтай ажлын талаар хамтдаа ярилцах үед Ариун Сүнсний хүч та нарт болон надад туслахын төлөө би залбирч байна.

### **Зүрх сэтгэл ба санваарын ёслолууд**

Сайн мэдээг номлох болон нас барагсдаа аврах нь бидний зүрх сэтгэлтэй мөн санваарын ёслолуудтай холбоо бүхий бурханлагаар томилогдсон хоёр үүрэг

хариуцлага юм. Их Эзэний ажлын мөн чанар нь санваарын зохих эрх мэдлээр гүйцэтгэгддэг гэрээнүүд болон ёслолуудаар дамжуулан зүрх сэтгэлийг өөрчлөх, эргүүлэх, ариусгах явдал юм.

*Зүрх, зүрх сэтгэл* гэдэг үг жишиг бүтээлүүдэд 1000 гаруй удаа давтагдсан байдаг бөгөөд хувь хүний дотоод мэдрэмжийг бэлгэддэг. Тиймээс бидний зүрх буюу бидний хүсэл таашаал, зорилго, учир шалтгаан, хандлагын нийлбэр нь бид хэн бэ гэдгийг мөн бид ирээдүйд ямар хүмүүс болох вэ гэдгийг тодорхойлдог.

Номлогчийн ажлын талаарх Их Эзэний зорилго бол бүхнийг Христэд ирж, сэргээгдсэн сайн мэдээний ёслолуудыг хүлээн авахад мөн Христэд итгэх итгэлээр дамжуулан эцсээ хүртэл тэвчихэд урих явдал юм.<sup>3</sup> Бид хожмын үе дэх сүмийн



*Сайн мэдээтэй  
холбоотой  
“хийх ёстой”  
зүйлсийн урт  
жагсаалт дээрх  
бүх зүйлийг зүгээр  
л биелүүлж, мөн  
яг таг гүйцэтгэх  
нь Түүний дүр  
төрхийг царай  
төрхөндөө хүлээн  
авах эсвэл зүрх  
сэтгэлийн хүчит  
өөрчлөлтийг  
мэдрэх боломжийг  
бидэнд олгоно гэсэн  
үг биш юм.*

гишүүдийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэхийн төлөө л сайн мэдээг хуваалцдаггүй. Харин бид Эцэгийн аз жаргалын төлөвлөгөө, Түүний Төрсөн Ганц Хайртай Хүү Есүс Христийн бурханлаг мөн чанар, Аврагчийн цагаатгагч золиослолын бодит байдлыг тунхаглах бурханлагаар томилогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхийг эрэлхийлдэг. Бүх хүмүүнийг “Христэд ирэгтүн” (Моронай 10:30–33-ыг үзнэ үү), зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлтийг” (Алма 5:12–14-ийг үзнэ үү) мэдрэгтүн хэмээн урьж мөн гэрээнд хараахан орж амжаагүй байгаа мөнх бус амьдрал дахь хувь хүмүүст авралын ёслолуудыг санал болгох нь сайн мэдээг номлох ажлын гол зорилго юм.

Их Эзэн ариун сүмүүдийг барьж, ёслолуудыг хийдэг зорилго нь амьд болон нас барсан хүмүүсийн өргөмжлөлийг боломжтой болгох явдал билээ. Бид зөвхөн хувийн эсвэл гэр бүлийн дурсамжит туршлагатай болохын тулд ариун сүмд шүтэн биширдэггүй. Харин бид авралын ёслолуудыг болон өргөмжлөлийг бүх хүн төрөлхтөнд санал болгох бурханлагаар томилогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхийг эрэлхийлдэг. Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд эцгүүдэд нь буюу Абрахам, Исаак, Иаков нарт өгөгдсөн амлалтуудыг суулган, гэр бүлийн түүхийн судалгаа хийж, ариун сүмд нас барагсдын төлөө ёслолуудыг гүйцэтгэх нь сүнсний дэлхийд буй, гэрээнд хараахан орж амжаагүй хувь хүмүүсийг адисалдаг ажил юм.

Санваарын ёслолууд нь бурханлаг чанарын хүчинд хүрэх зам мөн:

“Мөн энэхүү дээд санваар нь сайн мэдээг удирдаж мөн хаант улсын нууцуудын түлхүүрийг, бүр Бурханы мэдлэгийн түлхүүрийг атгадаг болой.

“Тиймийн тул, үүний ёслолуудад бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэг.

“Үүний ёслолуудгүйгээр мөн санваарын эрх мэдэлгүйгээр бурханлаг чанарын хүч

махан бодид хүмүүнд илэрхийлэгдэх нь үгүй бөлгөө” (С ба Г 84:19–21).

Эдгээр шүлгийн ач холбогдлыг тунгаан бодно уу. Хувь хүн эхлээд баптисм ба Ариун Сүнсний бэлгийн хаалгаар орох ёстой бөгөөд дараа нь Аврагч ба Түүний Цагаатгалын адислалууд руу хөтөлдөг гэрээнүүд болон ёслолуудын замаар үргэлжлүүлэн урагш тэмүүлэх ёстой (2 Нифай 31). Санваарын ёслолууд нь “Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн” (Моронай 10:30–33-ыг үзнэ үү) хэмээн бүрэн дүүрэн урихад зайлшгүй чухал. Ёслолуудгүйгээр хувь хүн Их Эзэний хязгааргүй хийгээд мөнхийн цагаатгагч золиослолоор боломжтой болдог бүх адислалыг (Алма 34:10–14-ийг үзнэ үү)—бурханлаг чанарын хүчийг хүлээн авч чадахгүй.

Их Эзэний ажил нь зүрх сэтгэл, гэрээнүүд ба санваарын ёслолууд дээр төвлөрсөн нэгэн сүр жавхлантай ажил билээ.

## **Оролцоо**

Энэхүү бурханлаг сургаал сүм дэх бидний ажилд хоёр чухал оролцоог санал болгодог.

Нэгдүгээрт, бид ихэвчлэн авралын ажлын тусгаар хэсгүүдийг болон үүнтэй холбоотой бодлого, дүрэм журмуудыг хэт онцолдог байж магадгүй. Бид Их Эзэний ажлын аль нэг тодорхой хэсэг дээр бүх анхаарал, хүчин чармайлтаа төвлөрүүлснээр авралын энэхүү агуу ажлын бүрэн хүч чадлыг эзэмшиж чадахгүй болох вий гэж би айдаг.

Их Эзэн бүх зүйлийг Христ дотор нэг болгон цуглуулахыг эрэлхийлж байгаа үед бид өөрсдийн ойлголт, алсын харааг хязгаарлах арга замуудаар бүхий л зүйлийн аль нэг хэсэг дээр анхаарлаа ихэвчлэн төвлөрүүлдэг байж мэднэ. Хэт түйлширвал эн тэргүүнд анхаарах зүйл нь хувь хүмүүсийг гэрээнд орж, ёслолуудыг зохистой хүлээн авахад урихаас илүүтэй, хөтөлбөрүүдийг удирдаж, тоон үзүүлэлтүүдээ сайжруулах

гэсэн оролдлого болж хувирна. Ийм оролдлого нь “зүрх сэтгэлээ Бурханд зориулсан” (Хиламан 3:35) учраас ирдэг цэвэршүүлэлт, баяр баясгалан, цаашдын хөрвөлт, сүнслэг хүч чадал болон хамгаалалтыг хязгаарладаг. Сайн мэдээний дагуу “хийх ёстой” зүйлсийн жагсаалтан дээрх зүйлсийг л хийж гүйцэтгэх нь Түүний дүр төрхийг царай төрхөндөө хүлээн авах эсвэл зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг мэдрэх боломжийг бидэнд олгоно гэсэн үг биш юм (Алма 5:14-ийг үзнэ үү).

Хоёрдугаарт, Елиагийн сүнс нь сайн мэдээг тунхаглах ажлын төв болоод амин чухал хэсэг юм. Сайн мэдээний бүрэн байдал энэхүү хожмын өдрүүдэд дэлхий дээр сэргээгдэх үед тохиосон үйл явдлуудын дараалалд Их Эзэн уг үнэнийг онцолсон бололтой.

Ариун төгөлд Иосеф Смит Мөнхийн Эцэг, Есүс Христ хоёрыг харж, тэдэнтэй ярилцсан билээ. Энэхүү үзэгдэл нь “цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийг” (Ефес 1:10) эхлүүлсэн бөгөөд Бурхан Тэргүүтний жинхэнэ мөн чанар, байнгын илчлэлтийн талаар сурч мэдэх боломжийг Иосефт олгосон юм.

Ойролцоогоор гурван жилийн дараа 1823 оны 9-р сарын 21-ний үдэш хийсэн чин сэтгэлийн залбирлын хариуд Иосефын унтлагын өрөө “үд дундынхаас илүү гэрэлтэй” (Иосеф Смит—Түүх 1:30) болж, гэрлээр дүүрсэн юм. Нэгэн хүмүүн бие орных нь дэргэд зогсоод, хөвгүүнийг нэрээр нь дуудаж “тэр [бол] Бурханы дэргэдээс . . . илгээгдсэн элч гэдгийг, мөн түүний нэр Моронай гэдгийг” (Иосеф Смит—Түүх 1:33) мэдэгдсэн билээ. Тэр Мормоны Номын ирэлтийн талаар Иосефт зааварчигаа өгсөн юм. Тэгээд Моронай Хуучин Гэрээн дэх Малахийн номоос эш татсан



*Бид зөвхөн хувийн эсвэл гэр бүлийн дурсамж бүхий туршлагатай болохын тулд ариун сүмд шүтэн биширдэггүй. Харин бид авралын ёслолуудыг болон өргөмжлөлийг бүх хүн төрөлхтөнд санал болгох бурханлагаар томилогдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхийг эрэлхийлдэг.*

нь хаан Жеймсийн хувилбарт бичигдсэнээс бага зэрэг өөр байжээ:

“Болгоогтун, Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө, бошиглогч Елиагийн гараар би та нарт санваарыг илчлэх болно. Мөн тэрээр эцгүүдэд нь хийгдсэн амлалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгах болно, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд уруугаа эргэх болно. Хэрэв энэ нь ийм байхгүй аваас, түүний ирэлтээр бүх дэлхий бүрмөсөн устагдах болно” (Иосеф Смит—Түүх 1:38–39).

Залуу бошиглогчид өгсөн Моронайн зааварчилгаа чухамдаа хоёр чухал сэдвийг багтаасан байв: (1) Мормоны Ном ба (2) “Бурхан Өөрийнхөө ариун эш үзүүлэгчийн амаар эрт цагаас айлдсанчлан бүхнийг” (Үйлс 3:21) сэргээх ажилд Елиагийн гүйцэтгэх үүргийг угтан хэлсэн Малахийн үгс. Иймээс сэргээлтийн удиртгал болсон үйл явдлууд нь Бурхан тэргүүтний талаарх зөв ойлголтыг илчилж, байнгын

илчлэлтүүдийг бодитой болгон, Мормоны Номын ач холбогдлыг онцолж, амьд хүмүүсийн болон нас барагсдын төлөөх авралын ажил ба өргөмжлөлийг угтан хэлсэн юм.

Зүрх сэтгэлийг өөрчлөхөд Мормоны Ном ямар үүрэгтэйг мөн зүрх сэтгэлийг эргүүлэхэд Елиагийн сүнсний гүйцэтгэх үүргийг одоо тунгаан бодно уу.

Мормоны Ном нь Их Эзэний Сүнстэй хамт “дэлхийг хөрвүүлэхийн тулд Их Эзэнээс бидэнд өгсөн хамгийн агуу хэрэгсэл мөн.”<sup>4</sup> Сэргээлтийн энэхүү судар нь манай пашны тулгуурын чулуу бөгөөд бодгалиудыг Аврагчид авчрахад зайлшгүй чухал юм. Мормоны Ном бол Есүс Христийн бас нэгэн гэрээ—Гэтэлгэгчийн бурханлаг байдлыг илүү шашинлаг бус бөгөөд эрээ цээргүй болж



*Сайн мэдээг номлох болон нас барагсдаа аврах нь бидний зүрх сэтгэлтэй мөн санваарын ёслолуудтай холбоо бүхий бурханлагаар томилогдсон хоёр үүрэг хариуцлага юм.*

буй дэлхийд гэрчлэхэд амин чухал юм. Хувь хүмүүс Мормоны Номыг судалж, уг номын үнэнийг ойлгох чин хүслээр залбирсан үед зүрх сэтгэл нь өөрчлөгддөг.

Елиагийн сүнс нь “гэр бүлийн тэнгэрлэг мөн чанарыг Ариун Сүнс гэрчилдгийн илэрхийлэл юм.”<sup>5</sup> Ариун Сүнсний энэхүү онцгой нөлөө нь Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөг хүчтэй гэрчилж мөн өөрсдийн нас барсан болон одоо амьдарч буй өвөг дээдэс болон гэр бүлийн гишүүдийг эрж хайн, тэднийгээ хайрлан хүндлэхэд хүмүүсийг татан оролцуудаг. Елиагийн сүнс нь сүмийн дотор болон гаднах хүмүүсийн аль алинд нь нөлөөлж, зүрх сэтгэлийг эцгүүд рүү эргүүлдэг.



Энэхүү өгүүлэлд хамаарах б видео бичлэг байгаа. Энэ зарчмыг харуулж буй түүхийн эхний видео бичлэгийг үзэхийн тулд [lds.org/go/bednar1014](https://lds.org/go/bednar1014) рүү орох юм уу түргэн хариулах (QR) кодыг ашиглана уу.

Мормоны Номын сүнслэг хүч чадлын ачаар боломжтой болсон зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлт болон Елиагийн сүнсээр дамжуулан гүйцэлддэг зүрх сэтгэлийг эцгүүд рүү нь эргүүлэх хоёрын хүчирхэг нэгдлийг илүү үр дүнтэй онцлох цаг бидэнд ирээд байна. Өнгөрсөн үетэйгээ холбогдох гэсэн хүсэл эрмэлзэл нь хувь хүнийг Бурханы үгийн хүчийг хүлээн авч, итгэлээ хүчирхэгжүүлэхэд бэлтгэж чадна. Зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх үйл явц нь хувь хүнд хилэнцийн нөлөөний эсрэг зогсож, хөрвөлтөө хүчирхэгжүүлэхэд онцгой байдалаар тусалдаг.

*Энэ зарчмыг харуулж буй түүхийг үзэхийн тулд 2 дахь видео бичлэгийг үзнэ үү.*

### **Зарчмууд**

Одоо би зүрх сэтгэлийг өөрчилж, эргүүлэхээс ирдэг сүнслэг хүч чадлын талаарх дөрвөн зарчмыг тодорхойлохыг хүсэж байна.

**1. Зүрх сэтгэл ба хөрвөлт.** Эцгүүд рүүгээ эргэх үйл явц нь зүрх сэтгэлийг хүчит өөрчлөлтөд бэлтгэдэг. Иймээс Елиагийн сүнс хөрвөлтөд тусалдаг.

*Энэ зарчмыг харуулж буй түүхийг үзэхийн тулд 3 дахь видео бичлэгийг үзнэ үү.*

**2. Зүрх сэтгэл ба идэвхтэй байлгах ажил.** Эцгүүд рүүгээ эргэх үйл явц нь хүчит өөрчлөлтийг мэдэрсэн зүрх сэтгэлийг дэмжихийн хамт хүчирхэгжүүлдэг. Иймээс Елиагийн сүнс шинэ хөрвөгчдийг идэвхтэй байлгахад тусалдаг.

*Энэ зарчмыг харуулж буй түүхийг үзэхийн тулд 4 дэх видео бичлэгийг үзнэ үү.*


**3. Зүрх сэтгэл ба дахин идэвхжүүлэх ажил.** Эцгүүд рүүгээ эргэх үйл явц нь хүчит өөрчлөлтийг мэдэрсний дараа хатуурсан зүрх сэтгэлийг зөөллөдөг. Иймээс Елиагийн сүнс дахин идэвхжүүлэх ажлын түлхүүр юм.

*Энэ зарчмыг харуулж буй түүхийг үзэхийн тулд 5 дахь видео бичлэгийг үзнэ үү.*

**4. Зүрх сэтгэл ба зоригтой номлогчид.** Зүрх сэтгэлийн хүчит өөрчлөлтийг болон зүрх сэтгэл хэрхэн эргэхийг мэдэрсэн номлогч нь илүү хөрвөсөн бөгөөд бүхнээ зориулсан, зоригтой үйлчлэгч байх болно.

*Энэ зарчмыг харуулж буй түүхийг үзэхийн тулд 6 дахь видео бичлэгийг үзнэ үү.*

Бид хурдан өсөн тэлж буй, илүү сайн бэлтгэгдсэн номлогчдын армитай хамт ирээдүйн чиг хандлага болон арга барилыг тодорхойлохдоо сайн мэдээг тунхаглах ажилд дан ганц өмнө нь олсон амжилт дээрээ тулгуурлаж болохгүй. Энэ эрин үед өмнөх аль ч эрин үед байгаагүйгээр номлолын ажил, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлыг нэгдмэл нэг зүйл болгох боломжийг бидэнд олгож буй технологи ба арга хэрэгслүүдийг Их Эзэн



*Елиагийн сүнс нь  
“гэр бүлийн тэн-  
гэрлэг мөн чанарыг  
Ариун Сүнс гэрчилж  
байгаагийн илэрхий-  
лэл юм.”*

бэлтгэсээр байна. Энэхүү дэвшил нь номлолын ажлыг дэлхий даяар урагшлуулах яг хэрэгцээтэй үедээ гарч ирж байгаа нь тохиолдлын зүйл биш юм. Их Эзэний ажил бол өөрчлөгдөн эргэдэг зүрх сэтгэлд мөн ариун нандин гэрээнүүдэд болон санваарын ёслолуудаар илэрдэг бурханлаг чанарын хүчинд төвлөрсөн нэгэн сүр жавхлант ажил билээ.

### **Дүгнэлт ба гэрчлэл**

Их Эзэн “Өөрийн ажлыг би өөрөө хийж чадна” (2 Нифай 27:21), “Бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яаравчлуулах болно” (С ба Г 88:73) хэмээн тунхагласан билээ. Түүнийг Өөрийн ажлыг яаравчуулж байгаагийн гэрчүүд нь бид юм.

Бид цаг хугацааны бүрэн байдлын эрин үед амьдарч, үйлчилж байна. Өөрсдийн амьдарч буй онцгой эрин үеийн мөнхийн ач холбогдлыг ойлгох нь бидний хийдэг бүх зүйлд мөн бид ямар хүмүүс болохоор эрмэлздэгт нөлөөлөх ёстой. Энэхүү эцсийн өдрүүдэд гүйцэлдэх ёстой авралын ажил нь агуу, өргөн цар хүрээтэй, амин чухал хийгээд яаралтай юм. Эцсийн эрин үеийн энэхүү онцгой цаг үед амьдрах адислал, үүрэг хариуцлагын төлөө бид талархах ёстой билээ. “Их нь өгөгдсөн түүнээс их нь шаардагдах” (С ба Г 82:3) болно гэдгийг мэддэгийн хувьд бид туйлын даруу байх ёстой.

Сайн мэдээг номлох болон нас барагсдаа аврах нь үнэнийг шударгаар хайгчдын зүрх сэтгэлийг өөрчлөн, эргүүлж, цэвэршүүлэх зорилготой хайрын нэг л агуу ажлын харилцан холбоотой хоёр хэсэг юм. Номлолын ажил, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын хооронд бидний олонтоо тавьдаг зохиомол хил

хязгаар одоо үед арилж байна. Энэ бол авралын нэг л агуу ажил билээ.<sup>6</sup>

Бид сонирхогчид эсвэл идэвх султай гишүүнд авралын төлөвлөгөөний тухай илүү гүнзгий ойлголттой болоход нь туслах ажилд ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажлын гүйцэтгэдэг үүргийг ойлгодог бил үү? Хөрвөгчийг идэвхтэй хэвээр байлгахад туслах хамгийн чухал нөлөөнүүдийн нэг нь Елиагийн сүнс гэдгийг бид ойлгодог уу? Гишүүд ба номлогчид аль аль нь гэр бүлийн түүхээ хуваалцах явдлыг заах хүмүүсийг олох арга болгож ашиглахад бий болдог зүрх сэтгэлийг эргүүлэх үйл явцын ач холбогдлыг бид илүү бүрэн дүүрэн үнэлж чаддаг бил үү? Бидний үйлчилдэг хүмүүс ариун ёслол, нас барагсдын төлөөх баптисм, гишүүний баталгаа гэх мэт ёслолуудад зөв зохистой оролцсоноор бурханлаг чанарын хүчийг илүү ойр ойрхон хүртэхэд тэдэнд тусалж чаддаг уу?

Та бүхэн илүү тод харж, андууралгүй сонсон; зүрх сэтгэлийг өөрчлөн, эргүүлж, цэвэршүүлэх Их Эзэний ажилд өөрсдийн хийдэг үйлчлэлийн ач холбогдлыг үргэлж санаж явах болтугай. ■

*2013 оны 6-р сарын 25-нд болсон номлолын шинэ ерөнхийлөгчдөд зориулсан сургалт дээр хэлсэн үгээс авах.*

### **ЭШЛЭЛҮҮД**

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 330.
2. *Teachings: Joseph Smith*, 475.
3. *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж* (2004), 1-ийг үзнэ үү.
4. Эзра Тафт Бэнсон, “A New Witness for Christ,” *Ensign*, 1984 оны 11-р сар, 7.
5. Рассэл М.Нэлсон, “A New Harvest Time,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 34.
6. Спэнсэр В.Кимбалл, “The Things of Eternity—Stand We in Jeopardy?” *Ensign*, 1977 оны 1-р сар, 3.



# ГЭР ОРОН

## бол суралцах амин чухал газар юм

Сүм дээр суралцах нь гэр орондоо суралцахыг дэмжиж байгаа үед та сайн мэдээний дагуу амьдрах хүчтэй үндэс суурийг бий болгодог.


“Ирэх долоо хоногийн хичээлдээ бэлтгэж даалгаварт өгсөн хэсгүүдийг уншаарай.” Эдгээр үг танил сонсогдож байна уу? Эдгээр үгийг ихэвчлэн Сүмийн хичээлийн төгсгөлд даалгавар өгч буй багш хэлдэг.

Ням гаргийн хичээлдээ бэлтгэлтэй байх нь мэдээж чухал хэдий ч заримдаа танд ням гарагт бүрэн бэлтгэлтэй байхын тулд суралцаж мөн тунгаан бодох нь таны гол зорилго мэт санагддаг уу?

Үнэндээ, энэ нь эсрэгээрээ байх хэрэгтэй байдаг.

Сүмийн бүхий л “сургаал, хөтөлбөр болон үйл ажиллагаанууд нь гэр оронд төвлөрч, Сүмээр дэмжигдсэн байдаг.”<sup>1</sup> Энэ нь манай Сүмийн цуглаанууд үнэндээ хувь хүн болон гэр бүлүүдийг суралцахад нь дэмждэг гэсэн үг юм. Тэргүүлэх бишоп Гари И. Стивэнсон заахдаа “зааж мөн суралцах хамгийн чухал газар бол гэр юм”<sup>2</sup> гэжээ. Суралцах мөн заах нь гэр оронд төвлөрсөн үед тэр нь хөрвөлт рүү удирдах хүчтэй байдаг.

Энэ бол [annualtraining.lds.org](http://annualtraining.lds.org) хаягаар орж онлайнгаар үзэх боломжтой, Гэр орон болон Сүм дээр суралцах мөн заах нь нэртэй туслах бүлгийн жил тутмын 2014 оны сургалтын захиас юм. “Бидний хэн нь ч ариун ёслолын танхим, цуглааны байруудад заагддаг сургаалуудын ач холбогдлыг бууруулдаггүй” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд хэлжээ. “Бид бүгд үүнийг амьдралынхаа турш хийсээр ирсэн бөгөөд одоо үүнийг сүмээс гадуурх амьдралдаа 7 хоногийн 24 цагийн турш байлгахыг хүсэж байна.”<sup>3</sup> Та гэр бүлийнхээ амьдралд өдөр бүрийн цаг мөч бүрийг 7 хоногийн 24 цагийн турш суралцахад зориулснаар таныг болон гэр бүлийг тань сүнслэг хоргодох газар болон хамгаалалтаар хангаж чадах “суралцах өргөөндөө” зориулан та хүчирхэг үндэс суурийг бий болгож чадна. (С ба Г 88:119)





## ГЭРТЭЭ СУРАЛЦАХ НЬ

Та үр дүнгүүдийг үргэлж тэр даруй харахгүй байж болох ч жирийн мөчүүдийг өдөр тутмын амьдралынхаа суралцах мөн заах давуу тал болгон ашиглах үед энэ нь хүчирхэг үр нөлөөтэй байж чадна. Хэд хэдэн гэр бүл тэрхүү нөлөөг өөрсдийн амьдралд олж харсан байна.

### Жирийн мөчүүд

“Сайн мэдээтэй холбоотой зарим сэдвийн талаар албан ёсоор ярилцахад хэцүү санагдаж болох үеүд байдаг. Албан бусаар заах мөчүүд нь биднийг хүүхдүүдэд чухал хичээлүүдийг заахад үнэхээр их адисалдаг

юм. Мөн албан ёсоор заах мөчүүдээс илүүтэй өдөрт албан бусаар заах мөчүүд илүү их тохиолддог. Тиймээс бид хүүхдүүдэд чухал зарчмуудыг заахдаа эдгээр боломжийг бүрэн ашигладаг. Жишээ нь, би хүнсний

дэлгүүрээс юм худалдаж авахдаа шударга байдлын талаар заадаг. Хүүхдүүд маань зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хараад тэдгээрийг илүү амархан сурдаг.”

*Мона Вилланува, Филиппин*







## **Зууш идэх зуураа дотно харилцаагаа сайжруулах нь**

“Албан бусаар заах мөчүүд нь хүүхдүүдтэйгээ илүү сайн харилцаатай байхад надад тусалсан юм. Бид сургууль тарсны дараа гал тогооны ширээн дээр сууж, зууш идэх зуураа сургууль дээр нь юу болсон талаар ярилцдаг. Ихэнхдээ тэдний нэг нь найзынхаа хэлсэн зүйлийг эсвэл хэн нэгэн ямар нэгэн зүйлийг хэлж эсвэл хийх үед ямар мэдрэмж төрснөө хуваалцдаг. Дараа нь би хувийн гэрчлэлээ хуваалцаж, хүүхдүүд маань тухайн нөхцөлд юу мэдэрсэн талаар ярилцдаг. Хүүхдүүдээ чөлөөтэй байх үед нь илэн далангүй ярилцсанаар хэрэгцээ гарах үед эцэг эх нь сонсоно гэдэгт тэд итгэдэг учраас чухал зүйлийнхээ талаар ярилцахад илүү бэлэн байдаг гэж би боддог.”

*Алисон Фрост, Грек*

## **Гэрээс сургууль хүрэх зам дахь харилцан ярианууд**

“Би өглөө бүр охидоо сургуульд нь автобусаар хүргэж өгдөг учраас бидэнд ярилцах маш олон боломж гардаг. Бид саяхан эхнэр, нөхөр хоёрын маргалдаж байгааг харсан юм. Охид маань түргэн гэгч нь над руу эргэж хараад намайг ямар нэг зүйл хэлэхийг хүлээж байв. Би оронд нь болсон зүйлийн талаар юу мэдэрснийг нь тэднээс асуув. Тэд эрэгтэй хүн эхнэртэйгээ хэзээ ч ийм аргаар ярьж болохгүй гэж бодсон тухайгаа надад хэлэв. Үүний дараа бид гэрлэлт ба харилцааны талаар ярилцсан юм. Автобусанд өнгөрүүлсэн 30 минут нь биднийг маш их сэнхрүүлж мөн бидэнд урам өгсөн аялал болж хувирсан.”

*Марио Лорэнз, Гватемал*





## Анхаарал халамжийн тойрог

“Эхнэр бид хоёр хүүхдүүдээ заах нь удирдагчдын үүргээс илүүтэй бидний хамгийн анхны үүрэг гэж ойлгодог. Гэвч бид тэдний хийдэг зүйлүүдэд нь талархалтай байдаг бөгөөд чадах чинээгээрээ тэдэнд тусалдаг. Манай тойрог өсвөр үеийнхэн болон хүүхдүүдэд үнэхээр их анхаарал хандуулж, эцэг эхийнх нь хийсэн зүйлүүд дээр үндэслэсэн бүрэн чадавхаа олж харахад тэдэнд туслахын тулд чадах бүхнээ хийдэг агуу удирдагчидтай билээ. Би цөөхөн хэдэн тохиолдлоор бишоптойгоо уулзсан. Би өсвөр үеийнхний удирдагчидтай маш сайн харилцаатай байдаг бөгөөд ихэвчлэн хүүхдүүдийнхээ талаар болон тэдний өсөлт хөгжлийн талаар асуудаг. Хүүхдүүдийнхээ өсөлтийн талаар байнга асууж ярилцдаг маань тэдэнд нэг бүрчлэн хэрхэн тусалж чадахаа ойлгоход бид бүгдэд тусалдаг.”

*Жэссе Н.Арумугам, Өмнөд Африк*





**ХРИСТ  
ТОЛГОДЫН  
ЭНГЭРТ МӨН  
ГЭР ОРОНД  
ЗААДАГ  
БАЙВ**

“Аврагч гарамгай багш [байсан].

. . . Бид Түүний тохинууллын ихэнх хэсгийг нь зааж байгаагаар нь олж хардаг. Гэвч Тэр сүмд бараг заадаггүй байв.

Тэр хүмүүс байгаа газар заадаг байв. Тэрээр олны хөлийн газар, хөдөө хээр замд ч, толгодын энгэрт мөн нуурын эргүүдээр болон гэр оронд заадаг байв.”

annualtraining.lds.org хаяг дээрх “Learning and Teaching in the Home and the Church—the Home” (2014 оны туслах бүлгийн сургалтын видео бичлэг) дэх Жэффри Р.Холландын хэсэг

## Суаруу дахь хүч чадал

“Суаруудыг судлах нь Христтэй адил болохын тулд Түүний талаар болон Түүний зан чанаруудаас суралцахад надад тусалдаг. Мөн энэ нь амьдралын сорилтууд болон Сатаны илгээдэг уруу таталтуудыг даван туулахад бэлтгэж болохын тулд намайг удирдаж, эдгээр сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлж болохыг заадаг Сүнснийг надад илүү ихээр өгдөг юм. Миний амьдрал энэ адислалгүйгээр Бурханы хүү байх чадавхдаа хүрч чадахгүй гэдгээ би мэднэ.”

*Нафан Вүдворд, Англи*

## СҮМ ДЭЭР СУРАЛЦАХ НЬ: Багшийн мэдэх хэрэгтэй 10 зарчим

Гэртээ суралцах болон заах хүчийг хүчирхэгжүүлэхээс гадна бид Сүм дээрх ангийн туршлагыг бас хүчирхэгжүүлж чадна. Багш нар эдгээр 10 зарчмыг хэрэгжүүлснээрээ зааж байгаа хүмүүсийнхээ хөрвөлтийг дэмжих болно.

1. Ангийн гишүүдийн хэрэгцээг тодорхойлохдоо багшлах гол үүрэгтэй эцэг эхчүүдтэй зөвлөлдөж, тэдгээр хэрэгцээнд нь тохируулан заа.
2. Сүнсээр бэлдэж мөн заа. Сүнсээр хөтлөгдөх ярилцлагуудыг бий болгох асуултауд болон суралцах үйл ажиллагаануудыг тодорхойлж, ангийн гишүүдийг сүнслэгээр тэжээ.
3. Хичээлүүдэд тохируулж биш харин хүмүүст заа.
4. Сайн мэдээний үндсэн зарчмуудад анхаарлаа хандуул.
5. Хичээлийн бүх материалыг багтаах гэж хичээснээс нэгээс хоёр гол зарчмыг илүү гүнзгий заа.
6. Хүн бүрийг оролцуулж, Сүнсийг урь (С ба Г 88:122-ыг үзнэ үү).
7. Гэртээ очоод, зөвхөн унших ямар нэгэн зүйл өгөхөөс илүүтэй, үүний дагуу амьдралдаа үйлдэл хийх хүчтэй урилга өг.
8. Хичээлийн төгсгөлд болон Сүнс таныг өдөөх бүрд сургаалын талаарх гэрчлэлээ хуваалц.
9. Сайн мэдээний дагуу амьдарч, “гэр орноо цэгцэл” (С ба Г 93:43–44, 50-ийг үзнэ үү).
10. Өдөр тутмын амьдралдаа албан бус мөчүүдийг ашиглан, үргэлжлүүлэн заах арга замуудыг ол.

### ЭШЛЭЛҮҮД

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 1.4.
2. annualtraining.lds.org хаяг дээрх “The Ward Council—We’re All in This Together” (туслах бүлгийн 2014 оны сургалтын видео бичлэг) дэх Гари И.Стивэнсоний хэсэг
3. annualtraining.lds.org хаяг дээрх “Learning and Teaching in the Home and the Church—the Home” (2014 оны туслах бүлгийн сургалтын видео бичлэг) дэх Жэффри Р.Холландын хэсэг



# УСНЫГ МАНДАЛ ДЭЭР

*Би Тэнгэрлэг Эцэгээс миний сэтгэлийн зовнил, шаналлыг холдуулахыг хүсэн, гуйж байлаа. Гэвч эдгээр бэрхшээлгүйгээр Түүний намайг аваачих гэж байсан “амлагдсан нутагт” би хүрч чадахгүй байх байсан биз ээ.*

**Жон Варнэр**

**Б**и коллеж төгсөнөөсөө хойш зургаа орчим сарын дараа сандрал, сэтгэл санааны зовнил, сэтгэлийн хямралд автаж эхлэв. Би эдгээр мэдрэмж хаанаас ирж байгааг мэдээгүй ч тэдгээр нь хүчтэй бөгөөд маш хэцүү байлаа.

Би юунд ч анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байв. Ажил дээр хүлээсэн шинэ үүрэг даалгавар санааг минь зовоож, би тайван ч сууж чадахгүй байв. Оюун санаа минь тогтворгүй болж, зүрх дэлбэрэх гэж буй мэт хүчтэй цохилж байв. Ийм байдал хэдэн өдрөөр үргэлжилж, би ажлаасаа гэртээ ирээд буйдан дээр унаад өгдөг байлаа. Нэг л мэдэхэд үдэш өнгөрч, дахин нэг ажлын өдөр эхэлдэг байв.

Иймэрхүү мэдрэмжүүд хэдэн сар үргэлжилсэн бөгөөд

шинэ ажилд орж, мэргэжлийн хүнээс тусламж авсан ч нэмэр болсонгүй.

Би өглөө бүр ажилдаа явах замдаа тухайн өдрийг давж гаран, гэртээ эхнэр, охин хоёр дээрээ ирэх хүч чадлын төлөө залбирдаг байв. Надад тохиолдсон бэрхшээл арилаагүй бөгөөд би ихэнхдээ бууж өгмөөр санагддаг байв. Олон өдөр тэнгэрээс тусламж гуйхад нүдийг минь нулимс бүрхдэг байсан. Би өмнөхөөсөө илүү чин сэтгэлээсээ залбирч, энэ бэрхшээлийг ойлгоход минь тусалж, үүнийг надаас холдуулахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйдаг байлаа.

Би Сүнснийг мэдрэхгүй үедээ харанхуйд төөрсөн мэт санагдаж, гуньж гутардаг байв. Гэвч Сүнс намайг найдваргүй байдлаас өргөн гаргах үед би дараагийн

залбирал хүртэл тэвчих итгэлийг олдог байсан. Би хоол идэх үеийн юм уу орой бүрийн хайхрамжгүй залбирлаас илүүтэй Тэнгэрлэг Эцэгтээ найдах болсон юм. Үүний ачаар би Түүнтэй илүү ойр дотно болсон билээ.

### Давалгаан дээр шидэгдсэн нь

Би сэтгэлийн зовнил, гутрал дунд “агуу гүнийг” (Ифер 2:25) гаталсан жаредчуудын түүхийг дахин уншсан юм. Тэд усан онгоцондоо суух үед чухам юут хүсэн хүлээж байсныг би зөвхөн төсөөлж л чадна. Тэдний аялал аюултай байсан ч тэд “бүх нутгаас дээгүүр сонгомол нутаг руу” (Ифер 2:15) чиглэн яваагаа мэдэж байсан юм.

Тэдний аяллын талаар бид:

“Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан, амлагдсан нутгийн зүг усан дээгүүр ширүүн салхи үлээж байхаар болгосон аж; мөн тийн тэд салхины өмнө далайн давалгаанд шидэгдэн явав.

“Мөнхүү улиран тохиох дор тэдний дээр задрах уулс мэт давалгаанууд, мөн түүнчлэн салхины догшноос үүссэн агуу хийгээд аймшигт их шуургануудаас болон далайн гүнд тэд олонтаа автагдсан бөлгөө.

“... Тэд их усанд хучигдсан үедээ Их Эзэнд залбиран гуйж, мөн тэрбээр тэднийг дахин усны мандал дээр гаргаж байв.

“Мөнхүү улиран тохиох дор тэднийг усны мандал дээр байх үест салхи амлагдсан нутаг тийш үлээхээ хэзээ ч зогссонгүй; мөн тийн тэд салхины өмнө урагш туугдсан авай” (Ифер 6:5–8) хэмээн уншдаг.

Эдгээр шүлэг надад дотно болсон юм. Би өөрийнхөө усан онгоцонд байгаа юм шиг мэдэрч байсан бөгөөд намайг зовнилын салхи нүдэж, гутралын давалгаанууд бүрхэн, хямралын гүнд живүүлж байсан мэт санагдлаа. Би усаар “хүрээлэгдсэн” үедээ Их Эзэнд хандан залбирч, усны гадаргуу дээр гарч ирэвч дахиад л живдэг байв.

“Салхи амлагдсан нутаг тийш үлээхээ хэзээ ч зогссонгүй; мөн тийн тэд салхины өмнө урагш туугдсан авай” хэмээн би 8-р шүлгийг дахин уншлаа (онцлон тэмдэглэлт нэмэгдсэн). Тэгээд энэ нь надад хүчтэй нөлөөлөв. Усан онгоцнуудыг нөмрөх уул лугаа адил давалгаанууд жаредчуудыг аяллынх нь үед адисалсан юм. Би Тэнгэрлэг Эцэгээс салхи, давалгааг намжаахыг гуйж байлаа. Гэвч эдгээр бэрхшээл байгаагүйсэн бол Түүний намайг аваачих гэж байсан “амлагдсан нутагт” би хүрч чадахгүй байх байсан биз ээ.

Эдгээр шүлэг миний амьдралыг үзэх үзлийг өөрчилсөн юм. Сэтгэлийн хямрал, зовнил маань миний Тэнгэрлэг Эцэгт найдах найдварыг нэмэгдүүлсэн. Салхи, давалгаа байгаагүйсэн бол би Бурханыг одоо мэдэж байгаа шигээ мэдэж чадахгүй байх байсан, бас жаредчууд амлагдсан нутагт хэзээ ч хүрэхгүй байх байсан.

Харин одоо, энэ туршлагаас хойш хэдэн жил өнгөрөхөд сэтгэл санааны зовнилын салхи үлээхээ больж, хямралын давалгаа намайг нүдэхээ больсон. Гэвч хэрэв шуурга эргэн ирвэл би Их Эзэнийг дуудаж, Түүнд талархах болно, учир нь дөлгөөн тэнгис усан онгоцыг амлагдсан нутаг руу удирддаггүй, шуургатай тэнгис л удирддаг юм. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*



### ИТГЭЛЭЭ ХЭЗЭЭ Ч БҮҮ АЛД

“Та эсвэл таны хайртай хүмүүс сэтгэцийн эсвэл сэтгэл санааны хямралд орох үед та хэрхэн хандах вэ? Юуны түрүүнд таны ойлгож чадахаас ч илүү таныг хайрладаг Тэнгэр дэх Эцэгтээ итгэх итгэлээ

хэзээ ч бүү алд. . . .

“Таны амьдралд Их Эзэний Сүнснийг авчирдаг бөгөөд цаг хугацааны уртад шалгарсан шашны зан үйлээ итгэлтэй дагаарай. Та өөрийнхөө сүнслэг сайн сайхан байдлын төлөө түлхүүрүүдийг атгадаг хүмүүсээс зөвлөгөө ав. Санваарын адислалуудыг эрэлхийлж, эрхэмлэн хайрлаарай. Ариун ёслолоос долоо хоног бүр хүртэж, Есүс Христийн Цагаатгалын төгс амлалтуудаас зууран баригтун. . . .

“... Цөхөрсөн оюун санаа нь хугарсан яс, шархалсан зүрх сэтгэл эдгэрдэгтэй адил эдгэрнэ. Бурхан тэдгээр засварыг хийж байх үед бид тэр хүмүүст энэрэнгүй, шүүмжлэлгүй, сайхан сэтгэлээр хандаж туслах ёстой.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Бие биед энэрэнгүй хандагсаа,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 40, 41.



# ЧИЛИ

## ДЭХ ХӨРВӨЛТ БА ӨӨРЧЛӨЛТ

*Анхны баптисмууд 1956 онд болжээ. Өдгөө сүм Чилид 1 ариун сүм, 9 номлол, 74 гадастай бөгөөд бараг 600 000 гишүүнтэй болоод байна.*

### **Нэстор Курбэло**

Сүмийн түүхийн зөвлөх, Өмнөд Америкийн Өмнөд бүс

**Т**үүхийн 58 жилийн турш Чили дэх Сүмийн гишүүд чиглэлээ өөрчилж, амьдралаа бошиглогчдын чиглүүлсэн зүг рүү хандуулах чадвараа нотлон харуулсан юм. Энэхүү хандлага нь өнгөрсөн хагас зууны турш энэ улс дахь Сүмийн гайхалтай өсөлт хөгжилтөд хувь нэмрээ оруулсан байна. Өнөөдөр Чили бараг 600 000 гишүүнтэй байгаа бөгөөд 30 чили хүн тутмын 1 нь Сүмийн гишүүн болоод байна.<sup>1</sup>

### **Төлөөлөгч Чилид айлчилсан нь**

1851 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Парли П.Пратт (1807–1857) Сүмийг зохион байгуулах санаа өвөрлөн, Валпараисод иржээ. Гэсэн ч тэр өөрөө болон түүний хамтрагчид испаниар ярьдаггүй байлаа. Тэд санхүүгийн тун хомсхон эх үүсвэртэй байв. Мөн тус улсад шашны эрх чөлөө байгаагүй учраас сүмийг зохион байгуулах боломж тэдэнд байсангүй.



*Багш нар болон тэдний дөрөвдүгээр ангийн сурагчид сүмийн эзэмшлийн сургууль Колежиод. А.Д.Палмэр, ойролцоогоор 1966 оны үед.*

Ахлагч Пратт ерөнхийлөгч Бригам Янгад (1801–1877) “Мормоны Ном болон зарим хямдхан хэвлэмэл материалыг испани хэлэнд орчуулж, хэвлэх хэрэгтэй байна. Ингэснээр амьд санваар тэдэнд зориулсан ямар нэг унших зүйл болох Бурханы амлалт, эртний хүмүүсийн залбирлууд, итгэл болон Бурханы Сүнсний хүч зэрэг нь Израилийн угсааг сэргээх үйлсэд тэдэнтэй хамт ажилласнаар түлхүүр нь энэ үндэстэн рүү эргэх болно” гэсэн саналыг хэлсэн байна.<sup>2</sup>

### **Сүм зохион байгуулагдав**

Ахлагч Пратт чармайсан хэдий ч Чилид Сүм албан ёсоор зохион байгуулагдах хүртэл 100 гаруй жил өнгөрсөн байна. 1956 онд ахлагч Жозеф Бэнгли, Вэрлэ Аллрэд хоёр Аргентины номлолоос Чилид сайн мэдээг номлохоор илгээгдсэн бөгөөд энэ үед шашны эрх чөлөө нэлээд бэхэжсэн байлаа. Сантьягод Панамаас нүүж ирэн, номлогчдыг ирээсэй хэмээн найдаж байсан Фодерингхамын гэр бүл эдгээр номлогчид дэмжлэг тусалцаа үзүүлж байв.

Чили дэх анхны баптисмууд 1956 оны 11-р сарын 25-нд Сантьягогийн нэгэн клубт болсон байна. Ахлагч

Аллрэд “Бид нар мандахаас өмнө клубт очсон бөгөөд үйл ажиллагаагаа залбирал, богино ярилцлагатай хийв. Би Гарсиа ахтай хамт усанд орж, эхлээд түүнд, дараа нь найман хүнд баптисм хүртээсэн. Энэ маш онцгой тохиолдол байлаа. Бид бүгдийн мэдэрсэн зүйл мартагдашгүй. . . . Гарсиагийн болон Салданогийн гэр бүл бас Ланзаротти эгч зэрэг эдгээр гишүүн Чили дэх сүмийн анхдагчид болсон бөгөөд тэд бүгдээрээ нас барах хүртлээ итгэлтэй хэвээр үлдсэн гэдэгт би итгэлтэй байна” гэж дурсан ярьсан юм.<sup>3</sup>

### **Удирдагчдыг дуудав**

1959 оны 2-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) Чилид айлчилж, орон нутгийн удирдагчдыг хөгжүүлэх хэрэгтэй байгааг онцолсон байна. Орон нутгийн анхны удирдагчдын нэг нь Карлос Сифуэнтэс байсан бөгөөд тэрээр номлолын ерөнхийлөгч Роберт Бэртоны зөвлөх байсан юм. Хожим нь Бүсийн далын гишүүн болсон ахлагч Жулио Жарамилло: “Би баптисм хүртсэнийхээ дараа санваарын нэгэн хуралд уригдаж очихдоо



Сифуэнтэс ахтай анх танилцсан. Хурал эхлэх үед тэрээр индэр дээр гарч ирсэн бөгөөд миний харсан ганцхан зүйл бол түүний бохир, хар хумснууд байв. Би дотроо “Энэ эрэгтэй бохир гартай байж яаж номлолын ерөнхийлөгчийн хажууд хурал хөтөлж чадаж байна аа?” гэж бодлоо. Түүнийг ярих хүртэл би ингэж бодож байсан бөгөөд түүний сүнсийг мэдэрсний дараа би бүх зүйлийг мартсан. Энгийн үгсээр тэр бидэнд агуу санааг ойлгуулсан юм. Тэрээр хүнд машин механизмын засварчин байсан ба тэр бямба гарагт оройтож ажиллаад дараа нь гараа цэвэрлэдэг ч мухлагт нь хомс байдаг зүйлүүдийн улмаас тос маслоо бүрэн арилгаж чаддаггүй байв. Тэр үед, яг тэндээс би хүмүүсийг

болон номлогчдыг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсан юм” хэмээн хэлжээ.<sup>5</sup>

Чилид институт, семинарын хөтөлбөр 1972 онд хэрэгжиж эхэлжээ. Эхэндээ суралцагчид долоо хоногт нэг удаа цугладаг гэрийн семинарын хөтөлбөрт хамрагдаж байв. Удалгүй илүү ойр ойрхон цугладаг ангиуд зохион байгуулагдав. Эдгээр хөтөлбөр нь тус улсын залуучуудыг адисалж, тэднийг бүрэн цагийн номлогчоор үйлчлэхэд бэлтгэхэд нь тусалсан юм. Далын гишүүн асан, ахлагч Эдуардо Аяала анхны семинарын багш нарын нэг байсан бөгөөд хожим нь Чилийн сүмийн боловсролын системд ажиллажээ. Тэрээр “Их Эзэн тухайн үед тэнд байсан залуучуудыг

1851 он: Ахлагч Парли П. Пратт Валпараисо руу аялсан боловч Чилид сүмийг зохион байгуулах боломжгүй байв

► 1926 он: Ахлагч Мэлвин Ж.Баллард нэгэн гэрчлэлийн цуглаан дээр Өмнөд Америк дахь Сүмийн ирээдүйн өсөлт, хүч чадлын талаар бошиглов



► 1956 он: Анхны номлогчид болох Жозеф С.Бэнтли, Вэрлэ М.Алфред хоёр Сантьягод ирж, анхны баптисмууд болов



гадаад төрхөөр нь шүүх бус харин хэн бэ гэдгээр нь үнэлэхийг сурсан юм” гэж туршлагаа хуваалцжээ.<sup>4</sup>

### Өсөж буй үеийнхнийг хүчирхэгжүүлэх нь

1960-1970-аад онд Чили дэх Сүм өсөн нэмэгдэж буй туршлагатай орон нутгийн удирдагчдаар төдийгүй шинэ барилга, боловсролын хөтөлбөрүүдээр хүчирхэгжсэн билээ. Энэ нь сүмийн цуглааны болон сургууль, семинар, институтийн байруудыг барьсан явдал байв.

1964 оны 3-р сард сүмийн эзэмшлийн анхны хоёр бага сургууль Чилид байгуулагдав. Удалгүй хэд хэдэн сургууль нээгдэж, элсэгчдийн тоо 2600-гаас давлаа. 1970 оны сүүлч, 1980-аад оны эхэн үе гэхэд улсын сургуулиудын тоо хангалттай олон болсон учраас Сүм Чили дэх сургуулиудаа хааснаа зарласан юм.

Боловсролын хөтөлбөрийн талаар Бүсийн далын гишүүн асан, ахлагч Эдуардо А.Ламартинэ “Чили дэх сургуулиуд нь мянга мянган хүүхдийн боловсрол болон сүнсэлэг байдлын сургалтад маш их нөлөө үзүүлсэн бөгөөд тэд дараагийн жилүүдэд төрөн гарсан удирдагчид

Темуко дахь шашны институт нь Чилийн 50 институтийн нэг юм.





1996 онд ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Сантьягод болсон чуулган дээр Чилийн 48000 хожмын үеийн гэгээн-тэнд хандаж үг хэлэв.

сонгосон бөгөөд тэдний олон нь эргэж ирсэн номлогчид ба сайн гэр бүлтэй агуу удирдагчид юм. . . . Миний хувьд институт, семинар нь эх оронд маань үймээн самуунтай байсан үед авралын од байсан бөгөөд би боловсролын системд ажиллаж байгаадаа баяртай байна” гэж хэлжээ.<sup>6</sup>

### Анхны гадас

1972 оны 11-р сард тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч байсан Гордон Б.Хинкли (1910–2008) Чилийн Сантьяго гадсыг зохион байгуулж, Карлос Сифуэнтэсийг ерөнхийлөгчөөр нь дуудав.

Гадас зохион байгуулах бэлтгэл нь Чилийн гэгээнтнүүдийн зан чанарыг болон бошиглогчдыг дагах хүслийг харуулсан юм. Ахлагч Хинкли гадас зохион байгуулахын тулд хэдэн сарын өмнө Чилид ирсэн байна. Гэвч ярилцлагууд хийгдсэний дараа энэ ажил хойшлогдсон юм. Тэр үед олон хүн санхүүгийн асуудалтай байснаас гадна зарим гишүүн аравны нэгийн хуулийн дагуу амьдрах тал дээр асуудалтай байв.

Ахлагч Хинкли “Би зургаан сарын дараа эргэж ирээд

ярилцлага хийж байхдаа итгэл цэцэглэж байгааг олж харсан. Тэд Их Эзэний өмнө шударга алхаж байсан учраас гадас зохион байгуулагдаж, түүнээс хойш тэд өсөж, дэгжсэн юм” хэмээн тайлбарлажээ.<sup>7</sup>

### Хил дээрх анхдагчид

Өнөөдөр Чилийн хойд хязгаар дахь хот Арикад хоёр гадас байна. Арикагийн анхны хөрвөгчид болох Гладис ба Жуан Бэнавидезын түүх нь Чили даяар Сүмийг зохион байгуулахад илэрсэн анхдагчийн сүнс болон тэнгэрлэг нөлөөний жишээ юм.

Бэнивадез ах 1961 онд Сүмтэй танилцсан бөгөөд хэсэг цаас түүн рүү хийсэж ирсэн байна. “Эдгээр нь *Reader's Digest Selections* сэтгүүлийн хуудсууд байсан ба ‘мормончуудын’ болон тэдний амьдрал, итгэл бишрэлийн тухай нэлээд нухацтай бичсэн өгүүлэл байсан” гэж тэр хэлжээ.

Үүнээс хойш удалгүй түүнд нэгэн хүнд өвчин туссан бөгөөд Сантьягод очиж эмчлүүлэх шаардлагатай болсон байна. “Тэнд байхдаа би эгч дээрээ айлчлан очиж, түүнийг сүмийн гишүүн болсон гэдгийг нь

мэдсэн” гэж тэр хэлжээ. “Эгч маань намайг онцгой чуулганд урьсан. Би нээлтийн залбирлыг сонсож мөн үгсийг нь оюундаа дагах үед би бүхэл биеэрээ агуу баяр баяслыг мэдэрсэн бөгөөд Ариун Сүнсний нөлөөг таньсан юм. Чуулганы дараа номлогчид айлчлан ирсэн эрх мэдэлтэн болох, тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан ахлагч Эзра Тафт Бэнсонтой (1899–1994) намайг гар бариулахаар авч явлаа.”

Бэнивадес ах Арикад буцаж очоод өөрийнхөө туршлагыг найз охин буюу

1973 онд санхүү, нийгмийн эмх замбараагүй байдал нь армийн эрх барилт ба дарангуйлал бий болоход нөлөөлсөн бөгөөд энэ тогтолцоо 1990 он хүртэл үргэлжилсэн байна. Хэдийгээр өнөөдөр Чили улс хөгжин цэцэглэж буй ардчилсан улс ч гэлээ, өнгөрсөн тэрхүү хорин жил гишүүдийн хувьд хүнд үе байсан юм. Армийн дарангуйллыг эсэргүүцэж байсан бүлэглэл сүмийн цуглааны байр руу болон гишүүд рүү дайралт хийдэг байв. Учир нь Сүмийг Америкийн Нэгдсэн Улсын засгийн газрын ашиг сонирхлыг төлөөлдөг хэмээн



“Би 12 настай байхдаа сайн мэдээний захиастай танилцсан бөгөөд тэр даруйдаа энэ нь үнэн болохыг мэдсэн. Одоо дөчин зургаан жил өнгөрч, энэ хугацаанд би адислагдсаар ирсэн юм. Чадах бүхнээ хийж, бүхнээ зориулсан олон удирдагчдаа талархъя. Өсөж буй үеийнхнийг мэдэж мөн тэдэнтэй хамт байгаагийнхаа хувьд би баяртай байдаг бөгөөд бошиглогчдод буй Чилийн талаарх алсын хараа өргөсөх үед Их Эзэн энэ улсыг адисалсаар байх болно гэдэгт би итгэдэг.”<sup>12</sup>

**Ахлагч Хорхе Ф.Зэбаллос, Чилээс төрсөн Далын гишүүн**

1957 он: Сүм Чилид албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөв

1960 он: Концепционд хүчтэй газар хөдлөлт болж, Сүм хүмүүнлэгийн тусламж илгээв

► 1961 он: Чилийн номлол зохион байгуулагдаж, Асаэл Дэлбэрт Палмэр ерөнхийлөгчөөр дуудагдав



1962 он: Анхны ХҮГ цуглааны байрны шав тавих ёслол Сантьягод болов

одоогийн эхнэр Глэдис Агуилартай хуваалцжээ. Хэдэн өдрийн дараа Глэдис хоёр номлогчийг байшингийнх нь хажуугаар явахыг харсан байна. “Бид бушуухан тэдний араас явсан” хэмээн Бэнивадес ах хэллээ. “1961 оны 7-р сарын 1-нд бид эхнэрийнхээ гэр бүлтэй хамт баптисм хүртсэн. Өнөөдөр бидэнд сүмд төрсөн хүүхдүүд, ач зээ нар байна. Сүмийн талаарх мэдээллийг надад хүргэж ирсэн тэр салхины төлөө би Их Эзэнд талархдаг.”<sup>8</sup>

### Хүнд үе

1970 оны сонгуулиар доктор Сальвадор Аллэндэ ерөнхийлөгч болж, марксист засгийн газар байгуулжээ. Сүмийн гишүүд хүнсний болон эмийн хомсдол, номлогчдыг өдөж хоргоох болон хэвлэл мэдээллийн сөрөг хандлага зэргээс болж ихээхэн хүндрэлийг туулжээ.

тэд боджээ. Тухайн үед гадасны ерөнхийлөгч байсан ахлагч Аяала “Бид ерөнхий эрх мэдэлтнүүдтэй уулзахад тэд ‘Мэргэн ухаантай байж, их залбиран, зөв зүйлийг хийгээрэй, ингэснээр гишүүд цугларагсдын дунд дэг жаягтай байх болно’ гэж бидэнд хэлдэг байсан” гэжээ.<sup>9</sup>

1980-аад онд улсын санхүүгийн хүндрэл болон Чили орныг нийгмийг хагаралд хүргэсэн улс төрийн зөрчилдөөн байсан ч гэсэн Сүм хурдацтай өссөн юм. 1985–1970 оны хооронд Чили дэх Сүмийн гишүүдийн тоо 15728-аас 169361 болж нэмэгдсэн байна.

### Сантьягогийн ариун сүм

1980 онд гишүүд Чилийн Сантьягод ариун сүм баригдах болно гэсэн зарлалаар адислагдсан юм.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл ариун сүмийн газрыг онцгойлон адислахдаа



тухайн үедээ бие нь маш сул дорой байсан ч уг айлчлал 1959 оноос хойш хамт ажиллаж ирсэн Өмнөд Америкийн гэгээнтнүүдийг хайрлах түүний хайрыг харуулсан юм. Тухайн үед Кимбалл эгчийн хэлмэрч байсан Адриана Гуэрра дэ Сэпулвэда эгч “Би тэнгэр элчийн төрхтэй жижигхэн биетэй бошиглогчийг хараад үйлж эхэлсэн. Түүнтэй ярих үг ч олдохгүй байв. Энэ нь миний хувьд амьд бошиглогчийн дэргэд зогссон анхны тохиолдол байсан юм. Их Эзэний тослогдсон үйлчлэгчийг дэлхий дээр, тэр тусмаа эх

сургахад тусалж мөн олон зуун тойрог ба хэдэн арван гадасны дахин зохион байгуулалт, хаалт, нэгдэх зэрэг ажлыг хариуцсан байна. Сүм энэ улсад хурдацтай хөгжиж байсан учраас тэр үеийн дахин зохион байгуулалт болон сургалтууд хэрэгтэй байсан юм. Түүний удирдлага нэгжүүдийг хүчирхэгжүүлэхэд тусалсан бөгөөд Чили дэх Сүмийг ирээдүйд зориулан бэлтгэсэн юм.

Үүний зэрэгцээ ахлагч Холланд Чилид хэд хэдэн чухал холбоог бий болгосон байна. Далын гишүүн, Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөх, ахлагч Карл Б.Пратт

1972 он:  
Чилийн  
анхны гадас  
Сантья-  
год зохион  
байгуулагдав

1977 он: Ерөнхий-  
лөгч Спэнсэр В.  
Кимбалл болон  
бусад ерөнхий  
эрх мэдэлтэн  
оролцсон анхны  
бүсийн чуулган  
Сантьягод болов



◀ 1981 он:  
Номлогчийг  
бэлтгэх төв  
Сантьягод  
байгуулагдав



◀ 1983 он: Ерөн-  
хийлөгч Гордон Б.  
Хинкли Чилийн  
Сантьяго ариун  
сүмийг онцгойлон  
адислав



орондоо харах нь гайхалтай зүйл байсан” гэжээ.<sup>10</sup>

Тэр ариун сүм 1983 онд онцгойлон адислагдсан бөгөөд Өмнөд Америкийн хоёр дахь, испани хэлтэй оронд баригдсан анхны ариун сүм болсон юм.



### Ахлагч Жэффри Р.Холланд Чилид

2002 оны 8-р сард Тэргүүн Зөвлөл Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын хоёр гишүүнийг Сүмийн хоёр бүсийг тэргүүдүүлэхээр томилжээ. Ахлагч Даллин Х.Өүкс Филиппинд, харин ахлагч Жэффри Р.Холланд Чилид томилогдсон байна. Ахлагч Холландын Чилид хийсэн тохинуулал болон үзүүлсэн нөлөө нь хэмжээлшгүй бөгөөд үүний үр нөлөө нь олон үеийнхнийг адислах болно.

Ахлагч Холландын гол анхаарал нь Их Эзэний арга замаар удирдах жишээг харуулах явдал байв. Тэрээр шинэ удирдагчдыг



2010 онд болсон газар хөдлөлтийн дараа Чилийн өсвөр үеийнхэн болон залуучууд Мормон тусламжийн гар болон эрүүл ахуйн иж бүрдлийг хамтад нь хүргэв.

## ЧИЛИ ДЭХ СҮМИЙН ӨСӨЛТ



## ЧИЛИ ДЭХ СҮМ

Тойрог ба салбар: 622

Гадас: 74

Номлол: 9

Ариун сүм: 1 (дахин зарлагдсан 1)

Гэр бүлийн түүхийн төв: 99



◀ 1990 он: Чилийн ахлагч Эдуардо Аяала Далын хоёрдугаар чуулганд дуудагдав



◀ 2002 он: Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р. Холланд Чилийн бүсийн ерөнхийлөгчөөр дуудагдав



▶ 2008 он: Чилийн ахлагч Хорхе Ф.Зэбаллос Далын нэгдүгээр чуулганд дуудагдав

2009 он: Чилийн Консепционы ариун сүм зарлагдав


эдгээр чухал харилцааны заримыг дүрсэлж, “Ахлагч Холланд Рикардо Лагос [Чилийн ерөнхийлөгч] болон түүний эхнэртэй ойрын харилцаа тогтоосон юм. Тэд хэд хэдэн хүмүүнлэгийн тусламжийн төслийг хэрэгжүүлжээ. Ахлагч Холланд Апостолик Нунсиотой [Католик сүмийн дээд албан тушаалтан] мөн Чили дэх өөр чухал хүмүүстэй танил болсон” гэжээ.<sup>11</sup>

### Ирээдүйд итгэ

Ахлагч Парли П.Пратт, Жэффри Р.Холланд нарын хүчин чармайлт, Сантьягод ирсэн анхны номлогчдын золиослолууд, Карлос Сифуэнтэс зэрэг удирдагчийн болон Чилийн анхдагчдын хичээнгүй үйлчлэл ба тавь гаруй жилийн турш Сүмд нэгдсэн олон зуун мянган хүний итгэл хийгээд үйлчлэл нь Чили дэх Сүмийг хүчтэй суурьтай болгосон. Өнөөдөр уг улс нь нэг ариун сүм (дахин нэг баригдахаар зарлагдсан), нэг номлогчийг бэлтгэх төв, 9 номлол болон 74 гадасны өлгий нутаг болсон юм. Ирээдүй нь бүхнийг Христэд ирэхэд урих сүнслэг ажлын хувьд хязгааргүй боломжуудаар дүүрэн байна. ■

### ЭШЛЭЛҮҮД

1. *Deseret News 2013 Church Almanac*, 454-ийг үзнэ үү.
2. *Ахлагч Парли П.Праттын намтар*, хянасан Скот Фэйсэр Проктор, Маурин Жэнсэн Проктор нар (2000), 504.
3. Вэрлэ Алларэд, Нэстор Курбэло, *ХҮГ Өмнөд Америкт: Чили Сур*, боть 1 (2008), 6.
4. Жулио Жарамилло, Нэстор Курбэло, *ХҮГ Өмнөд Америкт: Чили*, боть 1 (2006), 4–5.
5. Эдуардо Адриан Ламартин Агуила, зохиогчид түүхэн хураангуй баримт өгөгдсөн, 2013 оны 11-р сар.
6. Эдуардо Аяала, Нэстор Курбэло, *ХҮГ Өмнөд Америкт: Чили*, боть 1 (2006), 44, 45.
7. Гордон Б.Хинкли, Родолфо Ачивидо А., *Alturas Sagradas: Templo de Santiago de Chile*, 100.
8. Нэстор Курбэло, “Blossoming in the Desert,” *Church News*, 1996 оны 11-р сарын 9, 8–9.
9. Эдуардо Аяала, Нэстор Курбэло, *ХҮГ Өмнөд Америкт: Чили*, боть 1 (2006), 33.
10. Адриана Гуэрра дэ Сепуледа, Нэстор Курбэлогийн, *ХҮГ Өмнөд Америкт: Чили* (2006), 16-д.
11. Карл Б.Пратт, Нэстор Курбэлогийн, *Colombia: investigación histórica*, боть 1 (2010), 16-д.
12. Хорхе Ф.Зэбаллос, зохиогчид илгээсэн захидал, 2014 оны 1-р сар.



**Кэрол Ф.Макконки**  
Залуу эмэгтэйчүүдийн  
ерөнхий ерөнхийлөгчийн  
зөвлөлийн нэгдүгээр  
зөвлөх

# ДАРУУ БАЙДЛЫГ СОНГОХ ЗОРИГ



*Ариун журамт сонголтуудынх нь улмаас өөрсдийг нь шоолдог дэлхийд даруу байдлыг сонгох зоригтой байхад нь туслахын тулд бид хөвгүүд, охиддоо юу зааж чадах вэ?*



**Д**аруу байдал нь яагаад тийм чухал юм бэ? Яагаад урт, хормой, энгэрийн зах эсвэл футболк Их Эзэнд чухал байдаг вэ? Би таван охин, хоёр хүүгийн эх учраас даруу байдал гэдэг сэдэв манай гэрт үе үе яригддаг. Даруу байдлыг заах хамгийн сайн арга бол үүнтэй холбоотой сургаалыг зааж, сайн үлгэр жишээ үзүүлэх явдал гэдгийг би олон жилийн явцад сурсан юм. Үүнтэй холбоотой сургаал нь даруу байдал нь яагаад тийм чухал болохыг ойлгоход хүүхдүүдэд маань тусалж мөн бидний үлгэр жишээ нь даруу байдлын адислалуудыг аз жаргалтай арга замуудаар харуулдаг.

### **Даруу байдал гэж юу вэ?**

Даруу байдал бол энэхүү мөнх бус амьдралд бие махбодоо зохих байдлаар авч явж сурахад бидэнд туслахаар Бурханаас өгөгдсөн зарчим юм. Даруу байдлыг *Итгэлдээ үнэнч байх нь* номонд “Төлөв даруу байдал ба хувцаслалт, гадаад төрх, хэл яриа, зан төлөв дэх даруу байдлын хандлага”<sup>1</sup> гэж тайлбарлажээ. Даруу байдал нь гангараа эсвэл бардамнал биш. Даруу хүмүүс бие махбод юм уу зан чанараа ашиглан дэлхийн алдар хүндийг эрэлхийлэхийг эсвэл өөрсдийнхөө бодит юм уу төсөөлсөн амжилтуудыг эсвэл хүсүүштэй зан чанаруудаа магтуулахыг хүсдэггүй.

Энд хуваалцаж буй даруу байдлын зарчмууд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст болон хөвгүүд, охидод аль алинд нь нөлөөлдгийг санаарай. Бид даруу байдлын үлгэр жишээг үзүүлэхийг хичээдэг ч гэсэн богино дашинз өмсөж эсвэл “солонгорсон өнгийн үс ба олон чамин бөгж” зүүхээр сонгодог хүмүүсийг буруушаадаггүйг санаарай.<sup>2</sup> Бид Их Эзэний тогтоосон жишгүүдэд үргэлж үнэнч байхын зэрэгцээ бусдад нинжин сэтгэл, Христийнхтэй адил хайрыг үзүүлэх талаар үлгэр жишээ үзүүлдэг.

Даруу гадаад төрх, даруу зан төлөвтэй байхын тулд бидний хийдэг сонголтууд нь бид Бурханы хөвгүүд, охидын хувьд өөрсдийн мөн чанарыг ойлгоход тусалдаг бөгөөд ариун газруудад зогсох сонголт хийсэн гэсэн хүчтэй ойлголтыг төрүүлдэг гэдгийг би гэрчилж байна.

“Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдогийг мэддэггүй юм уу? . . . Бурханы сүм ариун бөгөөд энэ нь та нар юм” (1 Коринт 3:16–17) гэсэн сударт би дуртай. Бидний бие бол сүнсний маань ариун сүм юм. Бид энэхүү бие махбодын ариун сүмдээ Ариун Сүнсний нөхөрлөлийг урьдаг. Бид даруу хувцаслаж, даруу зантай байхыг сонгосноороо Бурхан Мөнхийн Эцэг ба Түүний Хүү Есүс Христийн тухай *гэрчлэлтэй байж, уг гэрчлэлийнхээ дагуу амьдардаг* гэдэгт би итгэдэг. Бид гадаад төрх байдлаараа дамжуулан өөрсдийгөө Есүс Христийн дагалдагчид гэдгээ бас Түүний сайн мэдээний дагуу амьдардгаа гэрчилдэг.

### **Даруу байдал яагаад чухал вэ?**

Бид сайн ба муу зүйлс зэрэгцэн оршдог дэлхийд амьдардаг бөгөөд бие махбод нь зөв шударга эсвэл ёс бус зорилгын аль алинд ашиглагдаж болно. Гэхдээ бидний эрхэм бие махбод нь хүн бүрд Бурханаас өгөгдсөн бэлэг гэдгийг бид мэднэ. Бидний бие ариун нандин юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар “Авралын төлөөлөгчөөг ойлгож мэддэг хүмүүсийн хувьд биеийг бузарлах нь Бурханыг эсэргүүцэж байгаа хэрэг [Мозая 2:36–37-г үзнэ үү] бөгөөд Түүний охид, хөвгүүд хэмээх үнэн дүр төрхөөс ухарч байгаа явдал юм” хэмээн заасан.<sup>3</sup> Бид Бурханы мутарт зэмсэг болж, Түүний алдар суут зорилгуудыг тохиолгон авчрахын тулд бие махбодоо халамжилж, хамгаалахаар сонгодог (Алма 26:3-ыг үзнэ үү). Хэрэв бид

Аврагчийн төлөө зогсож, Түүний ажлыг хийх хүсэлтэй бол, хэрэв Аврагч бидний дэргэд зогсож байсан бол бид өмсөж байгаа хувцастайгаа ичихгүй байж чадах байсан болов уу? гэж өөрөөсөө асуух ёстой.

Хувцаслалт, гадаад төрх, бодол санаа ба зан төлөвийн хувьд даруу байх нь хийсэн гэрээнүүд маань биднийг адисалж, хамгаалан, Түүний оршихуйд буцаж очиход бэлтгэх хүч чадлыг бидэнд өгдөг гэдгийг бид ойлгодгийн нотолгоо юм. Бид баптисм хүртэхдээ дэлхийгээс гарч, Бурханы хаант улс руу орсон билээ. Бидний хувьд бүх зүйл өөр байх ёстой. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс: “Бид Түүний хаант улсад байхыг сонгосноороо өөрсдийгөө дэлхийгээс бүрмөсөн тусгаарлах биш харин зайтай байлдадаг. Бидний хувцаслалт даруу, бодол санаа ариун, хэл яриа цэвэр байх болно” гэж заажээ.<sup>4</sup>

Даруу байдал нь биднийг Бурханы оршихуйд очихоор өгсөх үед биднийг гэрээний зам дээр аюулгүй байлгах зарчим юм. Хувцаслалт, гадаад төрх, бодол санаа, зан төлөвөөрөө даруу байх нь бидэнд ариун сүмийн эрхэм нандин гэрээнүүдийг хийж, сахихад тусална. Адам, Ева хоёрыг адисалж, хамгаалахын тулд Бурхан тэдэнд ямааны арьс өгч, тэднийг цэцэрлэгээс гаргахаасаа өмнө хувцасласан юм. Үүнтэй адил, Бурхан мөнх бус амьдралд бидэнд гэрээний хувцсыг өгсөн бөгөөд бидний ариун сүмийн гармент үүнийг төлөөлдөг.

### Даруу байдлын адислалууд юу вэ?

Цэвэр бөгөөд ариун журамт сонголтуудынх нь улмаас өөрсдийг нь шоолдог дэлхийд даруу байдлыг сонгох зоригтой байхад нь туслахын тулд бид хөвгүүд, охиддоо юу зааж чадах вэ? Тэд биднийг бие махбодоо ашиглан бусдын анхаарлыг татах гэж байна гэж боддог уу эсвэл Бурханыг алдаршуулах гэж байгааг хардаг уу?

Бодол санаа, үг яриа, гадаад төрх, зан төлөвөөрөө даруу байх нь бидэнд хүч чадал, өөдрөг бодол санаа өгдөг гурван адислал олж авахад тусалдаг.

1. Даруу байдал нь Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг урьдаг. Ахлагч Хэйлс “Сүнсийг хүлээн авахуйц зохистой байхад даруу байдал зайлшгүй чухал юм” гэж заажээ.<sup>5</sup>

“Өгүүлшгүй Ариун Сүнсний бэлгийг” (С ба Г 121:26) үгүйсгэх ямар ч зүйлийг хийх ёсгүй гэдгээ ойлгоход нь хүүхдүүдээ тусалцаая. Сүнсний эрхэм ариун нөхөрлөлтэй хамт үнэ цэнэтэй хийгээд хүчирхэг сүнсэлэг бэлгүүд ирдгийг мэдэхэд нь тэдэнд тусал. Бурхан



“Оюуныг чинь гэгээрүүлж, сүнсийг чинь баяраар дүүргэх Сүнснээсээ би чамтай хуваалцах болно; . . . эсвээс зөв шударга ёсны зүйлүүдэд хамаарах юуг ч бай бүх зүйлийг чи хүлээж авна гэсэн итгэлээр итгэн чи надаас хүсвэл чи үүгээр мэдэх болно” (С ба Г 11:13–14) хэмээн амласан билээ. Бид хүүхдүүдээ даруу амьдарч, Ариун Сүнсстэй хамт байхуйц зохистой байхад урих үедээ тэдэнд амлаж болох агуу адислалуудын зарим нь мэдлэг, мэргэн ухаан, гэрчлэл, баяр баясал, амар амгалан ба аз жаргал юм.

Даруу хувцастай холбоотой бэрхшээлүүдийн нэг нь хувцасны загвар болон нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн зан төлөв байнга өөрчлөгддөг явдал мөн. Их Эзэний жишгүүд хэзээ ч өөрчлөгддөггүй. Юу өмсөх, юу хэлэх, юу хийхээ сонгох үедээ Сүнсэнд мэдрэмтгий байхыг залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд заа. Тэд Сүнсстэй ойр дотно амьдарч байгаа үедээ тэдэнд дэлхийтэй адилхан байх хэрэгцээ гарахгүй.

Бидний хүүхдүүд Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан бөгөөд тэд өөрсдийг нь ариун сүм рүү удирдах хийгээд Бурханы оршихуйд буцаан аваачих гэрээний замаар аялж байна. Тэд Ариун Сүнсийг хүлээн авахуйц зохистой амьдарвал түүгээр удирдагдаж, хамгаалагдан, тайтгаруулагдаж, цэвэршүүлэгдэх болно гэдгийг бид батлан хэлж, тэдэнд үлгэр жишээ үзүүлэх хэрэгтэй.

2. Даруу гадаад төрх болон зан төлөв нь биднийг дэлхийн хөнөөлт нөлөөнүүдээс хамгаалахад тусалдгийг бид хөвгүүд, охиддоо зааж чадна. Бидний эсрэг хэрэглэгддэг хамгийн их хууран мэхлэгч аргуудын нэг нь ёс суртахууныг дээдэлнэ гэдэг бол хоцрогдсон хуучинсаг үзэл гэсэн нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн хандлага





*Юу өмсөх, юу хэлэх, юу хийхээ сонгох үедээ Сүнсэнд мэдрэмтгий байхыг залуу эрэгтэй, эмэгтэйчүүдэд заа. Тэд Сүнсэтэй ойр дотно амьдарч байгаа үед тэдэнд дэлхийтэй адилхан байх хэрэгцээ гарахгүй.*

юм. Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь: “Гэрлэхээсээ өмнө . . . бэлгийн харьцааны мэдрэмжүүдийг өдөөх зүйлсийг бүү хий” гэсэн үгсийг сонс.<sup>6</sup> Даруу бус гадаад төрх ба зан төлөв нь бэлгийн харьцааны сэрлийг олонтоо өдөөж, хоригийг сулруулан, ариун явдлын хуулийг зөрчих илүү хүчтэй уруу таталт руу хөтлөх болно.

Ахлагч Хэйлс: “Бодол санаа, үйлдлээрээ цэвэр бөгөөд ариун журамтай байхын ноён нуруу нь даруу байдал юм. Тиймээс энэ нь бидний бодол санаа, зан төлөв, шийдвэрийг удирдаж, эдгээрт нөлөөлдөг учраас даруу байдал бидний зан чанарын үндэс суурь юм” хэмээн заажээ.<sup>7</sup> Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээ өөрсдөд нь буй нөхөн үржихүйн хүчээ хамгаалахад бэлтгэлтэй байхад нь туслахын тулд даруу байдлыг тэдэнд зааж, энэ талаар үлгэр жишээ үзүүл. Гэрлэлт дэх нөхөр, эхнэр хоёрын хооронд байх ёстой хайрын илэрхийллийг ариун байлгаж, хамгаалахад нь тэдэнд тусал.

**3.** Даруу байдал нь бидэнд “ямар ч үед Бурханы гэрчлэгч болж зогсох” (Мозая 18:9) боломжийг олгодог.

Аврагч: “Дэлхийд туяарч болохын тулд гэрлээ өгөгтүн. Болгоогтун би бол та нарын өргөх тэрхүү гэрэл билээ” (3 Нифай 18:24) хэмээн заажээ. Дэлхийд гэрэл байж, сайн мэдээний дагуу амьдрахаас ирдэг баяр баяслыг харуулах, зөв шударга байдлыг заах болон дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулах онцгой үүрэг бидэнд байдаг. Бид даруу бөгөөд цэвэр ариун байж, зарлигуудыг сахиснаар бидний хүн нэг бүр Есүс Христийн гэрлийг харуулдаг. Даруу байдал нь Аврагчийн болон Есүс Христийн сайн мэдээний талаарх бидний гэрчлэлийн баталгаа юм.

Ариун Сүнсээр удирдуулж, өөрсдийгөө дэлхийн нөлөөнөөс хамгаалж, дэлхийд Бурханы гэрчлэгч болж зогсдог хүмүүс хэчнээн үзэсгэлэнтэй хийгээд адислагдсан байна вэ. Сионы бүх хөвгүүн, охинд даруу байдлын сургаалыг зааж, энэ талаар үлгэр жишээ үзүүлдэг хүмүүс адислагдсан юм.

Бид Аврагчийг дагах гэрээ хийж мөн Түүний Цагаатгалын адислалуудын бүрэн байдлыг амьдралдаа хүлээн авах хүсэлтэй байгаа бол бидэнд хамаатай ганцхан л өмсгөл байдаг. Моронай “Мөн сэрэгтүн, мөн шорооноос өндийгтүн, . . . тийм ээ, мөн үзэсгэлэнт өмсгөлөө өмс, Ай Сионы охин; . . . Мөнхийн Эцэгийн . . . та нартай хийсэн гэрээнүүд биелэгдэж болохын тулд” (Моронай 10:31; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн цэдэглэжээ.

Үзэсгэлэнт өмсгөлүүд нь зөв шударга байдлын нөмрөг бөгөөд гэрээгээ сахидаг хүмүүс үүнийг өмсдөг юм. Бид хүүхдүүдээ эдгээр үзэсгэлэнт өмсгөлийг өмсөхөд бэлтгэж байна уу?

Аврал Христэд байдаг бөгөөд гэрээгээ сахидаг хүмүүс “өөрсдийн жаргал, мөн өөрсдийн зөв шударга үйлүүдийн төгс мэдлэгтэй байх болно, цэврээр хувцасласан байсны, тийм ээ, бүр зөв шударгын орхимжтой байсны учир болой” (2 Нифай 9:14) гэдгийг би гэрчилж байна. ■

*2013 оны 5-р сарын 2-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон эмэгтэйчүүдийн чуулганд хэлсэн үгээс авах.*

#### ЭШЛЭЛҮҮД

1. *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэлүүд* (2004), 106.
2. Жэффри Р.Холланд, “Израиль, Израиль, Бурхан дуудаж байна” Сүмийн боловсролын системийн онцгой цугларалт, 2012 оны 9-р сарын 9, cesdevotionals.lds.org.
3. Дэвид А.Бэднар, “Бид ариун явдалд итгэдэг,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 43.
4. Робэрт Д.Хэйлс, “The Covenant of Baptism: To Be in the Kingdom and of the Kingdom,” *Лиакхона*, 2001 оны 1-р сар, 8.
5. Робэрт Д.Хэйлс, “Modesty: Reverence for the Lord,” *Лиакхона*, 2008 оны 8-р сар, 18.
6. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 36.
7. Робэрт Д.Хэйлс, *Лиакхона*, 2008 оны 8-р сар, 19.

## ХОЙД ТЭНГИСТ БАЙХДАА ХИЙСЭН МИНИЙ ЗАЛБИРАЛ

Намайг 17 настай байхад бид Норвегийн умард хэсэгт орших Андабелоя гэдэг арал дээр амьдардаг байлаа. Аав минь Андабелояд Сүмд хөрвүүлэгдсэн бөгөөд би тэнд далайд баптисм хүртсэн.

Тэр үед би загасчин байсан болохоор завь жолоодох туршлагатай болсон байлаа. Аав минь тэр хавийн хүмүүсийн хэрэглэдэг байсан мэритайм гэдэг таксины үйлчилгээг хариуцах ажлыг надад даалгасан байв.

1941 оны нэгэн өдөр бид өмнөд хэсэгт орших Флэксфиордад байдаг эмчээс дуудлага хүлээн авлаа. Завиар хоёр цаг орчим явж хүрэх газар амьдардаг нэгэн эмэгтэйд яаралтай эмнэлгийн тусламж

хэрэгтэй болсон байлаа. Доктор Хоффман тэр эмэгтэйг үзэхээр өөрийг нь аваад явж чадах эсэхийг надаас асуухад аав, ээж хоёр Өмнөд тэнгист эхэлж байгаа шуурганц санаа нь зовж байв. Бид юу хийх ёстойгоо Тэнгэрлэг Эцэгээс асууж залбирахаар шийдэв. Тэгээд бид явах ёстой гэсэн хариулт авсан юм.

Би *Триг* гэдэг 10 метрт загасчилдаг завиа тэнгист гаргахад цаг агаар муу, давалгаа ихтэй байв. Эмчийг аваад би задгай тэнгис рүү гарлаа. Бид далайн шуургаараа болон усан онгоц сөнөөдгөөрөө алдартай Норвегийн чулуурхаг умард эргийн дагуу Листагаас өмнө зүгт орших нэг жижиг суурин руу явах хэрэгтэй байлаа.

Би шуурган дундуур залуурдаж байгаад 12 метр урттай нэгэн хадархаг тохойд орж ирлээ. Шуурга биднийг очих ёстой газар руу тууж эхлэв. Давалгаа маш өндөр байсан учраас би завиа тохой дундуур сэлүүрдэж чадахгүй байлаа. Давалгаа тохой руу хүрхрэн орж, хад мөргөж байв.

“Бид яах ёстой вэ?” гэж эмч шуургыг сөрөн асуухад

“Бид залбирах хэрэгтэй” гэж би хариулав.

Би түр зогсоод залбирч, Тэнгэрлэг Эцэгээс удирдамж хүслээ. Намайг амен гэж хэлмэгц хариулт нь тодорхой ирэв. Би гэнэт нэгэн ахмад загасчны ярьсан түүхийг саналаа. Тэрээр нэг удаа хүчтэй



шуурганы үеэр энэ хавьд загасчилж байгаад эрэг рүү хүрч чадахгүй болсон байжээ. Загасчин шуурга намдахыг хүлээж байхдаа хүрхрэн ирж буй давалгаануудад нэгэн хэмнэлийг олж харсан аж. Гурван маш том давалгаа ирсний дараа түр зуур нам гүм болж байв. Ийнхүү түр зуур нам гүм болсон үед тохой руу амжиж орж болохоор байлаа.

Би энэ хавьд олон удаа загасчилж байсан ч, давалгааны ийм хэмнэлийг хэзээ ч анзаарч байсангүй. Гэсэн ч би завиа тохойн аманд авчраад, бид тэндээ хүлээж, гурван том давалгаа ирэхийг харлаа. Үнэхээр ч гэнэт нам гүм болов. Би завиа зугуухан сэлүүрдэж, тогтуухан усан дээгүүр

Давалгаа маш  
дөндөр байсан  
учраас би завиа тохой  
дундуур сэлүүрдэж  
чадахгүй байлаа.

хөвсөөр Хоффман эмчийг эрэгт аюулгүй хүргэсэн юм. Намайг залбиралд минь хариулсан Тэнгэрлэг Эцэгтээ талархаад, завиндаа хүлээж байх хооронд тэрээр өвчтэй эмэгтэй рүү яаран явлаа.

Эмч цаг орчмын дараа эргэж ирээд “Бид түүний амийг аварч чадлаа!” хэмээн хэллээ.

Би энэхүү баярт мэдээнд болон сайжирч буй цаг агаарт сэтгэл амарч, завиа гэр рүүгээ осол эндэлгүй сэлүүрдэн хөдөлж билээ.

Тусламж хэрэгтэй болсон үед бид залбирах ёстой гэдгийг би гэрчилж байна. Тэнгэрлэг Эцэг хариулана гэдгийг би мэднэ. ■  
Олаф Торлиф Жэнсэн, АНУ, Юта

## ТЭР ЧАМД ХАЙРТАЙ

Би Мэмфисийн Тэннэссигийн Ариун сүмийг онцгойлон адислах үеэр селестиел өрөөний буланд, бадралт баг бишгүүр хөгжмийн ард сууж байлаа. 1995–2007 оны хооронд Тэргүүн Зөвлөлийн гишүүн байсан ерөнхийлөгч Жэймс И. Фауст (1920–2007) ариун сүмийг онцгойлон адислахаар ирсэн байв. Тэрээр бусад хэдэн удирдагчтай микрофоны ард сууж байлаа. Орон нутгийн сүмийн найрал дуучид орж ирээд, тэдний ард зогсов.

Миний айлчлагч багшаар очдог байсан нэг залуу эмэгтэй найрал дуучдын бүрэлдэхүүнд байсан. Цуглааны туршид би тэр охиныг хүлээн авахаар найдаж ирсэн зүйлээ авасай хэмээн залбирсан юм. Тэрээр Их Эзэний өмнө өөрийнхөө байр суурийг мэдэхийн тулд ариун

сүмийн онцгойлон адислалд ирснээ надад өмнө нь хэлсэн. Тэрээр урьд нь ноцтой нүгэл үйлдсэн юм. Тэр наманчилсан ч гэсэн өөрийнхөө талаар таагүй мэдрэмжтэй байв. Мөн найрал дуу дуулахдаа ч онцгүй мэдрэмжтэй хэвээр байжээ.

Би ерөнхийлөгч Фауст руу харж, Тэргүүн Зөвлөл дэх Их Эзэний төлөөлөгчийн хувьд тэр ямар нэг зүйл хийж чадах байх гэж бодож суулаа. Гэвч би үүнийгээ түүнд яахин хэлж чадах билээ, тэгээд ч тэр юу хийх билээ дээ? Цуглааны дараа тэр хэнтэй ч танилцалгүй, хэнтэй ч гар барьж, хэд гурван үг солилгүй, өрөөнд орж ирсэн шигээ яаран гарч явах биз ээ. Би түүнийг завгүй, өөр тийшээ явах хэрэгтэй байх гэдгийг ойлгосон ч, залбирсаар байлаа.

Ерөнхийлөгч Фауст гүн бодлого-ширч, над руу түр зуур харах үедээ хөмсгөө зангидсан байлаа. Хурал дуусахад харин царай нь гэрэлтэж, баясгалантай болсон байв.

Тэр над руу дахин нэг харснаа гэнэт босоод, дороо эргэж, гараа урагш нь урт гэгч сунган, миний найз руу заалаа. Тэгээд тэр “Их Эзэн чамд хайртай!” гэж чанга дуугаар баттай хэлэв.

Ерөнхийлөгч Фаустын энэхүү үйлдэл жижигхэн бөгөөд энгийн байсан ч миний түүнд хэлж чадаагүй зүйлийг Ариун Сүнс түүнд хэлсэн нь гарцаагүй юм. Түүний хэлсэн дөрөвхөн үг найзыг маань адисалсан төдийгүй Их Эзэн бидний амьдралын нарийн ширийн зүйлүүдэд санаа тавьдаг бөгөөд “өчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддаг” (Алма 37:6) гэсэн итгэлийг минь үргэлж тэтгэсээр байдаг билээ. ■

Алис Викториа Вэстон-Шэрвүүд, АНУ, Арканзас

# БИ ХҮҮХДҮҮДИЙГ СОНССОН

Сэтгэл санааны хямрал надад дахин нүүрлэхийг би огт хүсдэггүй байлаа. Гэвч 12 жил надаас хол байсан энэхүү хямрал эргэж ирэв.

Айдас түгшүүр, цөхрөл намайг эзэмдсэн байлаа. Би яагаад гэдгийг Тэнгэрлэг Эцэгээс асууж, бэрхшээлээ даван туулах хүч чадлын төлөө, бас сэтгэл санааны энэ удаагийн хямрал өмнөх шигээ таван жил үргэлжлэхгүй байхад туслаарай хэмээн Тэнгэрлэг Эцэгээс гуйж залбирав.

Нөхөр бид хоёр гурван хүүхэдтэй. Хоёр хүү, нэг охин маань биднийг 13 ач, зээгээр адисалсан. Надад учирсан зовлонг мэдэж байсан охин маань гэр бүлээ зохион байгуулан мацаг барьж, залбирах өдөр төвлөсөн байв. 1–10 настай бүх ач, зээ маань эмээгийнхээ төлөө залбирахыг, баптисм хүртсэн гурав нь мацаг барихыг хүссэн юм. Нөхөр, хүүхэд, ач, зээ нар маань миний өмнөөс мацаг барьж, залбирна гэдгийг мэдсэн нь намайг ихэд тайтгаруулж байлаа.

Маргааш нь би нойрноосоо сэрэхэд сэтгэл санааны хямрал надад

тийм ч хүчтэй санагдсангүй. Дараагийн өдөр нь арай илүү хөнгөн санагдав. Тав дахь өдөр нь миний хямрал бүрмөсөн арилсан байлаа. Тэр орой би энэхүү гайхамшиг хэрхэн тохиосон талаар тунгаан бодох үед нэгэн дуу хоолой миний бодгальд ирж, “Би хүүхдүүдийг сонссон” гэж хэлэв. Тэнгэрлэг Эцэг гэнэн сэтгэлт хүүхдүүдийг минь сонсож, тэдний даруу байдал, итгэлд болон хайрын залбирлуудад хариулсан юм.

Аврагч заахдаа:

“Та нар өөрчлөгдөж, хүүхэдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй.

“Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно” (Матай 18:3–4) хэмээн хэлсэн билээ.

Би ач, зээ нартайгаа захидлаар харилцаж, миний өмнөөс мацаг барьж, залбирсанд нь талархсан юм. Би тэдэнд ямар их хайртайгаа, бас Тэнгэрлэг Эцэг тэднийг сонсож, залбиралд нь хариулсан гэдгийг тэдэнд хэлсэн.

Ач, зээ нар маань сайн мэдээнд өсөхдөө Тэнгэрлэг Эцэг эмээд нь хандаж “Би хүүхдүүдийг сонссон” гэж хэлсэн үеийг санана гэж би найдаж байна. Мөн энэ туршлага тэдний гэрчлэлийг хүчирхэгжүүлж, сайн мэдээнд хүчтэй байхад нь тусална гэдэгт би найдаж байна. ■  
Жои Кромар, АНУ, Калифорни

1–10 настай бүх ач, зээ маань эмээгийнхээ төлөө залбирахыг, баптисм хүртсэн гурав нь мацаг барихыг хүссэн юм.



## ИХЭД ДУР БУЛААМ ХОР

Би сонин худалдаж авахаар урд хаалгаар гараад нэгэн таагүй дүр зураг харсан юм. Галт шоргоолжны овоолсон удаавтар өнгийн шороо зүлэг болон явган хүний замын завсраар овоорсон байлаа.

Хэдийгээр нөхөр бид хоёр АНУ-ын Техаст удаан амьдраагүй ч гэлээ энэ шоргоолжнууд өнгөөрөө бус харин хорсгом хаздаг учраас ийнхүү нэрлэгдсэн гэдгийг би гашиун туршлагаараа мэдэж байсан юм. Тэгээд шавжны хор авахаар гараж руугаа явлаа. Би шошгон дээрх зааврыг уншив.

“[Энэ хоронд] галт шоргоолжнууд маш их дуртай” гэж бичсэн байлаа. “Шоргоолжнууд хорыг үүрэндээ авч ороод хатан шоргоолжоо үүгээр хооллоход шоргоолж сүргээрээ үхэх болно.” Овоолсон шороон дээр болон эргэн тойронд нь хорыг цац гэсэн заавар шошгон дээр байлаа. Үлдсэнийг нь шоргоолжнууд өөрсдөө хийх болно.

Би эргэлзэж байв. Галт шоргоолжнууд нэг шөнийн дотор өндөр овоо босгож чадах учраас овоо ухаантай юм шиг санагдлаа. Шоргоолжнуудыг энэ хоронд хууртана гэдэгт би эргэлзэж байсан ч хорыг ямартай ч гэсэн цацлаа.

Хэсэг хугацааны дараа би шоргоолжнууд үүрэндээ бужигналдахыг харлаа. Би юу болохыг холоос ажиглаж байв. Тэнгэрээс манна орсон юм шиг л тэд ихэд баяртай байгаа бололтой. Шоргоолжнууд хорны талстуудыг өчүүхэн жижиг хошуугаараа хазаж аваад бие

биенээсээ өрсөн, үүрэндээ оруулахаар яарч байлаа.

Би мэл гайхан харж байв. Тэд энэ хорыг өөрсдөө үүр рүүгээ зөөж байлаа. “Ихэд дур булаам” гэсэн үг хэтрүүлэг биш гэдэг нь тодорхой болов. Хор хийдэг компани нь ямар нэг арга замаар муу—бүр үхэлд хүргэх зүйлийг маш сайхан харагдуулах арга олсон байжээ.

Муу зүйл хэрхэн сайхан юм шиг харагдаж болдог үүнээс илүү жишээг би хэзээ ч харж байгаагүй. Энэ нь Сатан хэрхэн үүнтэй адил зүйл хийдэг талаар намайг бодоход хүргэсэн. Хэдийгээр тэр зүсээ хувиргасан хороо миний гэрийн эргэн тойронд цацаж чадах ч гэлээ, намайг зөвшөөрөөгүй цагт үүнийгээ миний гэрт оруулж ирж чадахгүй гэдгийг ойлгоод би ихэд тайвширч билээ. Тэгвэл би муу зүйлийг гэрээсээ хэрхэн хол байлгаж чадах вэ?

Миний дуртай нэгэн судар санаанд орж ирлээ. “Учир нь болгоогун, Христийн Сүнс хүн бүрд тэрбээр сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тулд өгөгдсөн байдаг.” Энэ Сүнсээр дамжуулан бид ямар нэг зүйл Бурханаас эсвэл Сатанаас ирсэн эсэхийг “төгс мэдлэгээр мэдэж болно” (Моронай 7:16) хэмээн Мормон тайлбарласан байдаг.

Үхэж буй шоргоолжнуудыг харсан тэрхүү туршлага нөхөр бид хоёрыг аливаа зүйлийг шүүн тунгааж, гэртээ оруулах эсэхээ баттай мэдэж чадна гэсэн талархлаар дүүргэсэн

юм. Бидний үүрэг бол хүүхдүүдээ Христийн Сүнсийг дагахыг заах явдал бөгөөд ингэснээр тэд хортой учрах үедээ үүнийг таних болно.

Би тэнд зогсоод, шоргоолжнууд хорны талст бүрийг хэрхэн үүр рүүгээ зөөхийг хараад Сатаны хорыг гэрээсээ хол байлгахын тулд чадах бүхнээ хийх болно гэж андгайлсан юм. ■

Алисон Л.Рандалл, АНУ, Юта

Овоолсон шороон дээр болон эргэн тойронд нь хорыг цац гэсэн заавар шошгон дээр байлаа. Үлдсэнийг нь шоргоолжнууд өөрсдөө хийх болно.



# Итгэдэг зүйлийнхээ төлөө ЗОГСОХ НЬ

**Бидний амьдарч буй дэлхийд олон хүн хилэнцийг сайн гэж харин сайныг хилэнц хэмээн хардаг бөгөөд харин бид сайны төлөө зогсох ёстой. Дараах гэрчлэлүүд нь итгэдэг зүйлийнхээ төлөө зогссон залуучуудын гэрчлэл юм. Тэд маргалдаж эсвэл уураар болон найрсаг бус байдлаар хариу үйлдэл үзүүлээгүй юм. Тэд “зоригтой бас найрсаг”<sup>1</sup> байсан бөгөөд үүний үр дүнд бусдыг хүчирхэгжүүлсэн юм (3 Нифай 12:44–45-ыг үзнэ үү).**





## МИНИЙ ДХ ОРГИЛУУН ДАРС УУХААС ТАТГАЛЗСАН

Франц улсад цэргийн алба хаах нь хүн бүрийн үүрэг. 20 настай дүү Лоик маань дэслэгч болохын тулд Холбооны офицеруудын сургуульд суралцахаар шийдсэн юм. Сургууль төгсөхийн өмнөхөн шинэ офицеруудын тангараг өргөх ёслол болсон. Хүн бүр тогтсон уриаг цээжээр ээлж дараагаар уншсаны дараа дотроо сарнайтай, хундага оргилуун дарсыг сарнайтай нь хамт уух ёстой байв. Энэ уламжлал нь Наполеон Бонапартоос эхэлсэн бөгөөд үүнээс хойш нэг ч офицер уг ёслолд оролцолгүй өнгөрч байгаагүй юм.

Лоик өөрийнх нь шашны зарчмууд согтууруулах ундаа уухыг зөвшөөрдөггүй гэж хурандаад хэлжээ. Сарнайтай дарс уухаас татгалзсан Лоикийн хүсэлтийн дараа түр зуур нам гүм болов. Хурандаа бослоо. Тэрээр Лоикийг оргилуун дарсыг уу гэж хүчлэхийн оронд, дарамт шахалтыг үл тоон өөрийнхөө зарчмуудыг сахиж байгаад нь баяр хүргээд, ийм үнэнч шударга хүнийг бүрэлдэхүүндээ хүлээн авч байгаадаа бахархаж байна гэв. Тэд оргилуун дарсыг сольж, Лоик ч тангараг өргөх ёслолд оролцсон ажээ.

Пиерре Антиан, Франц

## УТГАГҮЙ ҮДЭШЛЭГТ УРИГДСАН МИНЬ

Коллеж төгссөнийхөө дараа миний эгч Грейс бид хоёр хэдэн хожмын үеийн гэгээнтэнтэй хамт нэг компанид ажиллаж байлаа. Ажил олгогчид маань сүмийн гишүүд биш байв. Эгчийг маань сүй тавих үед манай ажил олгогч түүнд зориулан сүйт бүсгүйн шоу хийж гэнэтийн бэлэг барихаар төлөвлөсөн юм. Дарга маань бидний жишгүүдийг хүндэтгэх байх гэж би найдаж байсан ч тэр ликёр дарс, эрэгтэй тайчигч болон ичгүүртэй кино захиалсан байв.

Сүйт бүсгүйн шоуны өмнө би Ариун Сүнсний шивнээг мэдэрсэн бөгөөд намайг даргадаа өөрсдийнхөө жишгүүдийг сануул хэмээн урамшуулж байлаа. Би залуу эмэгтэйчүүдийн бүлгийн медалиа атгаад, залуу эмэгтэйчүүдийн бүлэгт байхдаа хувийн хөгжил дэвшлийн төслөө гүйцээхийн тулд гаргасан бүх хүчин чармайлт, хийсэн золиослолуудаа бодлоо. Би энэ мөчид илүү өндөрт зогсох болтугай хэмээн залбирлаа. Би даргыгаа гомдож магадгүй гэж бодон, санаа зовж буйгаа түүнд мессежээр бичив. Гэсэн хэдий ч миний хамгийн агуу хүсэл бол Тэнгэрлэг Эцэгийг баярлуулах явдал байсан юм.

Үдэшлэг эхлэхэд дарга надтай ярилцсангүй, тэр ч бүү хэл над руу харж инээмсэглэсэн ч үгүй. Гэсэн ч тэр тайчигч, кино хоёрыг захиалахаа больсон байлаа.

Үдэшлэгийн дараах өдрүүдэд дарга маань үдэшлэгийн өмнөх шигээ надтай ярьж бас хамт инээхгүй байв. Гэсэн хэдий ч миний хийсэн зүйлд Бурхан баяртай байгаа гэдгийг мэдсэн учраас би тайван байлаа. Нэг долоо хоногийн дараа дарга бид хоёрын харилцаа хэвийн байдалдаа орсон юм. Бурхан түүний зүрхийг зөөллөж, намайг итгэдэг зүйлийнхээ дагуу амьдардгийг ойлгоход түүнд тусалсныг би мэднэ.

Лэми Лабитаг, Филиппин, Кагаяан Валли



## БИ АНГИДАА ДОРМЖИЛСОН ҮГС СОНССОН

Би 18 орчим настай байхдаа оёдлын хичээлд суусан юм. Нэг өдөр надаас зайтай сууж байсан гурван охин доромжилсон үгс хэлж эхлэв. Би зөрчилдөөнөөс зайлсхийхийн тулд тэднийг хайхрахгүй байх уу эсвэл жишгүүдийнхээ төлөө зогсож, тэдэнд энэ яриагаа зогсоо гэж хэлэх ёстой юу гэдгээ мэдэхгүй байлаа. Эцэст нь би маш найрсгаар “Намайг өршөөгөөрэй, гэхдээ та нар хэл яриагаа цэгнэж болох уу?” гэж хэллээ.

Охидын хамгийн том нь над руу хяламхийснээ “Бид хүссэнээрээ л ярих болно” гэв.

Би “Гэхдээ та нар заавал хараалын үг хэлэх ёстой юм уу? Энэ чинь надад маш эвгүй байна” гэж хэлэв.

Тэр “Тэгвэл зүгээр л битгий сонс” гэлээ.

Намайг “Та нарыг чанга ярьж байхад сонсохгүй байх арга алга даа” гэж тэдэнд бухимдан хэлэхэд

“Тэгвэл тэвчихээс өөр яахав дээ” гэж нөгөөх охин хэлэв.

Би бууж өглөө. Би тэр охидод бухимдсан ч өөртөө илүү их бухимдаж байлаа. Би дууны өнгөө өндөрсгөж ярьсандаа итгэж ч чадахгүй байв. Охид урьдын адил хараалын үг хэлж байсан болохоор энэ үед бид бүгд ууртай байсан юм.

Би тайвширсныхаа дараа нөгөө охидын оёдлын машин ажиллахгүй байгааг харлаа. Надад өмнө нь ийм асуудал тохиолдсон учраас би юу нь болохгүй болсныг мэдэж байв. Тэгээд би тэдэнд оёдлын машиныг яаж засахыг үзүүллээ. Би хамгийн том биетэй охины царай өөрчлөгдөхийг харав. Тэр “Хөөе, биднийг уучлаарай” гэв. Түүнийг уучлал гуйж байгаад би итгэж чадахгүй байсан ч “Намайг ч бас уучлаарай. Би тэгж их уурлах ёсгүй байсан юм” гэж түүнд хэлэв.

Би оёдлын машин дээрээ буцаж ирээд дахин хараалын үг сонсоогүй юм. Бидний үгс бусдын хандлагыг өөрчилж чадахгүй байж болох ч бидний сайхан сэтгэл болон үйлчлэл үүнийг өөрчилж чадна гэдгийг энэ туршлага надад заасан юм.

Кати Паик, АНУ, Юта





## БИ НОМЛОЛД ҮЙЛЧЛЭХЭЭР ХАТУУ ШИЙДСЭН БАЙВ

Би 19 настайдаа Сүмд нэгдсэн юм. Би гурван хүүгийн дундах нь бөгөөд гэр бүлдээ цорын ганц хожмын үеийн гэгээнтэн байлаа. Баптисм хүртээд удалгүй би номлолд үйлчлэхийг хүсэх болов. Нэг жилийн дараа Сүнс надад номлолд явах ёстой гэж хэлсэн. Намайг ээжтэйгээ ярилцахад тэр намайг явах нь зөв биш гэж бодсон юм. Би нэг жил хойшлуулсан ч номлолд үйлчлэх хүсэл маань намайг орхиогүй юм. Тэр жилийн туршид би судруудыг судалж, мөнгөө цуглуулан, өргөдлөө бэлтгэж, эрүүл мэндийн бүх үзлэгт орж, бүх зүйл бүрэн болсны дараа Их Эзэнийг хүлээлээ. Удалгүй би Бразилийн Кампинас номлолд үйлчлэх дуудлага хүлээн авав.

Аав, ээж хоёр эсэргүүцсэн хэвээр байлаа. Би мацаг барьж, илэн далангүй залбирч, Тэнгэрлэг Эцэгт өөрийнхөө бүх айдсын тухай хэлэв. Би Түүнээс дэлхийн аавын минь зүрх сэтгэлийг өөрчлөхийг гуйлаа. Хачирхалтай нь, намайг явахын өмнөх бямба гарагт найзуудын маань надад зориулан бэлтгэсэн үдэлтийн үдэшлэгт аав оролцлоо. Тэгээд даваа гарагт нь аав намайг нисэх буудалд хүргэж өгсөн билээ.

Би номлолынхоо туршид сайн мэдээг номлож явахдаа Бурханы хайрыг мэдэрдэг байлаа. Ээж минь ээж байхаа болиогүй бөгөөд намайг гэртээ буцаж ирэхэд хамгийн түрүүнд тэврэн авч билээ.

Номлолд үйлчлэх нь аливаа үүрэг хариуцлагаас илүү чухал зүйл гэдгийг би ойлгосон. Энэ бол онцгой боломж бөгөөд өсөж хөгжих, суралцах гайхалтай хугацаа юм.

Клэисон Вэллингтон Аморим Брито,  
Бразил, Параиба



## БИ БУРХАНЫ ТУХАЙ ГЭРЧЛЭЛЭЭ ХУВААЛЦСАН

Улсынхаа хамгийн шилдэг их сургуульд шинээр элсэн орсон оюутан миний хувьд хамгийн сайнаараа байх ёстой гэсэн мэдрэмж надад төрдөг байлаа. Хавчлага гарч, профессорууд маань “бодит байдал” хэмээн өөрсдийнхөө бодсон зүйлүүдийг заах үед би сайн мэдээнд итгэх итгэлдээ эргэлзэж эхэлсэн юм. Энэ нь ангийн олон оюутанд нөлөөлөв. Ийм уур амьсгалын дунд сүмийн заадаг зүйлүүдийг хамгаалах нь амаргүй байлаа. Би сургуулиасаа гарах талаар бодсон ч үлдсэн нь дээр гэж шийдсэн юм. Хэрэв би энэ их сургуульд тэнцсэн цөөн хүний нэг юм бол бас тэр цөөн хүн доторх хожмын үеийн гэгээнтнүүдийн нэг нь юм бол би эндээ үлдэж, үнэний төлөө зогсох ёстой гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Өөрийгөө шашингүй үзэлтэн хэмээн мэдэгддэг биологийн багш маань шинжлэх ухааныг ямар нэг Агуу Бүтээгчид итгэх итгэлгүйгээр заадаг байв. Гэвч би үүнийг сонсох тусам эдгээр бүх зүйлийг бүтээсэн Агуу Хүмүүн—бидний Бурхан Эцэг байдаг гэсэн бодол илүү их төрж байв. Зарим хүн энэ санаа бол утгагүй зүйл хэмээн маргаж байв. Бидний ярилцлага илүү ноцтой болж байлаа. Бурхан бол Бүтээгч гэдэгт итгэдэг гэдгээ тайлбарлах гэж гараа өргөхдөө би сандарч байлаа.

Саналаа хэлэх мөч ирлээ. Сургууль дээр хүмүүс бусдын хэлсэн зүйлд алга ташиж, хашгирах юм уу доромжлох нь хэвийн зүйл байсан юм. Би зоригтой зогсож мөн эсэргүүцэгч талынханд хандан: “Бурханд итгэх нь яг одоо та нарт утгагүй зүйл мэт санагдаж байж магадгүй, гэхдээ энэ зүйл надад тодорхой байгаатай адил та нарт ч бас утга учиртай болох өдөр ирнэ” гэж тов тодорхой хэллээ.

Тэр цагаас хойш би итгэдэг зүйлийнхээ төлөө зогсохдоо хэзээ ч доромжлуулаагүй. Түүнээс хойш би сурлага, нийгмийн идэвх, сүнслэг байдлаараа өссөн юм. Би оюутны үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож, сургуулийн хэд хэдэн албанд сонгогдов.

Үнэний төлөө ганц удаа ч болов зогсох нь бидний ирээдүйд гаргах шийдвэрүүдэд асар их нөлөөлдгийг би ойлгосон юм.

Бага Винс А.Молэхан, Филиппин, Минданао

### ЭШЛЭЛ

1. Жэффри Р.Холланд, “Шавь байхын адислал ба төлөөс,” *Лиакхона*, 2014 оны 5-р сар, 6-г үзнэ үү.

# Хоорондоо нягт холбоотой миний ГЭРЧЛЭЛ

Аиви Ноче

**Н**омлогчид Сингапурт байдаг манай гэрт гэр бүлийнхэнд маань сайн мэдээг заасан. Аав сүмд нэгдээгүй харин ээж сүмийн гишүүн болсон учраас ээж бидэнд Есүс Христ болон Түүний сайн мэдээний тухай заасан. Би бүр хүүхэд байхдаа ч найзууддаа өөрийгөө хожмын үеийн гэгээнтэн гэдгээ бахархан хэлдэг байлаа.

Би ээжийнхээ заасан зүйлүүдэд үргэлж итгэдэг байсан. Гэтэл намайг насанд хүрсний дараа нэг номлогч надаас Мормоны Номыг хэдэн удаа уншсан бэ гэж асуув. Өмнө нь надаас энэ асуултыг асууж байсан ч би Мормоны Номыг уншаагүй учраас энэ ном үнэн эсэхийг мэдэхгүй байгаагаа тэр удаад анзаарсан юм.

## Үгүйсгэх аргагүй үнэн

Би цаашдаа үгүйсгэх аргагүй үнэнээс булгаж чадахгүй болсон

**Миний хувьд Есүс Христийн сайн мэдээ үнэн, Мормоны Ном үнэн гэдэг нь хоорондоо нягт холбоотой хоёр үнэн юм. Хэрэв сайн мэдээ үнэн бол Мормоны Ном ч бас үнэн.**

юм. Есүс Христийн сайн мэдээ үнэн, Мормоны Ном үнэн гэдэг нь хоорондоо нягт холбоотой хоёр үнэн юм. Хэрэв сайн мэдээ үнэн юм бол Мормоны Ном ч бас үнэн. Би Мормоны Ном үнэн эсэхийг мэдэхгүй байсан учраас итгэдэг бүх зүйлийнхээ талаар үнэмшил муутай байлаа. Эргэлзээ оюун бодлыг

минь дүүргэж, “Мормоны Ном үнэн үү?” гэсэн асуулт сэтгэл зүрхэнд минь хоногшин үлдсэн юм.

Аврагч Есүс Христтэй харилцах миний харилцаа өсөн нэмэгдэж байсан учраас энэ нь намайг үнэнийг хүсэхэд хөтөлсөн.

Мормоны Номыг нухацтай уншихгүйгээр Есүс Христийн талаар хангалттай мэдэж чадахгүйг ойлгосон тэр өдөр бол энэ ном үнэн эсэхийг мэдэхийг маш их хүссэн өдөр байсан юм.

## Багшаар дуудагдсан нь

Би удирдамж хүсэн залбирав. Энэ үеэр манай салбарын ерөнхийлөгч намайг сайн мэдээний сургаалын ангид Мормоны Номын тухай заахаар дуудсан. Энэ бол Мормоны Ном үнэнийг мэдэж, Аврагчид илүү ойртоход туслах Их Эзэний хариулт ч байж болох юм гэж мэдэрсэн

учраас би дуудлагыг хүлээн авлаа.

Заах нь хэцүү байв. Эхний хэдэн ням гаргийн дараа би Мормоны Номонд итгэх хүртлээ хэзээ ч үр дүнтэй зааж чадахгүйгээ мэдсэн юм.

### Түүхүүд бүлэг бүлгээр нээгдэв

Би долоо хоног бүр Мормоны Номыг судалж эхэллээ. Тэгээд удалгүй уншихдаа баяр баяслыг олдог болов. Мормоны Номон дахь түүхүүд бүлэг бүлгээр нээгдэж, намайг Есүс Христтэй илүү ойртуулсан юм.

Би Христийн төрөлтийг Нифайн үзэгдэлд харсан тухай уншлаа:

“Мөн би Назар хотыг үзэв; бас Назар хот дахь онгон бүсгүйг би харав, мөн тэрбээр үлэмж хонгор мөн цагаан байлаа. . . .

“Мөн тэр [тэнгэр элч] надад хандан: Болгоогтун, таны харж буй тэр онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодийн биеийг төрүүлэгч эх нь бөлгөө хэмээв” (1 Нифай 11:13, 18).

Би аз жаргалын төлөвлөгөөний талаар уншиж, Есүс Христэд итгэх нь бидний авралд зайлшгүй шаардлагатайг ойлгосон юм:

“Христ хүмүүний үрсийн дунд өөрийн хүмүүсийн зөрчлүүдийг өөртөө авахын тулд ирэхийг, мөн тэр дэлхийн нүглийг цагаатгах болно гэдгийг би мэднэ; учир нь

Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ. . . .

“. . . Учир нь Мөнхийн Бурханы агуу их төлөвлөгөөний дагуу цагаатгал хийгдэх ёстой, эс бөгөөс бүх хүн төрөлхтөн гарцаагүй мөхөх ёстой” (Алма 34:8–9).

Би Есүс Христийг эртний Америк дахь өөр хонинууддаа тохинуулж байгаа тухай уншаад Тэр бол бүх үндэстний Бурхан гэдгийг мэдсэн юм. Тэр нифайчуудад: “Та нар бол миний тухайлан хэлсэн тэд билээ: энэ хорооных бус өөр хонинууд надад бий; би тэднийг түүнчлэн авчрах ёстой, мөн тэд дуу хоолойг минь сонсох болно; мөн нэг хороо, мөн нэг хоньчин байх болно” (3 Нифай 15:21) хэмээн хэлжээ.

### Миний гэрчлэл бага багаар ирсэн

Мормоны Номоос унших үед Есүс Христэд итгэх миний итгэл илүү хурц болж, Түүний төлөвлөгөөний талаарх миний ойлголт өргөжин тэлсэн юм (Алма 32:28-ыг үзнэ үү).

Мормоны Ном бол манай шашны тулгуурын чулуу гэдгийг би гэрчилж байна. Иосеф Смит бол Бурханы сүмийг дэлхий дээр сэргээж, Мормоны Номыг алтан ялтсуудаас орчуулсан үнэн бошиглогч гэдгийг

Ариун Сүнс надад илчилсэн билээ. Мормоны Ном нь Есүс Христийг гэрчилдэг бөгөөд Ариун Библигтэй хамт ашиглагддаг. Энэ хоёр ном хамтдаа Есүс Христ бол үнэхээр Бурханы Хүү бөгөөд Тэр зөвхөн нэг үндэстний биш, бүх үндэстний Бурхан гэдгийг гэрчилдэг. ■  
*Зохиогч нь Сингапурт амьдардаг.*



### МАНАЙ ШАШНЫ ТУЛГУУРЫН ЧУЛУУ

“Хэрэв тулгуур чулууг авбал нуман хаалга нурж унадаг шиг

Мормоны Ном үнэн учраас л Сүм оршин тогтнож байгаа. . . . Хэрэв Мормоны Ном үнэн юм бол, мөн эдүгээ сая сая хүн энэ ном үнэн гэдэг Сүнсний гэрчлэлтэйгээр гэрчилж байгаа тохиолдолд хүн Сэргээлтийн тухай үзэл баримтлалыг болон үүнтэй холбоотой бүхнийг хүлээн зөвшөөрөх ёстой.”

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994),  
Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж (2004), 104.

# ЧӨЛӨӨТ СОНГОЛТ УУ ЭСВЭЛ ЁС СУРТАХУУНЫ СОНГОХ ЭРХ ҮҮ?

Сонгох эрхээ ухаалаг ашиглах нь бидний сонголтуудыг нээлттэй байлгаж, зөвийг сонгох чадварыг нэмэгдүүлдэг.

**Майкл Р.Моррис**

Сүмийн сэтгүүлүүд

**Б**и номлолд үйлчлэх талаар бишоптойгоо уулзахаар бэлтгэх үедээ ямар их сандарч байснаа одоо ч санаж байна. Би өөрийгөө хангалттай сайн байгаа эсэхээ бодож байлаа. Бошиглогч Иосеф Смиттэй адил, би “их эсвээс хор хөнөөлтэй нүглүүдэд” (Иосеф Смит—Түүх 1:28) гэмтэй байгаагүй ч түүнтэй адил сандарч байв.

Би Данни (нэрийг өөрчилсөн) гэдэг найзынхаа тухай бодож байсан учраас сандарч байлаа. Данни номлолд үйлчлэхийг ямар их хүсэн хүлээж байгаагаа хэдэн сарын турш ярьсаар байв. Гэвч энэ нь түүнийг бишоптой уулзсаны дараа өөрчлөгдсөн юм.

Данни хэд хэдэн залуу эмэгтэйтэй зохисгүй харилцаатай байснаа дараа нь надад ярьсан юм. Тэр өөрийгөө бүрэн цагийн номлогчийн үйлчлэлд тэнцэхээргүй болгосон байжээ. Тэр номлолыг сонгох боломжгүй болсон байв.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бойд К.Пакэрын хэлснээр Данни Сатаны уруу таталтад автсан



учраас “сонгох эрхээ буруу ашигласан” байлаа.<sup>1</sup>

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд зааснаар биднийг сонгох эрхээ дуулгавартай байдлыг сонгоход ашигласан үед жинхэнэ эрх чөлөө ирдэг. Данни эрх чөлөөгөө алдсан нь дуулгаваргүй байхыг сонгосны уршиг гэдгийг мэдсэн юм.

“Хэдийгээр та нар үйлддээ чөлөөтэй сонгох эрхтэй ч үр дагавруудыг нь чөлөөтэй сонгож чадахгүй.” Та нарын хийдэг сонголтууд бодит үр дүнгийнхээ хувьд сайн эсвэл муу үр дагавартай байдаг.”<sup>2</sup>

### Өөрсдийнхөө төлөө сонгогчид

Бид “өөрсдөө сонгох чөлөөтэй,” “өөрсдийн чөлөөт хүслээр” мөн “өөрсдөө үйлдэх” эрх чөлөөтэй гэж судрууд заадаг учраас (2 Нифай 2:27; 10:23; С ба Г 58:27; Хиламан 14:30) бид ихэвчлэн “сонгох эрх чөлөө” гэдэг нэр томъёог ашигладаг.

Гэвч “чөлөөт сонголт” гэдэг үг судруудад гардаггүй гэдгийг та нар мэдэх үү? Үүний оронд судрууд “Миний өгсөн *ёс суртахууны сонгох эрхийн* дагуу хүн болгон . . . сургаал хийгээд зарчимд үйлдэж болохын тулд, . . . хүн болгон нүглүүдийнхээ төлөө хариуцаж болохын тулд буюу” (С ба Г 101:78; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн заадаг.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон: “сонгох эрх гэдэг үг [судруудад] дангаараа эсвэл *ёс суртахууны* гэсэн тодотголтой гардаг. Бид *ёс суртахууны сонгох эрх* гэсэн тодорхойлолтыг ашиглах үедээ сонгох эрхийн тэнгэрлэг бэлгийн зайлшгүй чухал хэсэг болох хариуцлага хүлээх чадварыг зохих байдлаар тодорхойлж байдаг. Бид бол *ёс суртахууны* субъектууд бөгөөд өөрсдийнхөө

төлөө сонгогчид юм. Бид сонгох эрхтэй ч, сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг” гэж заажээ.<sup>3</sup>

Ерөнхийлөгч Пакэр “Сонгох эрх нь судруудад ‘ёс суртахууны сонгох эрх’ гэж тодорхойлогдсон байдаг бөгөөд энэ нь бид сайныг муугаас сонгож чадна гэсэн утгатай” гэж нэмж хэлжээ.<sup>4</sup> Бурханаас өгөгдсөн энэхүү бэлэг нь бид “бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвээс чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй” (2 Нифай 2:27) гэсэн үг юм.

### Сонгох эрхийн эсрэг Сатаны дайн

Ёс суртахууны сонгох эрх нь авралын төлөвлөгөөнд чухал байр суурь эзэлдэг учраас Сатан мөнх бус байдлын өмнөх дэлхийд үүнийг устгахаар эрэлхийлсэн юм. Тэрээр бослого гаргасны улмаас тусгаарлагдсан бөгөөд одоо “хүмүүнийг мэхлэн мөн харалган болгох, мөн тэднийг, . . . таалагдаа боолчлон хөтлөх” (Мосе 4:3–4) гэж эрэлхийлдэг.

Сатан биднийг эрх чөлөөгөө хязгаарлах сонголтууд хийгээсэй гэж мөн биднийг муу зуршил ба донтолт руу удирдаж, түүний уруу таталтуудыг эсэргүүцэх хүчгүй болгохыг хүсдэг. Сайн мэдээний гайхалтай шинж чанар бол бидний сонголтуудын болон тэдгээрийн үр дагавруудын тухай мэдлэгийг бидэнд өгдөг явдал юм. Сонгох эрхээ ухаалаг ашиглах нь бидний сонголтуудыг нээлттэй байлгаж, зөвийг сонгох чадварыг нэмэгдүүлдэг.

### Аврагчийн үлгэр жишээ

Тэнгэрт болсон Их зөвлөгөөнд дээр авралын төлөвлөгөө танилцуулагдах үед Аврагч бидэнд ёс суртахууны сонгох эрхээ хэрхэн зөв ашиглахыг үзүүлсэн билээ. Тэр “Аав аа, таны таалал хэрэгжих болно, мөн алдар суу үүрд таных байх болно” (Мосе 4:2) хэмээн хэлсэн. Есүс тэр үед болон дараа нь Гетсеманий цэцэрлэгт мөн загалмай дээр Эцэгийн хүслийг биелүүлэхэд бэлэн байсан учраас (Матай 26:39; Лук 22:42-ыг үзнэ үү), бидний муу сонголтын төлөөсийг төлж, наманчлалаар дамжуулан уучлагдах арга замыг бидэнд өгсөн юм.

Хэрэв бид Аврагчийн жишээг дагавал “Би юу хүссэнээ хийнэ” гэж хэлэхийн оронд “Би Эцэгийн хүсэж буй зүйлийг хийнэ” гэж тунхаглах болно.<sup>5</sup> Ёс суртахууны сонгох эрхээ ийм замаар ашиглах нь бидэнд эрх чөлөө, аз жаргалыг авчрах болно.

Би номлолынхоо анхны ярилцлагыг хийхээр бишоптойгоо уулзахаар орохдоо сайн сонголтууд хийсэндээ талархалтай байсан. Хэдэн сарын хойно би Гватемалд Их Эзэнд үйлчилж, бусдад авралын төлөвлөгөөг болон энэ төлөвлөгөөнд ёс суртахууны сонгох эрх ямар үүрэгтэйг зааж байлаа. ■

### ЭШЛЭЛҮҮД

1. Бонд К.Пакэр, “Миний мэддэг зүйлүүд,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 8.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 2.
3. Д. Тодд Кристоффэрсон, “Ёс суртахууны сонгох эрх,” *Ensign*, 2009 оны 6-р сар, 47.
4. Бонд К.Пакэр, “Миний мэддэг зүйлүүд,” 8.
5. Wolfgang H. Paul, “The Gift of Agency” *Liahona*, 2006 оны 5-р сар, 35-ыг үзнэ үү.



## “Би бодол санаагаа хянахыг хичээсээр байгаа ч маш олон уруу таталттай тулгардаг. Би хэрхэн илүү цэвэр ариун бодолтой болох вэ?”

**Б**одол санаагаа хянах нь хэцүү ч энэ нь боломжтой бөгөөд адислалуудыг авчирдаг. “Та нар бодол санаагаа хянаж сурснаар зуршлууд буюу тэр ч байтугай уруу татагч хувийн зуршлуудыг даван туулж чадна. Та зоригтой болж, айдсаа ялж, аз жаргалтай байх болно.”<sup>1</sup>

Мөн эдгээр адислалыг бодож үзээрэй:

- Цэвэр ариун бодол нь та нарын “итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй байхад” мөн “Ариун Сүнс чиний байнгын хамтрагч байхад” (С ба Г 121:45–46) туслах болно.
- Цэвэр ариун бодол нь та нарт сүнслэг өдөөлтийг танихад тусална, учир нь Ариун Сүнс та нарын зүрх сэтгэлд болон оюунд хандан ярьдаг (С ба Г 8:2–3-ыг үзнэ үү).
- Цэвэр ариун бодол нь анхны агуу тушаалыг дуулгавартай дагахад тусална: бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла (Матай 22:37-г үзнэ үү).

Илүү цэвэр ариун бодолтой байхын тулд та нарын хийж болох олон зүйл байдаг. Эдгээр хуудсан дээр байгаа санаануудаас та нар үүнийг харах болно. Гэхдээ та нарын хийж чадах гол зүйлдүүдийн нэг нь “эгэл хүнээ” орхих явдал бөгөөд энэ нь алгуур хэрэгжих үйл явц юм. Эгэл эрэгтэй эсвэл эгэл эмэгтэй нь цэвэр бус бодолд дуртай байдаг. Үүнийг хэрхэн даван туулах арга нь энд байна: “Учир нь эгэл хүн бол Бурханы дайсан, . . . мөн тэрээр Ариун Сүнсний таталтанд автагдан, эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн болж, хүүхэд шиг хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, . . . бус аваас үүрд мөн үргэлж тийм байх болно” (Мозая 3:19).

Энэхүү өөрчлөлтийг амьдралд тань авчрах Христийн Цагаатгалыг урихын тулд өнөөдөр та нарын хийж чадах нэг зүйл юу вэ?

### ЭШЛЭЛ

1. Бойд К.Пакэр, “Зохистой хөгжим, зохистой бодлууд,” *Лиахона*, 2008 оны 4-р сар, 31.



### Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба найзууд

Үүнийг эхлэх нэгэн сайн зүйл бол сэтгэл санааг өргөх кино, хөгжим, уран зохиолыг

сонгох явдал юм. Дэргэд нь зохистой яриа өрнүүлж, зөв үйл ажиллагаануудад хамт оролцож чадах тийм найзуудыг сонго. Та нар бодож болох илүү олон сайн зүйлтэй болсноор муу бодлыг арилгах нь илүү амархан болох бөгөөд муу бодол бага төрөх болно.

*Амбэр С., нас 18, Канад, Британий Колумб*

### Залбирал

Залбирал надад Тэнгэрлэг Эцэгтэй илүү ойр байж, сайн бодол дээр төвлөрөхөд тусалдаг. Өдөр бүр судраас судлах нь уруу таталтыг даван туулахад өөртөө итгэх итгэлийг минь хүчирхэгжүүлдэг. Судруудаас би Христийн итгэлтэй дагалдагчдын жишээг харж чадна. Гэрчлэлээ хуваалцах нь надад бодлоо цэвэр ариун байлгахад бас тусалдаг.

*Даша М., нас 17, Украин, Киев*



### Судрууд

Өглөө бүр сургуульд явахасаа өмнө судар унших нь надад тусалдаг. Муу бодол орж ирэнгүүт би хурдхан

шиг илүү сайн зүйлээр сольдог. “Үгүй ээ, битгий тэгж бод” (Энэ сайн зүйл хэдий ч) гэж зүгээр л хэлэхийн оронд сайн бодлоор соль. Сатан биш чи өөрөө оюун санаагаа хянадаг гэдгээ сана. Бид Тэнгэрлэг Эцэгийн зоригт охид, хөвгүүд бөгөөд өөрсдийгөө хөгжүүлэх байнгын үүрэг даалгавартай юм.

*Ник С., нас 16, АНУ, Арканзас*



### Сайн зүйл үү эсвэл зөв зүйл үү?

Оюун санаанд орж байгаа бодлоо чи байнга хянаж чадахгүй ч энэ бодол нь үлдэх эсэхийг чи хянаж чадна. Энэ бодол надад сайнаар нөлөөлөх үү? Энэ бодол надад зөв чиглэлд явахад туслах уу? гэж өөрөөсөө асууж болох юм. Уруу татсан асуулт санаанд орж ирвэл сайн дуу дуулж, дурсамжаа бодох юм уу залбираарай. Энэ бүхэн муу бодлыг сайнаар солиход оршино.

Лиза П., нас 17, Дани



### Лихайн жишээ

1 Нифай 15:27-д Нифай ах дүү наргаа аав нь амьдралын модны үзэгдэлдээ бузар байдлаар хүрээлэгдсэн байсныг хэлсэн. Гэвч “түүний оюун өөр зүйлүүдэд хандсан байсны улмаас” Лихай тэрхүү бузар байдлыг ажиглаагүй. Энэ нь өнөөдөр ч бидэнд үнэн юм. Хэрэв бид зөв шударга зүйлсээр дүүргэгдэж, үүний төлөө залбирч, зөв зүйлүүдэд анхаарлаа төвлөрүүлэх юм бол бидний оюун санаа зөв шударга, цэвэр ариун зүйлсээр дүүргэгдэх болно. Ингэснээр цэвэр бус бодол үлдэх хүчгүй байх болно.

Хатий В., нас 16, АНУ, Аризона

### Дуулал

Сүмийн дуулууд цэвэр бодолтой байхад бидэнд тусалдаг. Сайн дуу хөгжим сүнсийг өдөөдөг. Сүмийн дуулуудыг сонсох үед тэдгээр нь намайг илүү тайван, селестиел орчинд үргэлж аваачдаг. Дуулууд нь Тэнгэрлэг Эцэгийн бид бүгдийг хайрлах хайрыг санахад бидэнд

тусалж, уруу таталтуудаас хол байхыг илүү амархан болгодог.

Аманда А., нас 18, Бразил, Амазонас

### Гэр бүлээрээ судар судлах

Цэвэр бус бодол орж ирэх үед би гэр бүлийнхээ болон өөрийнхөө өглөө уншсан судруудыг санахыг хичээдэг. Өглөө бүр 6:00 цагт манай гэр бүл хамтдаа судар уншдаг. Энэ нь хэдий эрт ч гэсэн адислал болдог бөгөөд өдрийн турш намайг хүчтэй байлгадаг.

Елена В., нас 16, Швейцарь



### Ариун ёслол

Ариун ёслолын залбиралд, хэрэв бид Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, Түүний зарлигуудыг сахиж мөн үргэлж Түүнийг санавал Түүний Сүнстэй байнга хамт байх болно гэж дурдагддаг. Бид Түүнийг дурсан санаснаараа дэлхийн бодлыг үлдэн хөөж, мөнхийн зүйлүүд дээр анхаарлаа төвлөрүүлэхийг хичээдэг. Бид Түүнийг байнга санах үед бидний бодол, хүсэл, үйлдэл улам сайн болж өөрчлөгдөх болно.

Макхэй М., нас 18, АНУ, Юта



### ЭДГЭЭР ЗҮЙЛИЙГ ТУНГААН БОД

“Заримдаа эрсдэлтэй байдаг мөнх бус байдлын энэхүү аялалд

биднийг аюулгүй, зөв зам дээр байлгах төлөөлөгч Паулын зөвлөгөөг бид дагах болтугай: ‘Юу нь үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь зөв, юу нь цэвэр ариун, юу нь сайхан, юу нь сайшаалтай байна, хэрэв аливаа сайн үйл байгаа бол, хэрэв магтууштай ямар нэгэн юм байгаа бол тэдгээр юмсыг бодож санацгаа’ [Филиппой 4:8].”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Эргэн харх ба урагш тэмүүлэх нь,” Лиахона, 2008 оны 5-р сар, 90.

## ДАРААГИЙН АСУУЛТ

“Ээжийгээ өвчтэй байхад бид түүний төлөө мацаг барьж, залбирсан ч ээж минь нас барсан. Бид үүнтэй хэрхэн эвлэрч чадах вэ?”

Хариултаа, хэрвээ хүсвэл өндөр нягтралтай зургаа 2014 оны 11-р сарын 15-ны дотор [liahona.lds.org](http://liahona.lds.org) хаягаар (“Submit Your Work” гэсэн товчийг дарах), цахим шуудангаар [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар, шуудангийн (3-р хуудсан дээрх хаягийг үзнэ үү) хаягаар ирүүлнэ үү.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл, зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр хийсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.



## НЯМ ГАРГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Энэ сарын сэдэв:

Христтэй илүү адил  
болох нь

# Хэрхэн утга учиртай асуултууд асуух вэ

*Зөв асуулт асуух нь хүмүүст үнэний тухай гэрчлэлд  
зүрх сэтгэлээ нээхэд нь тусалж чадна.*

**Дэвид А.Эдвардс**

Сүмийн сэтгүүлүүд

**А**втобусан доторх нэг минутын яриа, сүм дээрх хичээл, интернэт дээрх коммент юм уу найзтайгаа ганцаарчлан хийх гүнзгий яриа аль нь байхаас үл хамааран эргэн тойрныхоо хүмүүст заах боломж та нарт байдаг.

Тиймээс ямар ч нөхцөлд үр дүнтэй заах зөвлөгөөг хэлье: асуултууд асуу.

Сайн асуултууд нь сайн ойлголт руу хөтөлдөг бөгөөд аз болоход сайн асуулт асуух дадлыг та нар судалж, дадлага хийснээр сайн сурч чадна. Хэрхэн хийхийг үзүүлье.

### Утга учиртай асуултууд асуу

Утга учиртай асуултууд нь та нарыг бодолд оруулж, гүн мэдрэмж төрүүлэн; үнэн рүү болон гэрчлэл, өөрчлөлт рүү хөтөлдөг. Тэдгээр нь маш өргөн хүрээтэй сэдвийг хамардаг ч ихэвчлэн нэлээд хэдэн нийтлэг шинжтэй байдаг: (1) асуулт нь хийсвэр эсвэл зөвхөн баримт төдий байдаггүй (хэдийгээр энэ нь баримттай асуултад хүргэж болох ч), (2) асуулт нь бидний өдөр тутмын амьдралтай ямар нэг байдлаар холбоотой байдаг, (3) асуулт нь биднээс урьдчилан төлөвлөсөн хариултаас илүү зүйл өгөхийг шаарддаг.



### Бид яагаад асуулт тавьдгийг сана

Асуултууд нь бидний оюун бодол нөхөхийг хүсэж байгаа орон зайг танилцуулах замаар бидний анхаарлыг татдаг. Тодорхой хэлбэл, хувийн бодлыг өдөөх асуултууд асууснаар дараах үйл явц өрнөж болно:

1. Хүмүүс таны ярьж буй зүйлийг сонирхож эхэлдэг.
2. Тэд бодож, хариулахын тулд сонгох эрхээ ашигладаг.
3. Сонгох эрхээ ингэж ашиглах нь үнэнийг тэдэнд гэрчлэх боломжийг Ариун Сүнсэнд олгодог.<sup>1</sup>

Энэ үйл явцыг санаснаар та нар ямар төрлийн асуултууд асуух болон ямар асуултуудаас зайлсхийх вэ гэдгээ мэдэх болно.

**Жишээлбэл:** “Судрыг унших нь яагаад чухал вэ?” гэж асуухын оронд та “Судрыг судлах нь та нарын амьдралд хэрхэн өөрчлөлт авчирсан бэ?” гэж асууж болно.

### Та зүгээр л хичээлийг заадаггүй харин хүмүүст зааж байгаа гэдгээ санаарай

Хэрэв та зааж буй хүмүүсээ мэддэг бөгөөд тэдний хэрэгцээний талаар бодож үзвэл ямар нэг санааг зүгээр ойлгуулах гэж биш харин тэдэнд туслахад чиглэсэн асуултуудыг сонгох болно.

#### Жишээлбэл:

“Наманчлалын үйл явцын алхмууд юу вэ?” гэж асуухын оронд та “Та ямар нэг буруу зүйл хийсэн гэдгээ мэдсэн үедээ үүнийгээ яаж залруулах вэ?” гэж асууж болно.

### Судалж мөн гүн гүнзгий бод

Сайн мэдээг заахаар бэлтгэхдээ судруудыг болон орчин үеийн бошиглогч, төлөөлөгчдийн заасан зүйлсийг судалж, залбир. Ингэснээр Ариун Сүнс тантай болон таны зааж буй хүмүүстэй хамт байж чадна (С ба Г 42:14; 50:21–22-ыг үзнэ үү).

Хэрэв та хүмүүсээс тэднийг үнэхээр бодолд оруулах асуулт асуухыг хүсвэл, та ч бас өөрөө адилхан ихийг бодох ёстой. Судалж буй зүйлээ тунгаан бод. Таныг хамгийн их бодоход хүргэдэг зүйл нь таны өөрөөсөө асуудаг асуулт гэдгийг та олж мэдэх болно. Өөрийг тань үнэхээр бодоход хүргэдэг асуултуудад анхаарлаа хандуул. Эдгээр нь илүү сайн ойлголт болон гэрчлэл рүү хөтөлдөг асуултууд юм. Та бусдад сайн мэдээний талаар сурахад нь тусалж байгаа үедээ яг ийм асуултуудыг асууж болно.

**Жишээлбэл:** “Бид энэрлийг хэрхэн олж авдаг вэ?” гэж асуухын оронд та “Моронай 7:48 дээр ‘зүрх сэтгэлийнхээ бүх эрч хүчээр’ энэрлийн төлөө залбир гэж хэлсэн байдаг нь ямар утгатай гэж та боддог вэ?” гэж асууж болно.

ХЭРЭГСҮҮДИЙН ЗУРГИЙГ СЕРГЕЙ МАРКОВИЧЕВ/GETTY IMAGES/THINKSTOCK, ТОЛГОЙН ЗУРГИЙГ JOHACHA/ISTOCK/THINKSTOCK





**Ахлагч  
Жэффри Р.Холланд**  
Арванхоёр  
Төлөөлөгчийн Чуулга

## ХҮЧ ЧАДАЛ БА АМЖИЛТЫГ ХЭРХЭН ОЛОХ ВЭ

**Т**а нарын зарим нь амьдралдаа ямар хүн байх, хаашаа явахаа мэдэж байгаа бол зарим нь үүнийгээ мэдэхгүй байгаа. Та нарын заримд нь маш олон гайхалтай адислал ирсэн байгаа мөн олон гайхалтай сонголт өмнө чинь хүлээж байгаа. Та нарын зарим нь ямар нэг шалтгаанаар аз муутай байж, өмнө чинь сайхан зүйлс хомсхон байгаа мэт мэдэрч байж болно.

Гэвч та нар амьдралд хөлөө олох гэж хичээхдээ хэн ч байлаа гэсэн мөн хаана ч байлаа гэсэн би та бүхэнд “зам, үнэн ба амь”-ийг (Иохан 14:6) санал болгож байна. Та нар хаашаа ч явж байлаа гэсэн, би та бүхний хувийн аз жаргал, хүч чадал, амжилтыг олох хамгийн чухал анхны алхам болгож, “Түүнд ирэхийг” (Матай 11:28–30) та нараас хүсэж байна.

Андрей, Филип хоёр Христийн ярихыг анх сонсоод сэтгэл нь маш

их хөдөлжээ. Тэр цугласан олныг орхин явах үед тэд **Түүнийг дагасан**. Өөрийг нь дагаж байгааг мэдээд Христ эргэж харан, хоёр эрэгтэйгээс “Та нар юу эрнэ вэ?” (Иохан 1:38) гэж асуув. Өөр орчуулагууд үүнийг энгийнээр “Та нар юу хүсээ вэ?” гэсэн байдаг.

Тэд “Та хаана байрлаж байна?” эсвэл “Та хаана амьдарч байна?” гэсэн байдаг.

Христ “**Ирээд үз**” гэж хэлэв. Богино хугацааны дотор Тэрээр Петрийг болон бусад шинэ төлөөлөгчийг үүнтэй адил илчлэлтийн сүнсээр, албан ёсоор “**Ирээд, намайг дага**” хэмээн дуудсан юм (Матай 4:19-ийг үзнэ үү).

Бидний амьдралын гол утга учир нь Аврагчийн мөнх бус тохинуулын нээлтийн үзэгдэл дэх энэ хоёр товчхон хэсэгт шингэсэн байдаг гэж би боддог. Нэг нь бидний хүн нэг бүрд хандсан “Та нар юу эрнэ вэ? Та нар юу хүсээ вэ?” гэсэн асуулт. Хоёр дахь нь үүнийгээ хэрхэн авах талаар Түүний өгсөн хариулт. Бид хэн ч байсан, ямар ч асуудалтай байсан, Түүний хариулт мөнхөд адилхан байдаг: “**Ирээд, намайг дага.**” Миний юу хийдгийг мөн би цагаа хэрхэн зарцуулдгийг ирээд хар. **Надаас суралц**, намайг дага, тэгсэн үед чинь би та нарын залбирлын хариултыг болон бодгальда чинь амралтыг өгөх болно.

Хайрт залуу найзууд минь, та нар амжилтад хүрэх юм уу аз жаргалтай байх эсвэл аюулгүй байх өөр ямар ч арга замыг би мэдэхгүй. Та нар ачаа дарамтаа үүрэх боломжтой байх эсвэл “гэгээнтнүүдэд зориулан бэлтгэгдсэн аз жаргал” (2 Нифай 9:43) хэмээн Иаковын хэлсэн зүйлийг олж авч чадах өөр ямар ч арга замыг би мэдэхгүй. Ийм л учраас бид Христийн цагаатгагч золиослол

дээр суурилсан ёслол төгөлдөр гэрээнүүдийг хийдэг бөгөөд ийм л учраас бид **Түүний нэрийг өөрсөд дээрээ авдаг**.

Есүс бол Христ, амьд Бурханы Хүү мөн. Энэ бол Түүний үнэн хийгээд амьд сүм. Тэрээр биднийг Түүнд ирж, Түүнийг дагаж мөн **Түүгээр тайтгарахыг** хүсдэг. Тэгээд Тэр биднээс **бусдад тайтгарал өгөөсэй** гэж хүсдэг. Бид **Бурханы сайн сайхныг** болон Түүний Төрсөн Ганц Хайртай Хүүгийн нигүүлслийг хүлээн авахуйц хангалттай итгэлтэй байх болтугай. Бид Түүнд болон Түүний сайн мэдээнд ирж, эдгээгдэх болтугай. ■

*1997 оны 3-р сарын 2-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн үгээс авав.*

### ТА ҮҮНИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БЭ?

“Есүс Христ биднээс Өөрийг нь дагаасай гэж хүсдэг. Бид бусдад тусалж мөн Тэрээр биднийг хэзээ ч мартаггүй гэдгийг мартаггүй байх хэрэгтэй.”

**Сэсила Е., Филиппин**

“Бид Аврагчид ирэхийн тулд Түүний үлгэр жишээг даган, хамгийн сайнаараа амьдарч, Түүнийг өдөр бүр, мөч болгонд өөрсөдтэйгөө хамт байлгах ёстой.”

**Аллисон Л., АНУ, Аризона**



–ГЭР БҮЛИЙН ТҮҮХ–

# БИ ҮҮНИЙГ ХИЙЖ БАЙГАА

*Хийж эхлэх нь амархан бас хөгжилтэй байж болно. Дэлхий даяарх өсвөр үеийнхэн гэр бүлийн түүхийн ажлыг хийснээрээ өөрчлөлт бий болгож байна.*

**Х**аанаас эхлэх вэ? Та нар магадгүй хамаатнууд чинь хийх ёстой бүх ажлыг хийсэн гэж бодож байж магадгүй. Эсвэл та нар энэ ажлыг шинээр хийж эхэлж байгаа эсвэл энэ нь өөрсдөөс чинь ахадсан юм шиг санагдаж болох юм. Та нар хувийн тэмдэглэл хөтөлж, ариун сүмд зориулан нэрс бэлтгэж эсвэл амьд буй хамаатнуудаасаа суралцахын алийг нь ч хийж эхэлж байгаа бол *та нар* гэр бүлийн түүхийн ажилд хөгжилтэй, утга учиртай арга замуудаар оролцож чадна.

## **Хувийн тэмдэглэл хөтлөх: Адислалуудаа санах нь**

**Т**эмдэглэл хөтлөх нь амар биш. Бид ихэвчлэн хэтэрхий завгүй эсвэл их ядарсан эсвэл миний амьдралд бичээд байх сонирхолтой юм байхгүй шүү дээ гэж өөртөө хэлдэг. Хэдэн жилийн өмнө би тэмдэглэл хөтлөх нь хэцүү байх шаардлагагүй, тэмдэглэл хөтлөх дуртай болох юм байна гэдгийг ойлгосон юм.

Би өдөрт нэг зүйл бичиж эхэлсэн юм. Энэ зүйл нь маш урт эсвэл сэтгэл хөдөлгөм байх шаардлагагүй байсан. Би зүгээр л дотроо бодсон зүйлээ эсвэл тэр өдөр тохиолдсон зүйлийн тухай бичдэг байв. Энэ нь миний амьдралыг аль хэдийн адисалсан байлаа.

Нэг өдөр гэр бүлийн маань нэг гишүүн хүнд байдалд ороход би түүнд юу хэлэхээ сайн мэдэхгүй байсан ч өдрийн тэмдэглэлээсээ түүнд уншиж өгөх санаа төрлөө. Тэмдэглэлийн хар дэвтэртээ бичсэн өөрийнхөө бяцхан хэсгийг хуваалцах боломж надад олдсон юм. Миний хуваалцсан зүйл түүний санаа сэтгэлийг бага ч болов хөнгөлөхийг би харж билээ.

Хэрэв та нар өдөрт нэг л зүйл бичиж эхлэх юм бол энэ нь та нарын амьдралыг адисална гэдгийг би баталж байна. Хэр жижиг эсвэл хэр том гэдгээс үл хамааран амьдралдаа авч буй адислалуудаа бичих нь тэдгээрийг санахад та нарт тусалж чадна.

*Жэнтри В., АНУ, Юта*

## Гэр бүлийн түүхийн ажилд баяр баяслыг олох нь: Өвөг дээдсээ хайх нь

**Б**и баптисм хүртэх үедээ гэр бүлийн түүхийн талаар маш их сонссон боловч үүнийг хэрхэн хийхийг эсвэл үүнийг хийж чадах эсэхээ мэдэхгүй байсан. Би энэ талаар залбирахаар шийдсэн бөгөөд гэр бүлийн түүх дээр тэр даруй ажиллаж эхлэх ёстой гэсэн мэдрэмж хүлээн авлаа. Өвөг дээдсүүд маань намайг энэ ажлыг хийж эхлээсэй гэж догдолж байсан ба тэд надад ёслолуудаа шаардлагатай мэдээллүүдийг олоход туслах болно гэсэн мэдрэмж надад төрж байсан юм.

Би гэр бүлийн түүхийн ангид сууж үүнийг эхлүүлсэн бөгөөд богино хугацааны дараа гэр бүлийн түүхийн зөвлөхөөр дуудагдсан. Би энэ талаар их зүйл мэдэхгүй байсан болохоор сандарч байсан ч дуудлагыг хүлээн авсан юм.

Нэг өдөр би эмээгийнхээ эгч дээр айлчилж очсон. Түүнд элэнц эмээгийн минь талаарх баримтууд байлаа. Тэдний гэр бүлд нас барсан хамаатнуудынхаа талаар ярьдаггүй уламжлал байсан учраас тэр дэлгэрэнгүй мэдээлэл хуваалцахыг хүсэхгүй байв. Маргааш нь элэнц эмээгийн минь нас барсан өдөр байсан бөгөөд тэр бүх бичиг баримтыг нь устгах гэж байснаа надад хэлсэн юм. Би эхлээд тэдгээрээс хэсэг мэдээлэл авч болох эсэхийг асуухад тэр зөвшөөрөв. Тэгэхэд би Тэнгэрлэг Эцэг надад судалгаагаа үргэлжлүүлэн хийхэд тусална гэдгийг мэдсэн.

Би ариун сүмийн ойролцоох гэр бүлийн түүхийн төвд үйлчилж байхдаа гэр бүлийнхээ талаар илүү ихийг олж мэдсэн. Элэнц эмээгийн маань өвөө, эмээ нарын хоёр нь Италиас цагаачилж ирсэн бөгөөд Бразилийн Сао Паолод фермтэй байсныг олж мэдсэн юм. Гэр бүл маань ферм дээрх хамаатнуудтай холбоо тасарсан ч би манай гэр бүлийн удмын бичгийн талаар ном бичиж байсан нэг үеэлтэйгээ танилцсан билээ. Тэр есөн жил зарцуулж байж бичсэн номоо надад өгөв. Тэр яагаад уг номыг бичих ёстойгоо мэдээгүй ч энэ нь ирээдүйд хэн нэгэнд тус болно гэдгийг мэдэрсэн гэж хэлэв. Елиагийн сүнс түүнийг өдөөснийг би мэднэ.

Бид ариун нандин ажил хийж байгаа гэдгийг миний туршлага надад заасан юм. Өвөг дээдэс маань бидний тусламжийг хүлээж байгаа бөгөөд бидэнд туслахаар бидний талд байдаг.

*Габриэл Д., Бразил*



## Ариун сүмийн ажил хийх нь: Ариун нандин ёслолууд

**Б**и хөрвөгч бөгөөд гэр бүлээсээ ганцаараа Сүмийн гишүүн. Ариун нандин ёслолуудын нэг нь нас барагсдын төлөө хийгддэг баптисм гэдгийг би ойлгосон. Би нэгэн аялаар ариун сүмд очиж, ёслолуудын талаар хөтчийн ярьж байхыг сонсох зуур нэгэн намуухан зөөлөн дуу хоолой гэр бүлийн түүхийн төв рүү очиж, нас барсан ээжийнхээ төлөө ариун сүмийн ёслолын хүсэлт явуул гэж надад хэлэхийг мэдэрсэн юм. Дараа нь FamilySearch буюу Гэр бүлийн хайлт бүртгэлд түүний ариун сүмийн ажил дууссан гэж батлахыг хараад би маш их баярласан. Энэ нь миний гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн бөгөөд бид энэ дэлхий дээр байгаа шалтгаануудын нэг нь өвөг дээдэстэй Есүс Христийн үнэн сайн мэдээг хүлээн авахад нь туслах явдал гэдгийг би мэднэ.

*Марвин С., Филиппин*

## Сүнслэг өдөөлтүүдийг дагах нь: Амьд байгаа хамаатнуудаасаа суралцах нь

**Н**амайг ахлах сургуулиа төгссөний дараа хоёр талын өвөө, эмээ нар дээрээ айлчилж очих ёстой гэсэн мэдрэмж надад төрсөн. Надад чөлөөт цаг байсан бөгөөд ийм боломж дахин олдохгүй байж магадгүй гэдгийг ойлгоод, өвөө, эмээ нартайгаа нэг долоо хоногийг хамт өнгөрөөлөө.

Би хуучин хайрцгуудыг нээж үзэн, хуучин захиануудыг уншиж мөн хуучин зурагнууд үзэж, цагаа өнгөрөөсөн. Би өвөө, эмээгийнхээ





## ЯМАР НЭГ МӨНХИЙН ЗҮЙЛД ОРОЛЦ

“Өвөг дээдсийнхээ төлөө хийх ажлын талаар та залбирч үзсэн үү? Амьдралд тань төдийлөн чухал биш зүйлсийг хойш нь тавь. Мөнхийн үр дагавартай зүйлсийг хийхээр сонго. . . .

“Та дэлхийн хаана ч амьдардаг бай; итгэл, залбирал, шийдвэр төгс байдал, шаргуу хичээл зүтгэл, багхан золиослолоор энэ ажилд чухал хувь нэмэр оруулж чадна. Яг одоо эхлэгтүн. Их Эзэн танд замаа олоход тань тусална гэдгийг би танд амлаж байна. Энэ ажил танд гайхалтай сайхан сэтгэгдэл төрүүлэх болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт, “Нас барагсдын авралаас ирдэг баяр баясгалан,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 95.

амьдралын түүхийг бичиж тэмдэглэн, оршуулгын газрын эргэн тойронд алхаж; өвөө, эмээгийнхөө болон тэдний хамаатнуудын амьдарч, ажилааж байсан газруудаар айлчилсан юм. Энэ нь их зугаатай байлаа! Би өвөг дээдэс, өвөө эмээ, эцэг эхийнхээ тухай болон өөрийнхөө талаар маш их зүйлийг сурсан. Хэрэв өвөг дээдэс маань байгаагүй бол би одоогийн амьдралтайгаа байхгүй байх байсан гэдгээ ойлгосон.

Аялынхаа дараа би өөрийн өвөг дээдсийн 1000 орчим нэртэй буцаж ирсэн бөгөөд тэдний олных нь төлөө ариун сүмийн ажил хийх боломжтой байсан. Ариун Сүнсний өдөөлтийг дагаж; өвөө, эмээ дээрээ айлчилж очсон нь миний гаргасан хамгийн сайн шийдвэрүүдийн нэг байсан юм.

*Шэнли П., АНУ, Калифорни*

## Гэртээ байгаа мэт мэдрэмж: Ариун сүм рүү нэрс авч очих нь

Би хувийн хөгжил дэвшлээ гүйцээхийн тулд гэр бүлийн түүхийн талаар санаа өгөхийг ааваасаа хүссэнд тэр хэдэн жилийн өмнө хэсэг нэр олсон ч цаг зав багатай байсан учраас тэр нэрсээ ариун сүм рүү авч явахаар бэлэн болгож чадаагүй байгаа гэдгээ тайлбарлалаа. Миний тусламж манай гэр бүлийн эдгээр гишүүнд ариун сүмийн адислалуудыг хүлээж авах боломж олгоно.

Түүнээс хойш хэдэн сарын турш би ням гаргийн үдээс хойш болон үдэш нэрсүүдийг компьютерт оруулахын сацуу гэр бүлийн түүхийг ааваасаа мэдэж авсан. Бид бүр дэлгэрэнгүй мэдээлэл олохын тулд микрофич захиалсан юм. Заримдаа хуучин хальснуудыг уншихад хэцүү болох үед би чимээгүйхэн залбирч, тэгээд цаас гаргаж ирээд зургаар нь хөөдөг байв. Тодорхой бус мэдээллээс хүртэл нэрс гарч ирдэг байлаа.

Удалгүй би гэр бүлийн нэрсийн том цуглуулгыг бий болгосон бөгөөд тойргийн маань өсвөр үеийнхэн баптисмуудыг нь гүйцээхэд тусалсан юм. Аав, ээж хоёр болон тойргийн бусад гишүүн ариун сүмийн бусад ёслолыг нь гүйцээхээр нэрийн картуудыг авч явсан билээ.

Хэсэг хугацааны дараа би хувийнхаа хишгийг хүртэхэд бэлтгэж байв. Миний сэтгэл ихэд хөдлөхийн сацуу бас сандарч байлаа.

Биднийг ариун сүм рүү явж байхад аав миний хувийн хөгжил дэвшил төслөөр бэлтгэсэн гэр бүлийн нэрийн картуудын заримыг нь олсноо хэлэв. Хэдэн картыг хаана тавьснаа олоогүй байж. Тиймээс аав нэрийн картуудыг ээж, миний сүйт залуу хоёрт авчирч өглөө. Миний сүйт залуу ёслолуудыг хийж дуусгахаар болов. Тэр тэдний нэрийг надад хэлэхэд би тэднийг төсөл дээр минь байсныг саналаа.

Ариун сүмд эрхэм нандин гэрээнүүд хийж байх үед хөшигний хоёр талд буй хайртай хүмүүсээрээ хүрээлэгдсэн мэт мэдрэмж надад төрж байсан. Би гэр бүлтэйгээ мөнхөд нэгдэж чадна гэсэн мэдлэгтэйгээр асар их амар амгаланг мэдэрсэн юм. ■

*Холли П., АНУ, Айдахо*



## ТУРШЛАГАА ХУВААЛЦАНА УУ

Гэр бүлийн түүхийн туршлагаа  
[lds.org/youth/family-history/  
experiences-аар-хуваалцана-уу.](https://lds.org/youth/family-history/experiences-аар-хуваалцана-уу)

# ТЭДНИЙГ ТАНЬЖ МЭД БАС ӨӨРИЙГӨӨ Ч ТАНЬЖ МЭД

Таны амьдрал олон үеийнхний амьдралаас бүтсэн.  
Өөрийн тань түүх хаанаас эхэлснийг олж мэднэ үү.  
[FamilySearch.org](https://FamilySearch.org) хаягаар ороорой.



# МИНИЙ НОМЛОЛД ТУЛГАРСАН ЭСЭРГҮҮЦЭЛ

Гадасны ерөнхийлөгч маань номлолг үйлчлэх талаар нагтай ярилцсаны дараа “Чамайг боглоо өөрчлөхөд хүргэх хачирхалтай зүйлүүд амьдралг чинь тохиолдох болно” гэж хэлсэн.

## Алсэнир дэ Суза

Би 15 настай байхдаа сүмд нэгдээд дөрвөн жилийн дараа номлолд явах өргөдлөө явуулсан юм. Гадасны ерөнхийлөгчтэйгөө ярилцаж байх үед тэрээр бүрэн цагийн номлогчоор Их Эзэнд үйлчлэхээр шийдсэнд намайг сайшааж байв. Тэрхүү сүнсээр өдөөгдсөн удирдагч: “Ах аа, одооноос эхлээд таныг Их Эзэнд үйлчлэх шийдвэрийнхээ талаар бодлоо өөрчлөхөд хүргэх хачирхалтай зүйлүүд амьдралд чинь тохиолдох болно” гэж хүчтэй сэтгэгдэл төрүүлэм нэгэн зүйлийг надад хэлж билээ.



Номлолын дуудлагаа хүлээж байх үедээ би Ксерокс компанид дагалдангаар ажиллаж байлаа. Энэ ажил нь номлолын талбарт надад хэрэг болох зүйлүүдээ олж авч, гэр бүлийнхээ зардалд ээждээ туслах боломжийг олгосон юм. Бүх зүйл маш сайн байлаа.

Харамсалтай нь, “хачирхалтай зүйлүүд” тохиолдож эхэлсэн юм. Эхлээд ээж минь халдлагад өртөж, шархнаасаа болоод үхэх шахсан ч гэсэн сайхан сэтгэлт Тэнгэрлэг Эцэг гайхамшигтайгаар түүний амийг аварсан.

Энэ үед би ээж, хоёр эмэгтэй дүүтэйгээ түрээсийн байранд амьдарч байлаа.

Бид миний орлогоор, бас олон жилийн өмнө аавыг нас барснаас хойш ээжийн авдаг болсон тэтгэмжийн багхан мөнгөөр амьдарч байсан.

Сүмийн гишүүд болон зарим хүн “Чи ээжийгээ ийм







## БҮҮ БУУЖ ӨГ

“Сайн зүйл болж буй ямар ч гарт эсэргүүцэл тохиолддог. Энэ нь та нарыг боловсролтой болохыг хи-

чээж байхад тань тохиолдож болно. Энэ нь номлолын талбар дахь эхний сард та нарт цохилт өгч ч мэднэ. . .

“Томоохон шийдвэрүүдтэй хамт санах ёстой анхааруулга болон бодолцох зүйл байдаг, гэхдээ бүх зүйл тодорхой болсны дараа уруу таталт нь сайн зүйлээс ухардаг гэдгийг санаарай. Хэрэв аливаа зүйл та нарыг залбирч, итгэж, мөн үүний төлөө амьдрах үед зөв байсан бол энэ нь одоо ч зөв хэвээрээ байгаа хэрэг. Дарамт шахалт овоорох үед бүү бууж өг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Cast Not Away Therefore Your Confidence,” *Лиэхона*, 2000 оны 6-р сар, 38.

байдалтай орхиод номлолд явахаар зориглож чадна гэж үү?” хэмээн асуудаг байлаа. Энэ асуултыг дахин дахин сонсох нь зүрх сэтгэлд минь эргэлзээ төрүүлж эхэллээ.

Нэг өдөр гадасны ерөнхийлөгч над руу утасдаад номлолын чинь хариу ирсэн тул сүмийн төв байгууллагаас удаан хүлээсэн дугуйгаа миний өрөөнд ирж аваарай гэж хэлэв. Энэ мэдээг сонсонгуут би сандарсан ч аз жаргалтай байлаа.

Тэр өдөр манай менежер үдийн хоолны өмнө ярилцъя гэлээ. Түүний оффист ороход тэр надтай нөхөрсгөөр мэндэлж, миний сургалтын талаар болон компанид сурсан зүйлсийн тухай ярилцав. Тэгээд энэ байгууллагын нөлөө бүхий тэр хүн энэ хотод амьдардаг ихэнх хүний мөрөөдөж явдаг зүйлийг хэллээ: “Чи дагалдангаар сайн ажиллалаа, бид чамайг ажилд авч, багтаа оруулмаар байна. Чи юу гэж бодож байна?”

Энэ бол миний амьдралдаа гаргасан хамгийн хүнд шийдвэрүүдийн нэг байлаа. Цаг хугацаа зогсон мэт санагдаж байв. Ээжийгээ санхүүгийн дэмжлэггүй орхиод номлолын талбар руу явж байгаа юм уу

гэж хүмүүс надаас асууна гэдгийг би гадарлаж байв.

Гэсэн хэдий ч би судруудаас болон сүмийн удирдагчдаас эрхэм ариун арга замаар сурсан зүйлүүдээ санасан бөгөөд Бурхан намайг Өөрийн сүмийн бүрэн цагийн номлогчоор үйлчлээсэй гэж хүсэж байгааг ямар ч эргэлзээгүй мэдэж байлаа.


Намайг нөхцөл байдлаа менежертэй тайлбарлал: “Би чамайг ухаантай залуу гэж боддог. Гэтэл чи амьдралдаа ховорхон олдох боломжийг үл тоомсорлож байх юм” гэсэн түүний хариулт одоо ч гэсэн оюун санаанд минь тодхон үлджээ.

Тавьсан саналынх нь төлөө би түүнд чин сэтгэлээсээ талархсан ч 28 өдрийн дараа би Бразилийн Сан Паулогийн номлогчийг бэлтгэх төвд очсон юм.

Номлолын минь турш Их Эзэн сүмийн найзуудаар болон гайхамшигтай арга замуудаар манай гэр бүлийн хэрэгцээг хангасан билээ. Ээжийн минь бие сайжирч, ээж, дүү нарт маань ажлын боломжууд гарч ирсэн байлаа.

Бид Их Эзэнд үйлчлэхээр шийдэхэд “хачирхалтай зүйлүүд” үнэхээр тохиолддог. Гэвч номлолын үйлчлэл миний амьдралд асар их нөлөөлсөн тухай гэрчлэлээ би Бурханы үйлчлэлийг хийсэн мянга мянган хүний гэрчлэл дээр даруухан нэмж байна. ■

*Зохиогч нь Бразилийн Манауст амьдардаг.*





# БИДНИЙГ ЮУ ХҮЛЭЭЖ БАЙГААГ ИЛҮҮ САЙН ОЙЛГОХ НЬ

*Норвегийн Осло дахь өсвөр үеийнхэн бүрэн цагийн номлогчийн амьдралд бэлтгэн, нэг өдрийг өнгөрүүлжээ.*

## Катрин Апелсет-Аанэнсэн

Ерөнхийлөгч Томас С.Монсон номлолын үйлчлэлийн насыг өөрчлөх талаар зарласнаас хойш сүм даяарх өсвөр үеийнхэн номлолд үйлчлэх урилгад хариулаад зогсохгүй үйлчлэхээр *бэлтгэх* урилгад ч хүсэл эрмэлзлээрээ хариулсан юм. Бэлтгэх нэг арга зам бол бүрэн цагийн номлогч болох үед тань та нарыг юу хүлээж байгааг мэдэх явдал юм.

Норвеги дахь зарим өсвөр үеийнхэн үүнийг Норвегийн Осло гадасны Фредрикстад тойргоос зохиосон “Номлогчийн амьдрал” сэдэвт нэг өдрийн үйл ажиллагаанд оролцсоноор хийсэн байна.

## “НБТ” (Номлогч бэлтгэх төв)-д орсон нь

Өсвөр үеийнхэн номлогчийг бэлтгэх төвийг төлөөлсөн цуглааны байрны нэг өрөөнд цуглав. “Бид нэг улсын талаар суралцах даалгавар хүлээн авсан” гэж Мосс тойргийн Жэкоб Р. хэллээ. “Энэ нь номлолын дуудлага хүлээн авч, дассан газраасаа өөр газар дуудагдах үед ямар мэдрэмжтэй байх талаар ойлголт өгч чадсан.”

## “Номлолын ерөнхийлөгч”-тэй танилцсан нь

“Тэгээд бид номлолын ерөнхийлөгчийн дүрд тоглосон, буцаж ирсэн номлогчтой уулзахаар хажуугийн өрөөнд орсон” гэж Осло тойргийн Симон В. хэлэв. Сайхь буцаж ирсэн номлогч болон бусад буцаж ирсэн номлогч номлолд үйлчилж байхдаа ямар хүлээлтэй байдаг талаар ярьсан. “Бүрэн цагийн номлолын үеэр ямар хүлээлтэй байдаг талаар буцаж ирсэн номлогчдоос суралцах нь маш сайхан байсан” гэж Симон хэлэв. Оролцогчид бас нэрийн тэмдэг авч, хамтрагчтай болж мөн ямар ч үед хамтрагчтайгаа хамт байх удирдамж авсан юм.

## Ур чадвараа хөгжүүлэх нь

Сургалт нь өсвөр үеийнхэнд сүнс-лэг байдлаараа хэрхэн өсөж хөгжих





**ХАМГИЙН ЧУХАЛ БЭЛТГЭЛ**

“Үйлчлэх дуудлагад бэлтгэхийн тулд та нарын хийж чадах хамгийн чухал зүйл бол номлолд явахаасаа урт удаан хугацааны өмнө номлогч болох явдал юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, “Номлогч болох нь,” *Лиахона*, 2005 оны 11-р сар, 45.

тухай түүнчлэн угаалга хийх, санхүүгийн төсөв зохиох, бие бялдрын хувьд эрүүл чийрэг байх гэх мэт материаллаг хэрэгцээгээ хэрхэн хангах талаар заасан юм.

“Сайн мэдээтэй холбоотой яриаг хэрхэн эхлүүлэх талаар заасан сургалт надад илүү их таалагдсан” гэж Осло тойргийн Ингэр Софи Ж. хэлэв. “Би үүнийг яг одоо ч хийж эхэлж болно.”

“*Миний сайн мэдээг номло* удирдамжийг хэрхэн ашиглах талаар ярилцсан нь надад сайхан байсан” гэж Фрэдрикстад тойргийн Карл Фрэдрик О. хэлсэн юм. “Би номлогчдод суралцвал зохих өөрсдийн гэсэн судруудын жагсаалт байдаг гэж үргэлж боддог байсан ч семинарт сурч буй зүйлүүд болон *Миний сайн мэдээг номло* удирдамжаас сурч буй зүйлүүд номлогчийн хувьд надад тусална гэдгийг олж мэдсэн.”

Хамгийн дурсгалтай сургалтуудын нэг нь өөрийн гараар цагаан цамц индүүдэх ажил байсан гэж олон залуу эрэгтэй хэлж байлаа. “Энэ нь бүрэн цагийн номлод бэлэн болохын тулд миний хөгжүүлж болох олон энгийн чадвар байдгийг надад сануулж өгсөн” гэж Жакоб хэлэв.

“Энд үйлчилж байгаа бүрэн цагийн номлогчидтой нэгдэж, бүгд нэг баг болж ажилахын тулд би

одооноос маш их зүйлийг хийж чадахаа ойлголоо” гэж Сандвика тойргийн Р.Сара хэлэв. “Гишүүд ч бас номлогчид шүү дээ.”

Номлогчид дэлхий даяар үйлчилдэг гэдгийг сануулж, олон үндэстний онцгой жорын хоолнууд бэлтгэсэн байв. “Энэ нь шинэ хоолнуудыг идэж үзэх, ингэснээр дандаа идээд байдаггүй хоол хүнсэнд дасах болно гэдгийг надад сануулсан. Хэрэв би идэж үзээгүй хоол хүнс иддэг газар дуудагдвал хурдан дасахад энэ нь туслах болно” гэж Симон хэллээ.

**Бэлэн болох нь**

“Бид өдрийн төгсгөлд өсвөр насны хоёр гишүүн болон саяхан буцаж ирсэн хоёр номлогчийг сонсоны дараа ‘Үйлчлэхээр дуудагдлаа’ дууллыг дуулсан” гэж Фрэдрикстад тойргийн Лисс Андриа О. хэлэв. “Хэрэв би энэ дууллыг үргэлж дуулж байвал бид номлогч болох үедээ Тэнгэрлэг Эцэгтэй үйлчилж байгаа бөгөөд Тэр биднийг адислах болно гэсэн байнгын сануулгатай байх болно гэж бодсон.”

Өдрийн төгсгөлд гадасны өсвөр үеийнхэн өөрсдийгөө бүрэн цагийн номлод бэлтгэж байгаа төдийгүй яг одоо болон амьдралынхаа үлдсэн хугацаанд номлогчийн туршлагатай байж болно гэдгийг ойлгосон юм. ■

*Зохиогч нь Норвегийн Ослод амьдардаг.*

**НОМЛОГЧИЙН АМЬДРАЛ ЯМАР БАЙДАГ ВЭ?**

Видео бичлэгүүд, бусад эх сурвалжаар болон [youth.lds.org](http://youth.lds.org) дээрх тогтмол асуудаг асуултуудын хариултаар дамжуулан номлогчийн үйлчлэлд бэлтгэх талаар илүү ихийг олж мэдээрэй (“Номлогчийн ажилд бэлтгэх нь” хэсгийг дарна уу).



# Дараа ҮЙЛЧЛЭХИЙН ТУЛД ОДОО ҮЙЛЧЛЭХ НЬ

Майк Барбоса

Бодит түүхээс сэдэвлэв

“Бүх зүрхээрээ Эзэнд үйлчлэгтүн”  
(1 Самуел 12:20).

“Сүм хүртэл би чамтай уралдана!” гэж Мормон хэлээд дал моднуудын дээгүүр цухуйж буй сүмийн байрны орой руу заалаа. Тэгээд тэр дүү

Морианыхаа урд орохын тулд хар хурдаараа гүйв.

Хөвгүүд болон тэдний эцэг эх гэрээсээ 1,6 км орчим алхаад байсан ч Мормон, Мориан хоёр



уралдаж гүйсээр байгаад тойргийнхоо цуглааны байрны төмөр хаалган дээр ирээд амьсгаагаа дарахаар зогсов.

Тэд хэн нь түрүүлснийг шийдэхээс өмнө нэгэн хөвгүүн тэднийг дуудаад “хөл бөмбөг тоглох уу?” гэж асуув.

Мормон хөл бөмбөг тоглох дуртай байсан ч тэр гэрийнхэнтэйгээ хамт тойргийнхоо байрыг маргаашийн сүмийн цуглаанд зориулан цэвэрлэх гэж байв.

Мормон толгой сэгсрээд, “Одоо чадахгүй, дараа тоглож болох юм!” гэлээ.

Удалгүй Мормон, Мориан хоёр шаргуу ажиллаж эхлэв. Мориан ээжтэйгээ шал шүүрдсэн бол Мормон аавтайгаа хамт сандлуудыг зөөж, шал угааж байлаа.

Дараа нь хөвгүүд угаалгын өрөөнд хамтдаа толь угаав. “Би сүм цэвэрлэх ажилд дуртай болно гэж бодоогүй ч энэ нь их зугаатай ажил юм” гэж Мориан хэлэв. “Чи бас дуртай юу, Мормон? Ийм учраас л чи хөл бөмбөг тоглохын оронд энд ирсэн үү?”





Мормон аавынхаа тухай бодлоо. Тэр тойргийнхоо бишоп нь байсан мөртлөө цуглааны байрыг цэвэрлэх цаг гаргадаг байв.

“Би аавтайгаа адилхан болохыг хүсдэг учраас энд ирсэн” гэж Мормон хэлэв.

Тэгээд тэр тойргийнхоо номлогчдын тухай бодлоо. Тэд хаалга тогшиж, Мормоны Номыг бусадтай хуваалцаад завгүй байдаг. Тэд хүмүүсийг хөвгүүдийн цэвэрлэж байгаа байранд ирэхэд урих болно.

“Би бас хэзээ нэгэн өдөр номлолд үйлчлэхийг хүсдэг учраас энд ирсэн” гэж Мормон бодлоо. “Би сүмийг цэвэрлэж бэлэн болгосноор номлогчдод тусалж чадна.”

Мормон маргаашийнхаа тухай бодов. Тэр дүүтэйгээ хамт өглөө 6:00 цагт босож, цагаан цамцаа өмсөн, зангиагаа зүүж, алхаж ирээд Хүүхдийн хэсгийн өрөөнд сандал, дууны номуудыг бэлтгэх ёстой байв.

“Би сүмийн дуудлагад үйлчлэхийг хүсдэг учраас энд ирсэн” гэж тэр бодов.

Мормон өөрийгөө удахгүй дикон болно гэж бодлоо. Тэр ариун ёслолыг түгээж, үйлчлэх олон өөр зүйлийг хийх болно.

“Би дараа жил санваар хүлээж авах учраас энд ирсэн. Мөн би үүнд бэлэн болохын тулд одоо чадах бүхнээ хийхийг хүсэж байна.”

Мормон санваар хүртэхэд бэлтгэх нэг зүйлийг аль хэдийн хийсэн байсан нь тэр Бурханд итгэх итгэл

шагналаа авсан явдал байв. Тэр хэдийнээ сайн мэдээний дагуу амьдарч, бусдад үйлчлэхийг сурсан байлаа.

Сүүлд нь тэр дүү нь толинд хэрхэн харагдаж байгааг хараад инээв.

“Би Их Эзэнд хайртай учраас энд ирсэн” гэж тэр хэлээд “яагаад гэвэл одоо үйлчлэх нь дараа үйлчлэхэд минь туслах болно” гэлээ. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

## САНВААРТ БЭЛТГЭХ НЬ



Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Дэвид Л.Бэкийн өгсөн зөвлөгөөнүүд:

- Сүнсийг амьдралдаа урьж, зөвийг сонгоход чинь туслах найзуудыг сонго. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дээрх жишгүүдээр амьдар.
- Диконы хувьд ямар үүрэг хариуцлагатай байх талаар суралц. *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь, Итгэл*

*дээ үнэнч байх нь* номуудаас санваарын талаар унш. Тойрог эсвэл салбартаа санваарт бэлтгэх ангид оролц.

- Ариун сүм рүү явж, нас барагсдын төлөө баптисм хүртэхэд бэлтгэ.
- Бусад өсвөр үеийнхэнтэй хамт зугаатай үйл ажиллагаанд болон шашны цугларалтуудад урамтай оролц.
- Тэнгэрлэг Эцэг чамд итгэдэг бөгөөд чамд найддагийг мэдэж ав. Түүний тусламжтай хэр ихийг хийж чадахаа олж нээ!

# МАТИЛДЭ

## Залуу ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БҮЛЭГТ ОРОХОД БЭЛТГЭВ

Жэнн Вилкс. АНУ, Юта

**М**атилдэ удахгүй залуу эмэгтэйчүүдийн бүлэгт орох гэж байгаадаа сэтгэл нь хөдөлж байсан ч өөрийг нь юу хүлээж байгааг сайн мэдэхгүй байлаа. Тэр эмээтэйгээ ярилцжээ. Эмээ нь залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Оскарсон эгч юм. Түүнд хуваалцах гайхалтай зөвлөгөөнүүд байлаа!

Ээж, эмээ хоёроосоо эсвэл тойргийнхоо эмэгтэйчүүдийн нэгнээс нь Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн талаар юу санаж байгааг нь асуу. Та нар зарим нэг хөгжилтэй зүйл олж мэдэж магадгүй.

### ЗУГААТАЙ БАРИМТ

Матилдэ эмээгээ “Мо” гэж дууддаг бөгөөд энэ нь шведээр *модер* (ээж) гэсэн үгний товч хэлбэр юм байна.

### Тэр үед . . .




Оскарсон эгч Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт байхдаа өөр өөр амжилт гаргаж байж, тэмдэг авч байсан байна. Тэр тэднийгээ тусгай даавуун дээр итгэлтэй байдлыг төлөөлдөг цэцэгтэй хамт оёжээ.





## БЭЛЭН БОЛОХ ТАЛААР ОСКАРСОН ЭГЧИЙН ӨГСӨН ЗӨВЛӨГӨӨ!

- Залбирч, судраас унших замаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах харилцаагаа хөгжүүл.
- Хувийн хөгжил дэвшил хөтөлбөрийн талаар олж мэд.
- Судрууд, *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг болон *Лиахона*-г унш.
- Залуу эмэгтэйчүүдийн урианаас суралцаж эхэл. Та нар үүнийг долоо хоног бүр бусад охинтой хамт давтан уншиж байх болно.



## ... харин одоо



Энэ зүүлт нь та нарт бусдын гэрэл нь байхыг мөн үнэн ба зөвт байдлын төлөө зогсохыг сануулах болно.

Та нар түүнчлэн Хувийн хөгжил дэвшил туршлагауд ба төслүүдийг гүйцээснээр туузнууд авах болно.

Тэгээд та нар залуу эмэгтэйчүүдийн медаль авах юм.

## ШИНЭ ЭХЛЭЛҮҮД

Матилдэ шинэ эхлэлүүд гэдэг нэртэй нэг тусгай үйл ажиллагаанд оролцжээ. Тэд зугаатай хичээл үзэж, Хувийн хөгжил дэвшлийн талаар сурчээ.

Матилдэ түүнчлэн Бурханд итгэх итгэл шагнал авахаар ажиллан, Итгэлийн тунхгийг цээжилж байна.

## МАТИЛДЭ ДАРААХ ЗҮЙЛҮҮДИЙГ ТЭСЭН ЯДАН ХҮЛЭЭЖ БАЙНА . . .

- Долоо хоног бүрийн үйл ажиллагаа
- Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн бусад охинтой танилцах
- Залуу эмэгтэйчүүдийн зугаалгаар явах

## ОНЦГОЙ ДУРСАМЖ

Матилдэ болон түүний үеэлүүдийн олон нь 2013 оны 4-р сарын 6-нд Чуулганы төвд байсан юм. Гэхдээ тэд эмээ нь яагаад тэднийг бүгдийг нь Ерөнхий чуулганд урьсныг мэдэхгүй байв. Тэрээр Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхийлөгчөөр дэмжигдэх үед тэд маш их гайхаж бас сэтгэл нь хөдөлсөн байжээ!



# Бидний гэрэлтэх цаг

Урамтай ♩. = 58-68

Үгийг Жан Пинбороу  
Аяыг Жэнис Кэпп Пэрри

Chords: F C F Gm7 C7 F

*Охид*

1. Эзэ - ний зар-лигт Ес - тер шиг \_\_\_\_\_ би ү - нэнч байх бол - но. \_\_\_\_\_ Бурха -  
2. А - биш шиг би Түүнд үйл - чилж \_\_\_\_\_ сайн мэ - дээг тү - гээ - нэ. \_\_\_\_\_ Үү -

Chords: Bb C7 A7 Dm G7 C7

*Хөөгүүд*

ны тө - лөв лө - гөөг зо - риг - той хам - гаалж, ит - гэ - лээр Түүнд үйл - чилнэ би. \_\_\_\_\_ Эрт  
ний хос - гүй үнэ - нийг хү - мүүст би яри - на. Ит - гэл минь гал мэт шат - на. \_\_\_\_\_ Үнэ -

Chords: F C F Gm7 C7 F

үе - ийн Ни - фай шиг би \_\_\_\_\_ ах дүү - сээ ади - сал - на. \_\_\_\_\_ Тэн -  
ний тө - лөө Мо - ро - най \_\_\_\_\_ хэ - зээч бууж ө - гөө - гүй. \_\_\_\_\_ Түүн

Chords: Bb C7 A7 Dm Gm7 C7 F *Дахилт*

*Охид ба хөөгүүд*

гэр - лэг Эц - гийн - хээ тө - лөв - лө - гөөг би хам - гаа - лан мөн хүн - дэт - гэнэ. \_\_\_\_\_ Энэ бол  
шиг би а - гуу, ү - нэнч бай - хыг хи - чээнэ. Ту - гаа би өн - дөрт өр - гөнө. \_\_\_\_\_

Chords: Bb F C F Bb F Gm7 C7 F

бид бэл - дэж, гэ - рэл - тэх цаг юм. Бурха - ны ү - гийг сурч, заа - хад бид бэ - лэн.

© 2013 Жан Пинбороу ба Жэнис Кэпп Пэрри. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ дууг арилжааны бус, сүмд юм уу гэр орондоо ашиглах зорилгоор хувилан олшруулж болно.

Энэхүү анхааруулга олшруулсан хувь бүр дээр байх ёстой.



ОНЦГОЙ ГЭРЧ



Ахлагч  
Квинтин Л.Кук

Арванхоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын

Арванхоёр Төлөөлөгчийн  
Чуулгын гишүүд бол Есүс Христийн  
онцгой гэрчүүд юм.

# Би гэр бүлийн түүхийн ажилд хэрхэн тусалж чадах вэ?

*Ахлагч Кук гэр бүлийн модны цугларалт хийж байхыг зөвлөсөн. Хэрхэн хийхийг үзүүлье!*

Гэр бүлийнхээ бүх хүнээр гэр бүлийн түүх, тэмдэглэл, зурагнуудыг авчруул. Өвөө, эмээ, аав, ээжид тань байсан онцгой зүйлүүдийг оруулж болно.

Гэр бүлийн гишүүдийнхээ амьдралыг—тэдний хаанаас ирсэн, хэрхэн амьдарч байсныг мэдэх нь сэтгэл догдлом үйл явдал юм.

Ариун сүмийн ямар ёслолууд хийгдэх хэрэгтэй байгааг олж мэдээд, ариун сүмийн ажил хийх даалгавар өг.

Эдгээр түүх, зургуудыг скайнердаж, [FamilySearch.org](http://FamilySearch.org) дэх Гэр бүлийн модонд оруулахад тусал.

*“Үндэс ба мөчрүүд,” Лиахона, 2014 оны 5-р сар, 47-гоос авав.*







Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

Би гэр бүлээ хүчирхэгжүүлж чадна

## Чи чадна!



Цэвэрхэн, хоосон лаазыг энэ бичгээр (баруун тал дахь) болон хэдэн зургаар эсвэл зурсан зургуудаар чимэглэ. Гэр бүлээ хэрхэн хүчирхэгжүүлж болох санаануудыг цаасан дээр бич. Цаасыг хайчилж, лаазанд хий. Өдөр бүр лаазанд хийсэн бичигтэй цааснуудаас нэгийг сонгоод, үүн дээр бичсэн зүйлийг хий. Санаануудынхаа дагуу амьдрахыг хичээснээр та нар гэр бүлдээ өөрчлөлт авчирч чадна!



БИ ЧАДНА!



# Би Чилийн Барбара байна

Эми Жэйн Лэвиттэй  
хийсэн ярилцлагаас

**Б**арбара Өмнөд Америкийн баруун эргийн орон Чилид амьдардаг. Энэ улс урт, нарийн яг л тууз шиг хэлбэртэй газар нутагтай. Зарим хэсэг нь халуун, хуурай (Атакамагийн цөл шиг) уур амьсгалтай байхад зарим хэсэг нь халуун орны, чийглэг (Ийстэр арал шиг) уур амьсгалтай. Барбара Чилийн нийслэл Сантьягод амьдардаг. ■

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*



*Би сургуулийнхаа ангид цорын ганц сүмийн гишүүн нь. Энэ нь найзууддаа Есүс Христийн талаар болон Мормоны Номын тухай хэлэх боломжийг надад олгодог. Нэг удаа хамгийн сайн найз маань хэрхэн залбирахыг зааж өгөхийг надаас гуйсан учраас би түүнд заасан. Тэгээд бид хоёр сургууль дээр өдрийн хоолны үеэр хамтдаа залбирсан.*



*Би есөн настай, хоёр эрэгтэй дүүтэй. Би сайн эгч байхыг хичээж, дүү нартаа санаа тавьдаг мөн тэдэнтэй хамт тоглохыг хичээдэг. Би хүүхэд асрах дуртай, том болоод багш болохыг хүсдэг.*

*2013 онд намайг найман нас хүрэхэд аав надад баптисм хүртээж, би гишүүнээр батлагдсан. Миний сэтгэл маш их догдолсон! Энэ нь онцгой үйл явдал байсан болохоор би үргэлж дурсан санаж явах болно.*

Ола,  
амигос!\*

\* Испаниар "Сайн уу, найзууд аа!"

Чилид бид зугаатай баяруудыг тэмдэглэдэг. 9-р сарын 18 бол Тусгаар тогтнолын өдөр, харин 19 бол Зэвсэгт хүчний өдөр. Бид энэ хоёр өдрийн турш үндэсний бүжиг "Ла куэка"-гаа бүжиглэж, импанада гэдэг сайхан амттай хуушуур иддэг.



Амралтын өдрүүдэд манай гэр бүлийнхэн гэрийнхээ ойролцоох ууланд явганаар эсвэл дөрвөн дугуйгаараа мааждаг машинаар аялах дуртай. Бид бас далайн эргийн наран шарлагын газар очих дуртай.



Бид Христийн мэндэлсний баяраар тусгай хоол—алтан жад загасаар хачирласан улаан лооль иддэг. Чилид Христийн мэндэлсний баярын өмнөх өдрийн яг шөнө дунд Санта Клаус айлчлан ирдэг. Бид түүнийг ирэх хүртэл сэрүүн байдаг!



## БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Чилийн Сантьягогийн ариун сүм бол испани хэлтэй оронд баригдсан анхны ариун сүм. Тус ариун сүмийг 1983 оны 9-р сарын 15-нд онцгойлон адисалсан. Энэ нь өмнөд Америкт баригдсан хоёр дахь ариун сүм юм.



## ЯВАХАД БЭЛЭН БОЛЛОО!

Барбарагийн цүнх түүний дуртай зүйлсээр дүүрсэн байна. Та нар эдгээрийн алийг нь цүнхэндээ хийх вэ?



# БИДНИЙ ХУУДАС



Би баптисм хүртэхийнхээ өмнөхөн, нэг өдөр эмээгийнхээ гэрт байлаа. Эмээ ямар нэг юм авахаар газрын давхар руу орохдоо бүдэрч унаад босож чадсангүй. Эмээ намайг дуудсан ч би зурагт үзэж байсан болохоор сонссонгүй. Тэгээд 10 минутын дараа хэн нэг нь “Том!” гэж миний нэрийг аяархан дуудахыг сонслоо. Би эмээгээ хайхаар гараад, түүнийг шалан дээр хэвтэж байхыг харлаа. Эмээгээ өргөөд босгочих хүч тэнхээ надад байхгүй учраас би хөршийнхөө гэр рүү гүйв. Хөрш эгч ирж, эмээг босоход тусалсан юм.

“Том, чиний сонссон зүйл бол Ариун Сүнс байсан. Би чамаас их хол байсан болохоор чи намайг сонсох боломжгүй байсан” гэж эмээ надад хэллээ.

Надад шивнэсэн зүйл бол Ариун Сүнс байсныг би мэднэ. Одоо би баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг авсандаа баяртай байна.

**Том Р., нас 8, Герман**



**Лиу С., нас 7, Эквадор**



**Наталиа А., нас 10, Колумб**



**Бразилаас ирсэн 7 настай Тиэрри Хүүхдийн хэсэгт сууж, сүмийн дуулал дуулах дуртай. Ариун сүм бол Их Эзэний өргөө гэдгийг тэр мэддэг.**



**Румынээс ирсэн 8 настай Оливиа И. ээждээ гэрээ цэвэрлэхэд нь туслах дуртай. Ээж нь түүнд болон түүний 13 найзад заадаг ажээ.**



**Завсарлагааны үеэр Оливиа багш болж тоглох дуртай. Оливиа бас аав, ээжтэйгээ хамт аяллаар явах, эмээ, өвөөтэйгөө хамт цагийг өнгөрөөх дуртай. Тэр баптисм хүртэх үедээ Тэнгэрлэг Эцэгтээ маш ойрхон байгаагаа мэдэрсэн бөгөөд Ариун Сүнс түүнд шийдвэр гаргахад нь тусалдаг талархдаг. Түүний дуртай Хүүхдийн хэсгийн дуу бол “Бошиглогчийг дага” дуу юм (Children’s Songbook, 110).**

**Т**а зурсан зураг, гэрэл зураг эсвэл туршлагаа интернэтэд [liahona.lds.org](http://liahona.lds.org) хаягаар мөн [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар “Our Page” гэсэн гарчигтайгаар э-мэйлээр эсвэл 3-р хуудсан дээрх хаягаар шуудангаар илгээж болно.

*Liahona, Our Page*  
50 E. North Temple St., Rm. 2420  
Salt Lake City, UT 84150-2400, USA

Ирүүлэх материалдаа хүүхдийн овог нэр, хүйс болон нас (3-аас 11 насны хооронд), эцэг эх, тойрог эсвэл салбар, гадас эсвэл дүүргийн нэр, хүүхдийн гэрэл зураг, ирүүлсэн материалыг ашиглахыг зөвшөөрсөн эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйлээр ирүүлж болно) зэргийг оруулсан байх ёстой. Ирүүлсэн материалуудыг тодорхой байлгах үүднээс хянан засварлаж, хэмжээг өөрчилж болно.



Ахлагч Адриан Очоа  
Далын

# ДЭЭШЭЭ ХАР



*“Залбирч, ямагт сэргэг байгтун”  
(Лук 21:36).*

**Н**амайг найман настай байхад биднийг хоёр үеэлтэй маань хамт гэр бүлийнхээ хүнсийг бэлдүүлэхээр ойролцоох тосгон руу явуулсан юм. Одоо эргэн санахад авга, нагац, эмээ нар маань бидэнд ямар их итгэдэг байсанд би гайхдаг. Бид гурвыг морио унаад аян замд гарах үед өглөөний тэнгэр цэлмэг, нартай байлаа.

Хээр талаар явж байтал гэнэт мориноосоо бууж, шилэн бөмбөлгөөр тоглох гайхалтай санаа бидэнд төрөв. Тэгээд бид нэлээн удаан тоглосон. Бид тоглоомондоо улайраад хар үүл бүрхэн, тэнгэр муухай болохыг огт анзаараагүй юм. Юу болох гэж буйг ухаарсан тэрхэн мөчид бидэнд

мориндоо мордох ч боломж гарсангүй. Аадар бороо орж, мөндөр биднийг нүүр нүдгүй балбаж байсан учир бидний хийж чадах зүйл нь ердөө л эмээлээ аваад дор нь толгой хоргодох л байлаа. Тэгтэл морьд алдуураад давхичихав.

Морьдоо алдаж, норж даарсан бид аялаа үргэлжлүүлэн, чадлынхаа хэрээр хурдан явахыг хичээж байв. Бид нэг айл олж, хаалгыг нь тогших үед орой болсон байв. Тэднийх бидний хувцсыг хатаан, буурцагтай амтат ороомог өгч, бохир шалтай нэг өрөөндөө бидэнд ор засаж өгөв.

Биднийг өглөө сэрэхэд тэнгэр цэлмэг, нартай сайхан байлаа. Төөрсөн гурван хөвгүүнийг хайж ирсэн нэг хүн хаалга тогшлоо.

Харих замдаа харсан зүйлүүдээ би хэзээ ч мартаггүй. Олон хүн тэр шөнө биднийг хайсан байжээ. Биднийг тосгонд орж ирэхэд маш олон хүн биднийг хүлээж байлаа. Тэдний урд талд хайртай эмээ, авга, нагац нар маань байлаа. Тэд төөрсөн хүүхдүүдээ олсондоо магнай хагартлаа баярлаж, биднийг тэврэн, уйлж байв.

Энэ бол хайрт Тэнгэрлэг Эцэг минь биднийг нэг бүрчлэн мэддэг гэдгийг надад үргэлж сануулдаг гайхалтай сануулга юм. Тэр биднийг гэртээ эргэн ирэхийг сэтгэл зовнин хүлээдэг билээ. Бидний эргэн тойронд сүнсний шуурга шуурах төлөвтэй байна. Дээшээ харж, өдөр бүр гэрчлэлээ хүчирхэгжүүлэх замаар өөрсдийгөө бэлтгэцгээе. ■

# Гэр бүлээрээ нэг баг



*Хүн бүр нэгдэн тоглож байгаа үед хөгжих амархан.*

**Шэрали Харди**

Бодит түүхээс сэдэвлэв

*“Бид тусалж байхдаа аз жаргалтай байдаг” (Children’s Songbook, 198).*

**А**ммон аавтайгаа хамт хөл бөмбөгийн тэмцээнээс явах үедээ санаа алдаад, “Би нэг л зүйлийг ойлгохгүй байна” гэв. “Бидэнд маш олон сайн тоглогч байгаа. Гэтэл бид яагаад оноо авч чадахгүй байгаа юм бэ?”

Аав нь сайн хөл бөмбөгчин болохоор хариултыг нь хэлж өгч магадгүй.

Аав нь “Чи багаар ажиллахыг сурах хэрэгтэй гэж би бодож байна” гэж хэлэв. “Та нар бүгдээрээ гоол оруулахыг хүсэж байгаа биз дээ?”

Аммон “Тийм” гээд “Гэхдээ бид оноо авахын тулд бүгд нэг байж чадахгүй байна. Таны хэлэх гээд байгаа санаа энэ юм уу?” гэж хэлэв.

Аав нь толгой дохив. “Чи ганцаараа гоол оруулж чадахгүй. Эхлээд хамгаалагчид эсрэг багаас бөмбөгийг авах хэрэгтэй биз дээ?”

Аммон инээд алдан “Хэрэв бөмбөг байхгүй бол оноо авахад нэлээн хэцүү байх болно” гэв.

“Яг зөв” гэж аав нь хэлээд “Тэгээд хамгаалагчид бөмбөгийг оноо авч чадах хүнд дамжуулдаг. Хэн ч үүнийг ганцаараа хийж чадахгүй шүү дээ” гэлээ.

“Тийм байх л даа” гэж Аммон хэлэв.

Тэднийг гэртээ ирэхэд ээж нь нялх дүүг нь тэврэнгээ оройн хоолоо хийж байв. “Тэмцээн юу болсон бэ?” гэж тэр асуув.

“Бид дахиад л





хожигдчихсон. Гэхдээ бид дараагийн удаа сайн тоглоно” гэж Аммон хэлэв.

“Наадах чинь сайн хэрэг байна” гэж ээж нь хэллээ.

Самуэл, Люкас хоёрын хамт Мигуэл гүйн орж ирээд “Би өлсөж үхлээ!” гэж хашгирав.

“Хөвгүүд ээ, та нар ширээ засаж, тоглоомууд хураахад тусалж чадах уу?” гэж ээж нь асуув.

Дөрвөн хөвгүүн бүгд урвайлаа.

“Би энэ тоглоомуудаар тоглоогүй шүү дээ” гэж Самуэлыг хэлэхэд,

“Энэ чинь их удна шүү дээ!” гэж Мигуэл дуу алдав.

Аав нь инээд алдан, “Манай гэр бүлд Аммоны багт байгаатай адил асуудал байна гэж би бодож байна” гэлээ.

“Тэр чинь юу юм бэ?” гэж Самуэлыг асуухад

“Бид хамтдаа ажиллахгүй байгаа” гэж Аммон хэлээд “Бид бүгдээрээ оройн хоол идэж, оноо авахыг хүсэж байна. Гэхдээ бид бүх ажлаа ээжид үлдээгээд байна шүү дээ” гэв.

“Яг зөв!” гэж аав нь хэлэв. “Бид хэрхэн багаар

ажиллаж чадах вэ?”

Аммонд нэг санаа байлаа. “Самуэл бид хоёр ширээ засвал яаж байна? Бусад нь тоглоомуудыг хурааж болно шүү дээ.”

“Гайхалтай санаа байна!” гэж аав нь хэлэв.

Удалгүй оройн хоол бэлэн болов. Аммон залбирахаар гараа атгалаа. Гэр бүл нь багаар ажилласанд тэр баяртай байв. Хөл бөмбөгийн баг нь ч бас ингэж чадна гэж тэр найдаж байлаа. ■

*Зохиогч нь Канадын Альбертад амьдардаг.*



**Ахлагч**  
**М. Рассэлл**  
**Баллард**  
Арванхоёр  
Төлөөлөгчийн  
Чуулгын

## МЭХЛЭЛТ

**Н**амар бол уургаар загасчилдаг загасчдын хувьд онцгой сайхан үе юм. Учир нь энэ үед хулд загас хүнс ховорддог хахир өвөлд бэлтгэн, хүч тамираа нөөцлөхийн тулд ханахаа мэдэхгүй ховдоглон, хоол эрж явдаг.

Уургаар загасчилдаг загасчин хулд загасыг уран аргаар хуурч барьдаг. Чадамгай загасчин хулд загасны араншин, цаг агаарын байдал, усны урсгал, иддэг шавж зэргийг болон тэдгээр шавж нь авгалдайгаа хэзээ гаргадгийг ч нарийн судалдаг. Тэрбээр энэхүү өгөөшөө ихэнхдээ өөрөө хийдэг. Эдгээр хиймэл шавжны дотор маш жижигхэн дэргээ суулгах хэрэгтэй. Учир нь хулд загас өчүүхэн төдий сэжгийг ч андаггүй болохоор болхи өгөөшийг үмхдэггүй.

Хулд загас усан дээр үсрэн гарч ирээд, өгөөшийг залгин, эцсээ хүртэл тэмцэлдэж, бүр хөдөлж ч чадахгүй болоход нь суллан тавихыг харах нь тун сонин. Энэхүү тэмцэл нь овжин хулд загасны талаарх загасчны мэдлэг, ур чадвараас үүдэлтэй юм.

Загасыг хуурч барихад хиймэл өгөөш ашигладаг нь биднийг уруу татаж, хуурч мэхлэн, урхи занганд оруулдаг Люциферийн аргатай төстэй юм.



Хулд загасны цадахаа мэддэггүй ховдгийн гайг загасчин мэддэг шиг Люцифер бидний шунал буюу султалыг мэдэж, хуурамч өгөөшөөр биднийг уруу татаж, хэрэв амжилт олох юм бол бидний амар амгалан амьдралыг тасалдуулж, өршөөл энэрэлгүй нөлөөндөө оруулдаг. Харин загасыг бариад усанд нь буцааж тавьдаг загасчинтай адилгүй нь Люцифер урхидсан нэгнээ зүгээр тавиад явуулчихдаггүй. Түүний зорилго бол урхидсан нэгнээ эрхшээлдээ оруулж, өөр шигээ зовлонг болгох явдал мөн.

Бидний эсрэг түүний ашигладаг гол аргуудын нэг нь худал хэлж, хуурч мэхлэн, мууг сайн, сайныг муу гэж бидэнд итгүүлдэг чадвар

юм. Сатан Тэнгэрт болсон Их зөвлөгөөний бүр эхнээс “Бибээр Их Эзэн Бурхан мөн тэрчлэн түүнд өгсөн хүмүүний сонгох эрхийг эрэлхийлсэн юм” (Мосе 4:3) гэжээ.

Бурханаас хүнд соёрхсон сонгох эрхийн төлөө тэмцэл өнөөдөр ч үргэлжилж байна. Сатан болон түүний дагалдагчид биднийг бүдрүүлэх гэж хуурч мэхлэн барьж авахын тулд бидний эргэн тойронд өгөөшөө тавьж байна.

Ах, эгч нар аа, хуурамч өгөөшөөр хүмүүсийг ангуучилдаг Люциферийн хиймэл өгөөшөөс бүгдээрээ болгоомжилцгооё. Түүний санал болгодог аюултай олон зүйлийг ялган таньж, татгалзах мэргэн ухаан хийгээд сүнсний хүч чадалтай байцгаая.

Түүнчлэн ямар нэг донтолтод урхи дуулсан хүмүүст гарах гарц, найдвар бий шүү. Бурхан бүх хүүхдээ хайрладаг учраас мөн Есүс Христийн Цагаатгал болон хайр бүх зүйлийг боломжтой болгодог учраас ийм найдвар байгаа юм. ■

*“Ай тэр хилэнцэт нэгний зальт төлөвлөгөө,”*  
Лиахона, 2010 оны 11-р сар, 108–110-аас авав.



# ОЙЛГОЛТ




## Би өнөөдөр анхдагч мөн үү?

“Бид Солт Лэйкийн хөндийг явган туулсан анхдагчдыг хүндэлдэг ч өнөөдөр илүү олон анхдагч энд амьдарч байна. Тэд гар тэрэг түрдэггүй ч олон талаараа адилхан. Тэд Их Эзэний дуу хоолойг Мормоны Номоор болон хувийн залбирлаараа дамжуулан сонссон юм. Тэд итгэж, наманчлан, баптисмын усанд алхан орж, сайн мэдээний хөрсөнд хөлөө баттай суулгасан юм. Христийн шавь нарын хувьд тэд үнэн болоод зөв зүйлийн төлөө золиослол хийхэд бэлэн байсан. Тэд Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, мөнх амьдралд хүрэх замаар тууштай алхсаар байгаа билээ.”

# Энэ дугаарт

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



44

### Итгэдэг ЗҮЙЛИЙНХЭЭ ТӨЛӨӨ ЗОГСОХ НЬ

Таван залуу эсэргүүцлийг сөрөн, итгэлээ хэрхэн хамгаалсан тухайгаа хуваалцаж байна.

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

### Хэрхэн утга учиртай асуултууд асуух вэ

Хэрвээ та зөв ашиглаж чадвал асуултууд нь заах агуу хэрэгсэл байж болно. Энэхүү өгүүлэл танд үүнийг хэрхэн хийхийг заах болно.



54

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ



68

### Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт тавтай морилно уу

Бонни Л.Оскарсон эгч, түүний ач охин Матилдэ хоёр залуу эмэгтэйчүүдийн бүлэгт орохоосоо өмнө юу хүлээж болох талаар зарим санааг хуваалцаж байна.

